

АДБОУС 4200

Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Байгууллага
/ИНТОСАИ/ Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
/АДБОУС/-уудыг боловсрууллаа. Дэлгэрэнгүй мэдээллийг
www.issai.org цахим хуудаснаас авна уу.



Нийцлийн аудитын гарын авлага

*Санхүүгийн
тайлангийн
аудиттай хамаатай
нийцлийн аудит*

Өмнөх үг

Нийцлийн аудитын гарын авлага нь дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

1. АДБОУС 4000: Нийцлийн аудитын гарын авлагын ерөнхий танилцуулга
2. АДБОУС 4100: Санхүүгийн тайлангийн аудитаас тусдаа гүйцэтгэх нийцлийн аудитын гарын авлага. Үүнд гүйцэтгэлийн аудитын нэг хэсэг болгож гүйцэтгэх эсвэл бие даасан аудитын төрөл хамаарна.
3. АДБОУС 4200: Санхүүгийн тайлангийн аудиттай хамаатай нийцлийн аудитын гарын авлага

Агуулга

1. *Танилцуулга*
2. *Гарын авлагын хамрах хүрээ*
 - 2.1. Нийцлийн аудитын хамрах хүрээ ба мөн чанар
 - 2.2. Үндэслэлтэй ба хязгаарлагдмал баталгаажуулалтын харьцуулалт
 - 2.3. Батламж мэдэгдэлд суурилсан тайлагнал ба шууд тайлагналын харьцуулалт
3. *Хүрэх зорилго*
4. *Тодорхойлолтууд*
5. *Үндсэн анхаарах зүйлс*
 - 5.1. Ёс зүйн анхаарах зүйлс
 - 5.2. Чанарын хяналт
6. *Нийцлийн аудитыг төлөвлөх, зохиомжлох*
 - 6.1. Оролцогч талууд/хууль эрх зүйн үндсийг тодорхойлох
 - 6.2. Шалгах асуудал, түүний мэдээлэл
 - 6.3. Шалгуурууд
 - 6.4. Шалгагдагч байгууллага, түүний орчинг ойлгох нь
 - 6.5. Аудитын стратеги ба төлөвлөгөө
 - 6.6. Шалгагдагч байгууллагын дотоод хяналтыг ойлгох нь
 - 6.7. Материаллаг байдал
 - 6.8. Эрсдэлийн үнэлгээ
 - 6.8.1. Залилантай холбоотой эрсдэлийн үнэлгээний анхаарах зүйлс
 - 6.8.2. Төрийн байгууллагуудын хоорондох харилцаатай холбоотой эрсдэлийн үнэлгээний анхаарах зүйлс
 - 6.9. Аудитын горимуудыг төлөвлөх
7. *Нийцлийн аудитыг гүйцэтгэх ба нотлох зүйлсийг цуглуулах*
 - 7.1. Нотлох зүйлсийг цуглуулах ба үнэлэх
 - 7.1.1. Ажиглалт
 - 7.1.2. Шалгалт
 - 7.1.3. Асуулга
 - 7.1.4. Баталгаажуулалт

7.1.5. Дахин гүйцэтгэл

7.1.6. Шинжилгээний горимууд

7.2. Баримтжуулалт

7.3. Харилцаа холбоо

7.4. Сэжиг бүхий хууль бус үйлдлийг тайлагнахтай холбоотой анхаарах зүйлс

8. *Нотлох зүйлсийг үнэлэх ба дүгнэлт гаргах*

8.1. Нотлох зүйлсийг үнэлэх ба дүгнэлт гаргах талаар анхаарах ерөнхий зүйлс

8.2. Холбогдох албан тушаалтны бичгээрх мэдэгдэл

8.3. Хойшхи үйл явдал

9. *Тайлагнах*

9.1. Нийцлийн аудитын тайлангийн хэлбэр ба агуулга

9.1.1. Нийцлийн аудитын тайлангууд

9.1.2. Санхүүгийн тайлангийн аудиттай хамаатай нийцлийн аудитын тайлагнал

9.2. Аудитын мөрөөр арга хэмжээ авах үйл явц эцэслэх үйл явц

10. *Тооцооны Шүүхийн орчинд үйл ажиллагаа явуулдаг төрийн аудиторуудын нэмэлт удирдамж*

10.1. Тооцооны шүүхийн орчинд аудит хийх

10.2. Хуулийг мэдээлж, хэрэгжүүлэх мөрдүүлэх

10.3. Тооцооны шүүхийн янз бүрийн загвар дахь үйл явц

Хавсралт 1 – Нийцлийн аудитын шалгах асуудал, түүний мэдээлэл ба шалгууруудын жишээ

Хавсралт 1-А- Санхүүгийн тайлангийн аудиттай хамтад нь гүйцэтгэх нийцлийн аудитын шалгууруудын жишээ

Хавсралт 2 – Шалгаагдагч байгууллагын талаар ойлголт олж авах ба зохистой шалгууруудыг тогтооход ашиглах эх сурвалжуудын жишээ

Хавсралт 3 – Нийцлийн аудит дахь эрсдэлийг үнэлэхтэй холбоотой хүчин зүйлүүдийн жишээ

Хавсралт 4 – Тодорхой шалгах асуудалтай холбоотой эрсдэлийн хүчин зүйлүүдийн жишээ

Хавсралт 5 – Сонгосон шалгах асуудлуудад ашиглах нийцлийн аудитын горимуудын жишээ

Хавсралт 6 – Нийцлийн хэлбэлзлийн жишээ

Хавсралт 7 – Санхүүгийн тайлангийн талаарх Аудиторын тайлангийн нэг хэсэг болох нийцлийн аудитын санал дүгнэлтийн жишээ

Хавсралт 8 - Нийцлийн талаарх хязгаарлалттай дүгнэлтийн жишээ

Хавсралт 9 – Нийцлийн талаарх сөрөг дүгнэлтийн жишээ

Хавсралт 10 – Нийцлийн талаарх татгалзсан дүгнэлтийн жишээ

Хавсралт 11 - Онцлох асуудал ба бусад онцлох асуудал зүйлийн жишээ

Хавсралт 12 – Санхүүгийн тайлангийн талаар үндэслэлтэй баталгаажуулалтын дүгнэлттэй ба нийцлийн талаар хязгаарлагдмал баталгаажуулалтын дүгнэлттэй санхүүгийн тайлангийн талаарх аудитын тайлангийн жишээ

1 Танилцуулга


1. ИНТОСАИ-н Лимагийн тунхаглалд төрийн аудитын зорилгыг “Нийтийн мөнгийг захиран зарцуулах нь итгэл дээр тулгуурладаг учир аудитын үзэл баримтлал, тогтолцоо нь төрийн санхүүгийн удирдлагад агуулагдаж байдаг. Аудит нь өөрөө эцсийн зорилго биш, харин зохицуулалтын тогтолцооны салшгүй хэсэг бөгөөд түүний зорилго нь тогтсон стандартаас гажсан, хууль ёс, санхүүгийн удирдлагын үр ашигтай, үр нөлөөтэй, арвигч хямгач байдлын зарчмыг зөрчсөн тохиолдлыг аль болох эрт илрүүлэн засаж залруулах боломж олгох, зарим тохиолдолд, холбогдох этгээдэд хариуцлага хүлээлгэх, хохирлыг барагдуулах иймэрхүү зөрчлөөс урьдчилан сэргийлэх буюу наад зах нь түүнийг багасгах арга хэмжээ авах явдал юм” гэж тодорхойлдог ба үүнд нийцлийн аудит хамаарна.
2. Нийцлийн аудит нь шалгагдагч байгууллагын дүрэм журам, хууль тогтоомж, бодлого, тогтоосон дүрэм, гэрээний нөхцөл, эсвэл санхүүжилтийн хэлэлцээрийн нөхцөл зэрэг тохиролцсон нөхцөлүүдийг дагаж мөрдөх хэр хэмжээний асуудлыг зохицуулна. Нийцлийн аудитын тухай ойлголт нь ИНТОСАИ-н Аудитын үндсэн зарчмуудад (АДБОУС 100.38 ба 39) тусгагдсан байдаг. Энэ талаар АДБОУС 4000 – Нийцлийн аудитын гарын авлагын танилцуулгад дэлгэрэнгүй тайлбарласан.
3. Төрийн салбарт ил тод байдал, хариуцлага болон сайн засаглалын ухагдахуунууд нь үндсэн чухал зарчмууд юм. Төрийн байгууллагууд иргэдийн төлөө ямар үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа, эдгээр үйл ажиллагаанд ямар нэг хязгаар байгаа эсэх, хүрэхээр зорьж буй нэгдсэн зорилт болон иргэн бүрийн хуулиар тогтоосон эрхийг хэрхэн хамгаалах талаар хууль тогтоомжинд тусгаж болно. Түүнчлэн төрийн байгууллагууд нийтийн хөрөнгийг зүй зохистой удирдах үүрэг хүлээдэг. Төрийн байгууллагууд болон тэдгээрийн томилогдсон албан тушаалтнууд өөрсдийн үйл ажиллагаагаа ил тод байлгах, ард түмний хариуцуулсан хөрөнгийг сайн зохион байгуулах ба хариуцах чадвартай байх үүрэг хүлээнэ.
4. Төрийн байгууллагууд үйл ажиллагаагаа холбогдох эрх бүхий байгууллагын хууль тогтоомж, дүрэм журмын дагуу явуулах, ард иргэдийн хуулиар тогтоосон эрхийг хамгаалах зэрэг асуудлуудад хяналт тавих нь төрийн хяналтын чухал чиг үүрэг юм. Ерөнхийдөө төрийн аудитаар, ялангуяа нийцлийн аудитаар, дээр дурьдсан үндсэн зарчмуудыг дагаж мөрдөж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавихад төрийн аудиторүүд туслалцаа үзүүлдэг. Нийцлийн аудитын хүрээнд тухайлсан асуудалтай холбоотой мэдээлэл бүх материаллаг асуудлаар холбогдох хууль тогтоомж, заавар журам, ба гэрээ, хэлэлцээрийн нөхцөлүүд гэх мэт холбогдох шалгууруудтай нийцэж байгаа эсэхийг тодорхойлох нь энэ үүрэг хариуцлагад багтана. Аудитын үр дүнг шалгагдсан байгууллага болон хууль тогтоох байгууллагад тайлагнана. Мөн түүнчлэн төрийн салбар дахь хариуцлага

ба ил тод байдлыг дэмжих зорилгоор аудитын үр дүнг олон нийтэд нээлттэй болгоно.

5. Энэ гарын авлага нь ихэнх улс оронд өөр өөр бүрэн эрх, зорилтоор зохицуулагддаг төрийн салбар дахь нийцлийн аудитын асуудлыг авч үзнэ. Ардчилсан төрийн тогтолцоонд олон нийтийн, ялангуяа томилогдсон төлөөлөгчдийн өмнө хүлээх хариуцлага төрийн байгууллагын удирдлагын хамгийн чухал асуудал бөгөөд сайн засаглалын үндсэн элемент байдаг. Төрийн байгууллагууд ихэвчлэн хууль тогтоомжийн дагуу байгуулагддаг бөгөөд тэдгээрийн үйл ажиллагааг хууль тогтоомжоос үүсэн бий болсон олон төрлийн эрх бүхий байгууллага удирддаг. Төрийн байгууллагын үйл ажиллагаа холбогдох хууль тогтоомж болон бусад эрх бүхий байгууллагуудын заавар журмын дагуу явагдаж байгаа эсэх дээр тухайн байгууллагын удирдлага хариуцлага хүлээнэ. Төрийн байгууллагуудын төсвийн хөрөнгийг нэмэгдүүлэх, зарцуулах үйл ажиллагаанд хууль тогтоогчид хяналт тавих үндсэн арга нь хууль тогтоомж ба бусад эрх бүхий байгууллага учир тэдгээрийн үйл ажиллагаа холбогдох эрх бүхий байгууллагын хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэхэд аудит хийх нь ихэвчлэн аудитын бүрэн эрх, эсвэл ажил үүргийн удирдамж ялангуяа төрийн байгууллагын аудитын чухал бөгөөд салшгүй хэсэг юм. Олон төрлийн эрх бүхий байгууллагууд байдаг учраас тэдгээрийн шаардлагууд нэг нэгэнтэйгээ зөрчилдөж болох ба тайлбар нь ялгаатай байж болно. Түүнчлэн тэдгээрийн харьяа эрх бүхий байгууллагуудын үйл ажиллагаа хуулиар тогтоосон хязгаар эсвэл чиглэлтэй нийцэхгүй байж болно. Үүнээс хамааран төрийн салбарын үйл ажиллагаа эрх бүхий байгууллагатай нийцэж байгаа эсэхийг үнэлэхэд ихээхэн хэмжээний мэргэжлийн үнэлэмж шаардлагатай ба энэ нь маш чухал юм.
6. Энэ гарын авлага нь (Санхүүгийн тайлангийн аудиттай хамааралтай нийцлийн аудитын АДБОУС 4200) санхүүгийн тайлангийн аудиттай хамт гүйцэтгэдэг нийцлийн аудитын нөхцөл байдлуудыг хамарна. Энэ нь ИНТОСАИ-ын Аудитын үндсэн зарчмууд (энэ баримт бичигт АДБОУС 100 – АДБОУС 400-аар лавлагаа болж орсон, өмнө нь “ИНТОСАИ-н Аудитын стандартууд” гэх) дээр үндэслэсэн ба төрийн салбарын аудиторууд болон АДБ-уудад эдгээр зарчмуудыг ашиглахад туслалцаа үзүүлэх зорилгоор боловсруулагдсан. Энэ гарын авлага нь нэмэлт материал бөгөөд үүнийг ИНТОСАИ-н Санхүүгийн аудитын гарын авлага (АДБОУС 1000-2999, энэ баримт бичигт “Санхүүгийн аудитын гарын авлага” гэх)-тай хамт хэрэглэнэ.
7. Санхүүгийн аудитын гарын авлагатай хамт ашиглахад энэхүү гарын авлага нь төрийн салбарын санхүүгийн тайлангийн аудитын иж бүрэн зааварчилгаагаар төрийн аудиторыг хангахыг зорьсон.

8. Нийцлийн аудитыг гүйцэтгэх үйл явцыг ерөнхийд нь дараах диаграммаар харуулсан ба гарын авлагын дараагийн хэсгүүдэд тайлбарласан.

Нийцлийн аудитын үйл явц



2 Гарын авлагын хамрах хүрээ

2.1 Нийцлийн аудитын хамрах хүрээ ба мөн чанар

9. Ерөнхийдөө АДБ-ын бүрэн эрх нь тухайн АДБ нийцлийн аудитыг гүйцэтгэж байгаа эсэхийг тодорхойлдог. Нийцлийн аудитыг гүйцэтгэхэд гүйцэтгэх ажлын хамрах хүрээ, мөн чанар болон аудитын зохистой арга хандлагыг тодорхойлох үүргийг ихэвчлэн АДБ хүлээдэг. Зарим тохиолдолд парламент зэрэг хууль тогтоох байгууллага тодорхой нэг төрлийн аудитыг гүйцэтгүүлэхээр АДБ-д хүсэлт тавьж болно. Аудиторын хараат бус байдалд эрсдэл гарахгүй тохиолдолд ийм хүсэлтийг хүлээн зөвшөөрч болно. (АДБОУС 200, 2.2.16) Гэхдээ АДБ өөрсдийн ашиглах аудитын зохистой арга хандлага ба арга зүйг тодорхойлох шаардлагатай.
10. Нийцлийн аудитын шалгах асуудлууд өргөн хүрээтэй бөгөөд нэг аудитаас нөгөө аудитад харилцан адилгүй байж болно. Шалгах асуудал мөн чанарын хувьд ерөнхий эсвэл илүү нарийвчилсан байж болно. Нийцлийн аудитын шалгах асуудлын дэлгэрэнгүй удирдамжийг 6.2 дугаар хэсэгт тусгасан.
11. Аудитын үндсэн зарчмуудад засгийн газрын агентлагууд, хөтөлбөр болон үйл ажиллагаа нь ихэвчлэн тодорхой хууль тогтоомжийн үр дүн байдаг учраас нийцлийн аудит чухал гэж тайлбарладаг. Холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөж байгаа эсэх, хүссэн үр дүндээ хүрсэн эсэх хэрэв үгүй бол ямар засвар залруулга шаардлагатай байгаа зэргийг шийдвэр гаргагчид мэдэх хэрэгтэй (АДБОУС 300, 3.4.2). Шалгагдагч байгууллагад хамаарах хууль тогтоомж болон бусад нийцлийн шаардлагууд аудитыг бие даасан аудитын төрлөөр эсвэл гүйцэтгэлийн аудит эсвэл санхүүгийн тайлангийн аудиттай хамааралтай гүйцэтгэх эсэх зэрэг тухайн аудитын зорилтуудад ач холбогдолтойд тооцогдоно. Тиймээс төрийн аудиторууд холбогдох талуудыг бүтээлч тайлангаар хангах боломжийг олгох хамрах хүрээ ба мөн чанартай ажлыг төлөвлөж, гүйцэтгэнэ.
12. Зарим тохиолдолд тодорхой нийцлийн аудитын шалгах асуудал ба хамрах хүрээг аудитын бүрэн эрхэд тусгасан байж болно. Бусад тохиолдлуудад нийцлийн аудитын шалгах асуудал ба хамрах хүрээ төрийн аудиторын мэргэжлийн үнэлэмж дээр үндэслэнэ. Аудитын шалгах асуудал ба хамрах хүрээг төрийн аудиторууд тодорхойлоход нөлөөлөх хүчин зүйлсдэд дараах зүйлс орно. Үүнд:
 - А) Төсвийн эсвэл худалдан авалтын тухай хууль зэрэг холбогдох хууль тогтоомж эсвэл аудитын бүрэн эрхэд тусгагдсан шаардлагууд
 - Б) Тухайн байгууллагын өмнөх зөрчлийн тохиолдлууд, жишээлбэл өмнөх аудитаар тогтоосон зөрчлүүд
 - В) АДБ-аас гадуурх аудиторын хийсэн аудитын дүгнэлт ба зөвлөмж

- Г) Зөрчил байх эрсдэлтэй тодорхой хамрах хүрээг илэрхийлсэн санхүүгийн эсвэл гүйцэтгэлийн аудиттай холбоотойгоор гүйцэтгэсэн эрсдэлийн үнэлгээ (жишээлбэл, салбаруудын худалдан авалт эсвэл томоохон салбарын орлого бүрдүүлэлт, батлан хамгаалалт, нийгмийн халамж гэх мэт тусгай хөтөлбөрийн хамрах хүрээ)
- Д) Олон нийтийн ашиг сонирхол эсвэл хүлээлт (жишээлбэл, хэвлэл мэдээллийнхний тогтоосон сэжиг бүхий залилан, буруу удирдлага эсвэл зөрчлийн асуудлууд)
- Е) Хууль тогтоох байгууллагын анхаарлын төвд байгаа тодорхой асуудлууд (жишээлбэл, байгаль орчны асуудлууд ба олон улсын байгаль орчны гэрээ хэлэлцээрийн нийцэл)
- Ё) Хууль тогтоох байгууллага, санхүүжүүлэгч агентлагууд эсвэл хандивлагч байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтүүд (жишээлбэл, санхүүжилтийн гэрээ хэлэлцээрийн нөхцөлүүдийн нийцэл)
- Ж) Тухайн байгууллага хандивлагч байгууллагуудаас ихээхэн хэмжээний санхүүжилт авсан ба санхүүжилтээр тасралтгүй хангах нь гэрээ, хэлэлцээрийн нөхцөлүүдтэй нийцэж байх

13. Нийцлийн аудитын хамрах хүрээ ба мөн чанар нь аудитын бүрэн эрх эсвэл холбогдох хууль тогтоомж бус харин төрийн аудиторын мэргэжлийн үнэлэмж дээр үндэслэсэн тохиолдолд аудитын хамрах хүрээ ба мөн чанарын талаар шалгагдагч байгууллагад бичгээр мэдэгдэх шаардлагатай байж болно. Ингэснээр аудитаар юуг хамрах ба тодорхой нэг хязгаар байгаа эсэх, хангах мэдээлэл, хэнд, хэзээ ямар төрлийн тайланг гаргаж өгөх зэрэг асуудлууд болон янз бүрийн талуудын үүрэг хариуцлагуудын талаарх ойлголтыг илүү ойлгомжтой болгоход туслах юм.

14. Энэхүү баримт бичигт тусгагдсан “нийцлийн аудит” гэдэг нэр томъёог АДБ-уудын гүйцэтгэх эсвэл хариуцаж буй ажлын хүрээнд ойлгоно.

15. Энэ гарын авлагын зорилгын хүрээнд нийцлийн аудит ба нийцлийн тайлагналыг санхүүгийн тайлангийн аудиттай хамааралтай гэж дараах тохиолдолд үзнэ. Үүнд:

- А) Нийцлийн талаарх аудитын дүгнэлт нь санхүүгийн тайлангийн аудитын талаарх аудиторын тайлангийн нэг хэсгийг бүрдүүлж байгаа, эсвэл
- Б) Санхүүгийн тайланд хууль тогтоомжийн нийцлийг тусгахын шаарддаг санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу санхүүгийн тайланг бэлтгэсэн.

16. АДБ-уудын өргөтгөсөн бүрэн эрхээс хамааран төрийн салбар дахь санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх аудиторын хамрах хүрээ болон зорилтууд нь Хараат

бус аудиторын үндсэн зорилго ба аудитыг Аудитын олон улсын стандартын дагуу гүйцэтгэх тухай АОУС 200-д (Шинэчилсэн найруулга) зааснаас ерөнхийдөө өргөн хүрээтэй байна. Санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх аудиторын үндсэн зорилтуудыг АОУС 200-д дараах байдлаар заасан байдаг. Үүнд:

- А) Санхүүгийн тайлан нь залилан болон алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй нотолгоог олж авах, ингэснээр аудитор уг санхүүгийн тайлан бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэгдсэн эсэх талаар санал дүгнэлтээ илэрхийлэх боломжтой байх.
- Б) Санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт тайлан гаргах ба АОУС-д заасанчлан аудиторын илрүүлсэн зүйлсийг хэрэглэгчдэд мэдээлэх.

17. Төрийн салбар дахь нийцлийн аудитын хамрах хүрээ нь Санхүүгийн тайлангийн аудитад хууль тогтоомж, дүрэм журмыг анхаарах тухай шинэчлэн найруулсан АОУС 250-д зааснаас ихэвчлэн өргөн хүрээтэй байдаг. АОУС 250-д тусгасан Аудиторын зорилго нь дараах гурван хэсэгтэй. Үүнд:

- А) Санхүүгийн тайлан дахь материаллаг дүнгүүд, нэмэлт тодруулгуудыг тодорхойлоход шууд нөлөө үзүүлэх нийтээр хүлээн зөвшөөрсөн хууль тогтоомж, дүрэм журмын заалтуудыг мөрдсөн эсэх тухайд хангалттай ба зохистой аудитын нотолгоо олж авах;
- Б) Санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэх тэдгээр хууль тогтоомж, дүрэм журмыг зөрчсөн тохиолдлуудыг илрүүлэхэд туслах зорилгоор энд тодорхойлсон аудитын горимуудыг гүйцэтгэх; ба
- В) Аудитын явцад илэрсэн хууль тогтоомж, дүрэм журмын зөрчил эсвэл сэжиг бүхий зөрчилд зохистой хариу үйлдэл үзүүлэхэд оршино.

18. Аудитын хамрах хүрээ ба мөн чанарын талаар байгууллагуудад мэдэгдэх тухай нэмэлт удирдамжийг дараах баримт бичгүүдээс харж болно. Үүнд:

- АДБОУС
- 1210 ба 1300
- ИНТОСАИ-н Гүйцэтгэлийн аудитыг гүйцэтгэх гарын авлагын 2.3-р хэсэг – Холбогдох байгууллагуудад зүй ёсоор мэдээлэх ёстой
- НБОУХ-ны Баталгаажуулалтын гэрээт ажлын олон улсын стандарт (БГАОУС) 3000

2.2 Үндэслэлтэй ба хязгаарлагдмал баталгаажуулалтын харьцуулалт

19. Нийцэлтэй холбоотой Аудитын Үндсэн зарчмуудад аудитын зорилгод ихээхэн хэмжээгээр нөлөөлж болох алдаа, зөрчил дутагдал ба хууль бус үйлдлийг олж

илрүүлэх үндэслэлтэй баталгаажуулалтаар хангахаар аудитыг зохион байгуулах ёстой (АДБОУС 300, 3.4.1) гэж заасан байдаг.

20. Ихэнх төрлийн гэрээт ажлын хувьд үндэслэлтэй (эерэг) баталгаажуулалт ба хязгаарлагдмал (сөрөг) баталгаажуулалт гэсэн баталгаажуулалтын түвшний хоёр төрөл байдаг. Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшний боловч бүрэн төгс баталгаажуулалт биш юм. Аудитын уламжлалт хязгаарлалтуудаас (доор дурдсан эрсдэлийн үнэлгээ хэсгийг харна уу) шалтгаалан аудит нь ихэвчлэн 100 хувь баталгаажуулалтаар хангадаггүй. Ерөнхийдөө үндэслэлтэй баталгаажуулалтын аудит нь “бидний саналаар шалгах асуудал нь бүх материаллаг байдлаар тогтоосон шалгууруудтай нийцсэн/ нийцээгүй байна” гэсэн дүгнэлтийг эерэг хэлбэрээр илэрхийлэхэд чиглэгдсэн. Хязгаарлагдмал баталгаажуулалтын ажлыг аудит гэж үзэхгүй харин илүү нягтлах түвшний гэрээт ажил юм. Энэ нь аудитаас доогуур түвшний баталгаажуулалтаар хангадаг ба “шалгах асуудал нь бүх материаллаг байдлаар шалгууруудтай нийцэхгүй байгааг илтгэсэн юу ч бидний анхаарлыг татсангүй” гэх мэтчилэн дүгнэлтийг сөрөг хэлбэрээр илэрхийлэхэд чиглэгдсэн.
21. Үндэслэлтэй баталгаажуулалтын аудит ба хязгаарлагдмал баталгаажуулалтын хяналтын аль алинд нь шалгах асуудлыг ойлгох болон төрийн аудиторын дүгнэлтийг дэмжих хангалттай, зохистой нотолгоог олж авах үйл явц багтдаг. Үндэслэлтэй баталгаажуулалтын аудитад эрсдэлийг үнэлэх, үнэлсэн эрсдэлд хариулт өгөх аудитын горимуудыг гүйцэтгэх, ба олж авсан нотлох зүйлсийн хангалттай, зохистой байдалд үнэлгээ өгөх зэрэг үйл явц хамаарна. Хязгаарлагдмал баталгаажуулалтын хяналтын явцад ашиглагдах горимууд нь ихэвчлэн шинжилгээний горимууд болон асуулгаар хязгаарлагддаг. Үндэслэлтэй баталгаажуулалтын аудит болон хязгаарлагдмал баталгаажуулалтын хяналтын явцад гүйцэтгэх горимын төрөл, хугацаа ба хэмжээг мэргэжлийн үнэлэмж гаргаж буй төрийн аудиторууд тодорхойлно. Хязгаарлагдмал баталгаажуулалтын хяналт нь хэд хэдэн байгууллагуудыг хамарсан буюу тодорхой нэг байгууллага дахь шалгах асуудлуудаас илүү нарийн төвөгтэй асуудлуудыг багтаасан шалгах асуудлуудад илүү тохиромжтой байж болох юм.
22. Энэ гарын авлага нь үндэслэлтэй баталгаажуулалтын аудитын хүрээнд боловсруулагдсан. Санхүүгийн тайлангийн аудиттай хамт гүйцэтгэх нийцлийн аудитын үед энэ гарын авлага нь байгууллагын хууль тогтоомжийн нийцлийн талаар үндэслэлтэй баталгаажуулалтын дүгнэлтийн хэлбэрээр тайлагнахад төрийн аудиторуудыг удирдамжаар хангадаг.
23. Нийцлийн талаарх хязгаарлагдмал хяналтыг санхүүгийн тайлангийн үндэслэлтэй баталгаажуулалтын аудиттай хослуулан гүйцэтгэх тохиолдолд аудиторын өөр үүрэг хариуцлагыг тодорхой тайлбарласан байх ёстой.

2.3 Батламж мэдэгдэлд суурилсан тайлагнал ба шууд тайлагналын харьцуулалт

24. Зарим тохиолдолд шалгагдагч байгууллагын удирдлага тусгай батламж эсвэл нийцлийн мэдэгдлийг бэлтгэж болно. Бусад тохиолдлуудад батламж мэдэгдэл нь шууд бус байж болох юм.
25. Жишээлбэл, санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага санхүүгийн тайлан нь Улсын салбарын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (ТСНББОУС) эсвэл тухайн улс орны нийтээр хүлээн зөвшөөрсөн нягтлан бодох бүртгэлийн стандартууд гэх мэт холбогдох санхүүгийн тайлангийн үзэл баримтлалын дагуу бэлтгэгдсэн бөгөөд хөрөнгө байгаа, тэдгээрийг байгууллага эзэмшиж байгаа ба үнэн зөв үнэлсэн гэсэн шууд бус санхүүгийн тайлагналын батламж мэдэгдлийг гаргадаг. Үүний нэгэн адил удирдлага хууль тогтоомжийн нийцэлтэй холбоотой шууд бус батламж мэдэгдлийг гаргаж болно.
26. Төрийн аудитын явцад шалгагдагч байгууллага хэрэглэгчдийг хангах тусгай батламж эсвэл нийцлийн талаарх мэдэгдэл ихэнхдээ байдаггүй. Харин шалгах асуудлын мэдээлэл нь аудиторын тайланд мэдээллийн хэлбэрээр эсвэл дүгнэлтийн хэлбэртэй шууд мэдэгдлээр орсон байдаг. Ийм төрлийн аудитыг шууд тайлагналын аудит гэж нэрлэнэ. Аудитын илрүүлэлтийг шалгагдсан байгууллага ба хууль тогтоох байгууллага зэрэг холбогдох талуудад зохистой аргаар тайлагнадаг. Тайланг ихэвчлэн олон нийтэд нээлттэй болгоно.
27. Тайлагналын хэлбэр нь зорилтот хэрэглэгчдэд хамгийн үр өгөөжтэйгээр хэрхэн хүргэх талаар аудиторын гаргасан мэргэжлийн үнэлэмжээс шалтгаалан харилцан адилгүй байж болох юм. Тайлан нь товч эсвэл дэлгэрэнгүй хэлбэртэй байж болно. Тайлагналын талаар дэлгэрэнгүй удирдамж энэ баримт бичгийн тайлагналын хэсэгт тусгагдсан.
28. Энэ гарын авлага нь шууд тайлагналын аудит дээр үндэслэн боловсруулагдсан боловч тохиромжтой бол батламж мэдэгдэлд суурилсан тайлагналд ашиглаж болно.

3 Хүрэх зорилго

29. Дээр дурьдсанчлан, АОУС 200.11-д (Шинэчилсэн найруулга) санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх аудиторын зорилго нь санхүүгийн тайлан нь залилан болон алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй нотолгоог олж авах, ингэснээр аудитор уг санхүүгийн тайлан бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэгдсэн эсэх талаар санал дүгнэлтээ илэрхийлэх боломжтой байх ба аудиторын илрүүлсэн зүйлсийн дагуу мэдээлэх ба тайлагнах гэж тайлбарласан байдаг.

30. АДБ-ын бүрэн эрх ба үндсэн хуулиарх үүргээс хамааран санхүүгийн тайлангийн аудиттай хамаатай нийцлийн аудитыг гүйцэтгэх төрийн аудиторын үндсэн зорилго нь:

А) Санхүүгийн тайланд тусгагдсан үйл ажиллагаа, санхүүгийн ажил гүйлгээ ба мэдээлэл нь бүх материаллаг байдлаар тэднийг удирддаг эрх бүхий байгууллагын хууль тогтоомжтой нийцсэн эсэх талаар үндэслэлтэй нотолгоог олж авах, ба

Б) Холбогдох хууль тогтоох ба/эсвэл бусад байгууллагуудад илрүүлэлтүүд ба дүгнэлтийг тайлагнах

31. Тооцооны Шүүхийн тогтолцоог төлөөлж буй АДБ-уудын хувьд, зорилт нь мөн холбогдох байгууллагуудад нийцлийн хэлбэлзлийн талаар мэдээлэх эсвэл хариуцлага хүлээх эрх бүхий байгууллага/агентлагийг тодорхойлох ба болзошгүй зөрчлийг тогтоох зэрэг шүүхийн шүүх чиг үүрэгтэй холбоотой албан ёсны дүгнэлтэд хүргэх үйл явцыг эхлүүлэх юм.

4 Тодорхойлолтууд

32. Энэхүү гарын авлагын хүрээнд дараах нэр томъёонуудыг дор дурдсан утгаар ойлгоно.

1. **Батламж мэдэгдэл** - Аудитор нь байж болох олон төрлийн нийцлийн хэлбэлзлүүдийг авч үзэхдээ ашиглах шалгагдагч байгууллагатай хамаарах үйл ажиллагаа, санхүүгийн ажил гүйлгээ ба мэдээлэлд тусгагдсан шууд эсвэл шууд бус илэрхийллүүд. Нийцлийн аудитын хүрээнд нийцлийн батламж мэдэгдэл гэдэг нь тухайн байгууллага, түүний дотор хариуцлага хүлээх төрийн албан тушаалтан холбогдох хууль тогтоомжийн дагуу (Зүй зохистой байдлын аудитад – холбогдох олон нийтийн хүлээлт) үйл ажиллагаагаа явуулж гэсэн утгыг илэрхийлнэ. Батламж мэдэгдлүүд нь шалгагдагч байгууллагаас танилцуулсан шалгах асуудлын мэдээлэлд эсвэл удирдлагын төлөөллийн захидалд шууд тусгагдаж болно.
2. **Хууль тогтоомж (Authorities)** - Шалгагдагч байгууллагын дагаж мөрдөх ёстой хууль тогтоох байгууллагын холбогдох хууль тогтоомж эсвэл тогтоол эсвэл хууль тогтоомжоор эрх олгогдсон төрийн байгууллагаас гаргасан бусад хуулиар тогтоосон хэрэглүүр, заавар ба удирдамж. Эдгээр элементүүдийг нэгтгэн заримдаа “хууль тогтоох байгууллагаас гаргасан хууль тогтоомж” эсвэл зөвхөн “хууль тогтоомж” гэж нэрлэдэг. Үүнийг “хууль сахиулах байгууллага” эсвэл “захиргааны байгууллага” зэрэг эрх мэдэл эсвэл тушаал хэрэгжүүлж буй байгууллага эсвэл хүн гэсэн утгатай “эрх бүхий байгууллага/хүн” гэдэг ойлголттой андуурч болохгүй. Ийм байгууллага эсвэл хүмүүс гэсэн утгаар

хэрэглэх тохиолдолд “Хууль хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага”, “захиргааны эрх бүхий байгууллага” гэж тусгайлан нэрлэнэ.

3. **Нийцлийн аудит** - Нийцлийн аудит нь шалгагдагч байгууллагын дүрэм журам, хууль тогтоомж, бодлого, тогтоосон дүрэм, гэрээний нөхцөл эсвэл санхүүжилтийн хэлэлцээрийн нөхцөл зэрэг тохиролцсон нөхцөлүүдийг дагаж мөрдөх хэм хэмжээний асуудлыг зохицуулна. Нийцлийн аудит нь өргөн хүрээтэй шалгах асуудлыг хамарч болно. Ерөнхийдөө нийцлийн аудитын зорилго нь зохистой шалгуурын дагуу шалгах асуудалд хийсэн үнэлгээ эсвэл хэмжилтийн үр дүнгийн талаар зорилтот хэрэглэгчдийг баталгаажуулалтаар хангах юм.

ИНТОСАИ-н Аудитын үндсэн зарчмуудын хүрээнд нийцлийн аудитыг гүйцэтгэхэд дараах хоёр ухагдахуун чухал ач холбогдолтой. Үүнд:

- А) **Үнэн зөв байдал (Regularity)** – Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайланд тусгагдсан үйл ажиллагаа, ажил гүйлгээ ба мэдээлэл нь удирдлага болгодог хууль тогтоомж, бусад холбогдох хууль тогтоомж, гэрээ хэлэлцээр түүний дотор төсвийн тухай хуулийн дагуу гаргасан хууль тогтоомжууд ба дүрэм журмуудтай нийцсэн ба зүй ёсоор зөвшөөрөгдсөн тухай ухагдахуун
- Б) **Зүй зохистой байдал (Propriety)**– Төрийн салбарын санхүүгийн сайн удирдлага ба төрийн албан тушаалтнуудын зан байдлын ерөнхий зарчмууд

АДБ-ын бүрэн эрхээс хамааран нийцлийн аудит нь үнэн зөв байдлын эсвэл зүй зохистой байдлын эсвэл аль алиныг нь хамарсан аудит байж болно.

Зүй зохистой байдлыг бодитой тодорхойлох амархан биш учраас үндэслэлтэй баталгаажуулалтын түвшинд хүртэл зүй зохистой байдалд аудит хийх нь хүндрэлтэй, зарим тохиолдолд бүр боломжгүй байж болно. Зүй зохистой байдлыг хэмжих тодорхой, бодитой жишиг үзүүлэлтүүд ихэвчлэн байдаггүй – төрийн салбарын нэг хэсэгт ашиглаж болох жишиг үзүүлэлтүүд өөр газарт ашиглаж боломжгүй байж болно.

АДБ-ууд зүй зохистой байдалд аудит хийх бүрэн эрхтэй ч эхэндээ шалгуурууд нь ойлгомжтой тодорхойлогдоогүй байж болох юм. Зохистой шалгуурын талаарх асуудлыг энэ баримт бичгийн дараагийн хэсгүүдэд дэлгэрэнгүй авч үзнэ. Аудитын бүрэн эрхээр зүй зохистой байдлын аудитыг шаардаж буй нөхцөлд энэ гарын авлагад тусгасан зарчмуудыг тохиромжтой нөхцөл байдалд ашиглаж болох юм. Зүй зохистой байдлын талаарх тайлангийн хэлбэр ба

агуулга АДБ-ын бүрэн эрх болон тухайлсан нөхцөл байдлаас хамааран харилцан адилгүй байж болно.

4. **Нийцлийн хэлбэлзэл** - шалгагдагч байгууллага дараах зүйлсийг дагаж мөрдөөгүй. Үүнд:
 - А) Хууль тогтоомж – Үнэн зөв байдлын нийцлийн аудит
 - Б) Төрийн салбарын санхүүгийн сайн удирдлагын ба төрийн албан тушаалтнуудын зан байдлын ерөнхий зарчмууд – зүй зохистой байдлын нийцлийн аудит
5. **Дүгнэлт** – Шалгах асуудлын нийцлийн талаарх аудиторын тайлан нь ихэвчлэн гүйцэтгэсэн аудитын ажил дээр үндэслэсэн дүгнэлтийг агуулсан байдаг. Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хамтран гүйцэтгэх үед дүгнэлт нь санал дүгнэлтийн (“Санал дүгнэлт”-г харна уу) хэлбэртэй байж болно. Дүгнэлтийг мөн аудитын тодорхой асуултуудад илүү дэлгэрэнгүй хариулт өгөх аргаар илэрхийлж болно.
6. **Хууль тогтоох байгууллага** – Улсын хууль гаргах эрх бүхий байгууллага, жишээлбэл, парламент. Нийцлийн аудитын хүрээнд хууль тогтоох байгууллага гэдэгт төсвийн тухай хууль тогтоомж эсвэл тогтоол гаргах эрх бүхий төрийн бусад байгууллагууд мөн багтаж болно.
7. **Санал дүгнэлт** – Санхүүгийн тайлангийн талаарх аудиторын тайланд санхүүгийн тайлангийн талаарх санал дүгнэлтийн зэрэгцээ нийцлийн талаарх санал дүгнэлтийг бичгээр ойлгомжтой тусгасан байж болно. Аудитор шалгагдагч байгууллагын санхүүгийн тайланд тусгагдсан үйл ажиллагаа, санхүүгийн ажил гүйлгээ ба мэдээлэл бүх материаллаг байдлаар хууль тогтоомжийн дагуу хийгдсэн байна гэсэн дүгнэлтэд хүрсэн үед эерэг санал дүгнэлтийг илэрхийлж болно.
8. **Хэрэглэгчид** - Хүмүүс, багууд, байгууллагууд эсвэл төрөөс санхүүжүүлсэн хөтөлбөрийн амжилттай хэрэгжилт, , төрийн байгууллагын санхүүжилт болон төрийн салбарын үйл ажиллагаатай хамааралтай эсвэл сонирхсон бусад төрлийн байгууллагууд

5. Үндсэн анхаарах зүйлс

5.1 Ёс зүйн анхаарах зүйлс

33. Аудитын үндсэн зарчмуудад аудитын эхлэхээс өмнө анхаарч үздэг ёс зүйн ач холбогдолтой зарчмуудыг тусгасан байдаг (АДБОУС 200, 2.2.1). Эдгээр зарчмууд дараах зүйлстэй холбоотой. Үүнд:

- А) АДБ ба аудиторын хараат бус байдал, түүний дотор улс төрийн төвийн сахьсан байр суурь
- Б) Аудитор болон шалгагдагч байгууллагын хоорондын ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх асуудал
- В) Аудитын үндсэн зарчмуудыг дагаж мөрдөх явцад АДБ ба аудитор хянамгай байх

34. Хэрэв ямар нэгэн шалтгаанаар, АДБ эсвэл аудитор нь ёс зүйн ач хобогдолтой Аудитын үндсэн зарчмуудыг дагаж мөрдөх байр суурьгүй тохиолдолд аудитыг эхлэхээс өмнө зөрчлийн аюул заналыг арилгах зүй зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд, жишээлбэл, тухайн аудитыг гүйцэтгүүлэхээр үүрэг болгосон ажилтнуудыг дахин хуваарилах, нэмэлт сургалт эсвэл шинжээчдийг оролцуулах зэрэг багтаж болно.

35. Нэмэлт удирдамжийг дараах баримт бичгүүдээс олж болно. Үүнд:

- ИНТОСАИ-н Ёс зүйн дүрэм
- ИНТОСАИ-н Гүйцэтгэлийн аудитыг гүйцэтгэх гарын авлагын 2.2 ба 2.3-р хэсэг
- НБОУХ-ны БГАОУС 3000

5.2 Чанарын хяналт

36. Бусад төрлийн аудитын адилаар нийцлийн аудитыг гүйцэтгэхэд гүйцэтгэсэн ажил хангалттай чанартай хийгдсэн, тухайн аудитыг гүйцэтгэж буй төрийн аудиторууд бүгд шаардлагатай мэргэшил, ур чадвартай ба багийн ажлыг зүй зохистой чиглүүлж, удирдаж мөн хянасан зэргийг баталгаажуулах үйл явц ба горимууд АДБ-уудад байх нь чухал юм. ИНТОСАИ-н Аудитын үндсэн зарчмууд жишиг үзүүлэлтүүдийг тогтоосон ба ажлын чанарыг баталгаажуулах удирдамжаар хангадаг (АДБОУС 200, 2.1.26 ба 2.2.36).

37. Чанарын хяналтын нэмэлт удирдамжийг дараах баримт бичгүүдээс олж болно. Үүнд:

- ИНТОСАИ-н Чанарын дүрэм [төсөл] ба АДБОУС 1220
- ИНТОСАИ-н Гүйцэтгэлийн аудитыг гүйцэтгэх гарын авлагын 2.2 ба 2.3-р хэсэг
- НБОУХ-ны Чанарын хяналтын олон улсын стандарт (ЧХОУС) 1
- НБОУХ-ны БГАОУС 3000

6 Нийцлийн аудитыг төлөвлөх

38. Аудитын үндсэн зарчмуудад аудитор нь өндөр чанартай аудитыг арвилан хэмнэлт, үр ашиг, үр өгөөжтэйгээр тогтоосон хугацаанд гүйцэтгэхээр төлөвлөх ёстой гэж заасан байдаг (АДБОУС 300, 3.1.1). Түүнчлэн аудитыг төлөвлөж байгаа аудиторууд шалгагдагч байгууллагад хэрэглэх нийцлийн шаардлагуудын талаар мэдлэгтэй байх хэрэгтэй.
39. Төрийн аудиторууд аудитыг төлөвлөж, гүйцэтгэхдээ мэргэжлийн үл итгэх байр сууринаас хандана.

6.1 Оролцогч талууд/хууль эрх зүйн үндсийг тодорхойлох

40. Төрийн аудиторууд аудитыг үр дүнтэй гүйцэтгэхийн тулд шаардлагатай урьдчилсан нөхцөлүүд байгаа эсэхийг баталгаажуулна. Үүнд эхлээд холбогдох оролцогч талуудыг нийцлийн аудитыг төлөвлөх үед тодорхойлох багтана. Энэ нь шалгагдагч байгууллагын үндсэн хуулиарх байр суурь, үүрэг хариуцлага ба төрийн аудиторуудын үүрэг хариуцлагыг багтаасан АДБ-ын бүрэн эрх зэрэг аудитыг гүйцэтгэхэд шаардлагатай хууль эрх зүйн үндсийг тогтооход маш чухал юм.
41. Мөн түүнчлэн аудитын тайлангийн хэрэглэгчдийг тодорхойлох нь чухал юм. Тайлангийн хэлбэр ба агуулга зорилтот хэрэглэгчдэд хэрхэн хамгийн үр өгөөжтэйгээр мэдээлэх талаар аудиторын гаргасан мэргэжлийн үнэлэмжээс шалтгаалдаг. Хэрэглэгчид нь хууль тогтоох байгууллага, санхүүжүүлэгч агентлаг, хандивлагч байгууллага, ард иргэд эсвэл бусад холбогдох хэрэглэгчид эсэхээс хамааран хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлага нь харилцан адилгүй байж болно.

6.2 Шалгах асуудал ба шалгах асуудлын мэдээлэл

42. Шалгах асуудал ба түүний мэдээллийг тодорхойлох нь нийцлийн аудитыг төлөвлөх, гүйцэтгэх үед хийх эхний алхмуудын нэг юм.
43. Шалгах асуудлууд нь олон хэлбэртэй бөгөөд өөр өөр шинж чанартай байдаг. Мөн чанарын хувьд шалгах асуудлууд нь ерөнхий эсвэл илүү нарийвчилсан байж болно. Зарим нь тоон үзүүлэлтүүд байх ба ихэвчлэн амархан хэмжигддэг (жишээлбэл санхүүгийн үр дүн эсвэл нөхцөл байдал) байхад бусад нь чанарын үзүүлэлт буюу мөн чанарын хувьд илүү субьектив (жишээлбэл зан байдал) байдаг. Гэсэн ч шалгах асуудлууд тодорхойлох ба тохирох шалгуурын дагуу үнэлэх боломжтой байх ёстой. Түүнчлэн шалгах асуудал нь мөн чанарын хувьд үндэслэлтэй баталгаажуулалтын санал дүгнэлтийн хэлбэрээр тайлагнахад

дэмжлэг үзүүлэх шалгах асуудлын мэдээллийн талаар нотолгоо цуглуулах боломжтой байх ёстой.

- 44.Зарим тохиолдолд шалгах асуудлууд нь холбогдох хууль эсвэл аудитын бүрэн эрхэд тусгагдсан байж болно. Бусад тохиолдлуудад шалгах асуудлыг сонгох нь АДБ эсвэл төрийн аудитуудын хийх стратегийн сонголт бөгөөд эрсдэлийн үнэлгээ ба мэргэжлийн үнэлэмж дээр үндэслэдэг.
- 45.Нийцлийн аудит нь төсвийн тухай хууль тогтоомж эсвэл бусад холбогдох төсвийн шийдвэрүүдийг хамрахдаа байгууллагын орлого ба санхүүжилт мөн түүнчлэн зарцуулалтыг хамарна.
- 46.Хууль тогтоох байгууллагын холбогдох шийдвэрүүдээс өмнө баримтжуулсан төсвийн төсөөлөл ба урьдчилсан таамаглалын нийцэлд аудит хийх нь АДБ-ын бүрэн эрхэд хамаарч болно.
- 47.Санхүүгийн тайлангийн аудиттай хамаатай гүйцэтгэж байгаа тохиолдолд нийцлийн аудитын шалгах асуудал нь ерөнхийдөө төсөвлөсөн хөрөнгийн ашиглалт болон төсвийн зарцуулалттай холбоотой шийдвэр ба санхүүгийн удирдлага юм. Ийм нийцлийн аудитад санхүүгийн тайланд тусгагдсан үйл ажиллагаа, санхүүгийн ажил гүйлгээ ба мэдээлэл (шалгах асуудлын мэдээлэл) тэдгээрийг удирддаг эрх бүхий байгууллагын хууль тогтоомжтой (шалгуур) нийцэж байгаа эсэхэд үнэлгээ хийх багтана. Эдгээр хууль тогтоомж гэдэгт холбогдох хууль тогтоомж, түүний дотор төсвийн тухай хууль, ялангуяа хууль тогтоомжийн үндсэн зарчмууд, хууль эрх зүйн акт, парламентын шийдвэрүүд ба бусад эрх бүхий байгууллагын шийдвэрүүд, баримтлал, удирдамж ба тохиролцсон нөхцөлүүд зэрэг орно. Тухайн байгууллагын орлого, зарлага нь хууль тогтоох байгууллагаас төлөвлөсөн зорилго, байгууллагын эрх олгосон хөтөлбөрийн зорилт болон үйл ажиллагааны дагуу ашиглагдсан эсэх нь мөн хамаарна.
- 48.Нийцлийн аудиттай холбоотой шалгах асуудал, түүний мэдээллийн талаарх зарим жишээг Хавсралт 1-т тусгасан.

6.3 Шалгуур

- 49.Шалгах асуудлуудтай харьцуулах шалгуур эсвэл жишиг үзүүлэлтүүдийг заавал тогтоох ёстой. Нийцлийн аудитыг гүйцэтгэх шалгуурыг тогтоох нь аудитыг төлөвлөх үйл явцын үндсэн үе шат юм. Нийцлийн аудиттай холбоотой шалгуурын талаарх зарим жишээг Хавсралт 1 ба 1-А-д тусгасан.
50. Шалгуур нь хууль тогтоомж, засгийн газрын удирдамж, эсвэл гэрээ хэлэлцээрийн нөхцөлүүд зэрэг албан ёсны байж болно. Мөн шалгуур нь ёс

зүйн дүрэм эсвэл ёс зүйн зарчмууд гэх мэтчилэн илүү албан ёсны бус байж болох ба эдгээр нь зан байдалтай хамааралтай хүлээлттэй холбоотой байж болох юм, жишээлбэл хязгаарлалтыг хаа нэгтээ зааж өгөөгүй бол төрийн зардлаар зохион байгуулж буй аялалын зэрэглэл эсвэл зочлон хүндэтгэх үйл ажиллагааны түвшин ба тоглолт, хүлээн авалт зэрэгтэй холбоотой юуг зөвшөөрч болохуйц гэж үзэх. Шалгуур болгон ашиглаж буй захиргааны удирдамж нь хууль тогтоомжтой нийцсэн байх ёстой. Аудитын шалгуурын суурь болгон ашиглаж буй эх сурвалжууд нь нийцлийн аудитын нэг хэсэг байж болно.

51. Шалгуурууд нь тохиромжтой байх ёстой. Энэ нь шалгуурууд нь дараах шинж чанарыг агуулсан байх ёстой гэсэн үг юм. Үүнд:

- А) **Учир холбогдолтой байх** – Учир холбогдол бүхий шалгуурууд нь аудитын тайлангийн зорилтот хэрэглэгчдийн мэдээлэл ба шийдвэр гаргах хэрэгцээ шаардлагад ач холбогдол бүхий хувь нэмэр оруулдаг.
- Б) **Найдвартай байх** – Найдвартай шалгуурууд нь ижил төстэй нөхцөл байдлуудад өөр аудитор ашигласан үед үндэслэлтэй тогтвортой дүгнэлт гаргах боломж олгоно.
- В) **Иж бүрэн байх** – Аудитын зорилгод хангалттай ба хамаатай хүчин зүйлүүдийг орхигдуулаагүй байвал шалгуурууд иж бүрэн байна. Эдгээр нь ач холбогдол ихтэй бөгөөд зорилтот хэрэглэгчдийг мэдээлэл ба шийдвэр гаргах хэрэгцээ шаардлагад бодит төсөөллөөр хангах боломжийг бий болгодог.
- Г) **Бодитой байх** – Бодитой шалгуурууд нь товч ба аудитор эсвэл шалгагдагч байгууллагын удирдлагын нөлөөнөөс ангид байдаг. Энэ нь шалгуурууд шалгах асуудлын мэдээлийг шалгуурын дагуу үнэлэхэд илүү субъектив байж, бусад төрийн аудиторуудыг дэндүү ялгаатай дүгнэлтэд хүргэхээр илүү албан бус байж болохгүй гэсэн үг юм.
- Д) **Ойлгомжтой байх** – Ойлгомжтой шалгуурууд нь тодорхой байх, зорилтот хэрэглэгчдэд ойлгомжтой байна. Эдгээр нь өөр өөр тайлбарлагдахааргүй байна.
- Е) **Харьцуулж болохуйц байх** – Харьцуулж болохуйц шалгуурууд ижил төстэй агентлаг эсвэл үйл ажиллагаанд хийсэн ижил төстэй аудитад ашиглагдсан ба тухайн байгууллагад хийсэн өмнөх аудитуудад ашиглагдсан шалгууруудтай нийцсэн байдаг.

Ё) **Хүлээн зөвшөөрөгдсөн байх** - Хүлээн зөвшөөрөгдсөн шалгуурууд нь салбарын шинжээч, шалгагдагч байгууллагууд, хууль тогтоох байгууллага, хэвлэл мэдээллийнхэн болон олон нийт нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн байна.

Ж) **Нээлттэй байх** – гүйцэтгэсэн аудитын ажлын мөн чанар ба аудитын тайлангийн үндэслэлийг ойлгуулах үүднээс зорилтот хэрэглэгчдэд шалгуурууд нь нээлттэй байх ёстой.

52. Шалгуурууд нь тухайлсан аудитын зорилгод ач холбогдол бүхий нөлөө үзүүлж болзошгүй асуудлуудыг агуулсан байдаг. Тиймээс нийцлийн аудитыг гүйцэтгэх төрийн аудаторууд гүйцэтгэх гэж буй тухайн аудитын зорилт ба шалгах асуудалтай учир холбогдолтой, тохиромжтой шалгууруудыг тогтооно. Дээр дурдсан шинж чанар дээр үндэслэн тохиромжтой шалгууруудыг тогтоосны дараа ач холбогдол ихтэй аудитын дүгнэлтэд хүрэхийн тулд аудит бүрийн тодорхой нөхцөлүүдэд тэдгээрийг зүй зохистойгоор “ажилд оруулах” ёстой.

53. Шалгууруудыг тогтоох нь хялбар байж болох ч зарим тохиолдолд нарийн төвөгтэй байж болно. Зарим тохиолдолд төрийн аудаторуудад ашиглах тохиромжтой шалгууруудын талаар төсөөлөл олж авахад шалгах хуудас тус дөхөм болж болох юм. Төрийн аудаторууд шалгууруудыг тогтооход туслах хэд хэдэн эх сурвалжийг ашигладаг. Эдгээр эх сурвалжийн талаарх зарим жишээг Хавсралт 2-т тусгав.

54. Ихэнх нийцлийн аудитад тохиромжтой шалгуурууд нь шууд тогтоогдохоор байдаг. Энэ тохиолдолд тодорхой, төвөгтэй бус хууль эсвэл тогтоомжууд шалгууруудыг бий болгодог. Хууль тогтоох байгууллагаас гаргасан тогтоолуудын баримтжуулсан зорилго эсвэл урьдчилсан таамаглал нь тохиромжтой шалгууруудыг тогтооход аудиторт дэмжлэг үзүүлж болно.

55. Холбогдох хууль тогтоомжийн зөв тайлбар нь юу болох талаар эргэлзээтэй нөхцөл байдалд хуулийг боловсруулах үед төлөвлөсөн зорилго ба урьдчилсан таамаглалуудыг харгалзаж үзэх эсвэл хууль тогтоомжийг хариуцсан тухайн байгууллагатай зөвлөх нь төрийн аудаторуудад тустай байж болох юм. Мөн аудаторууд шүүхийн эрх бүхий байгууллагаас өмнө нь гаргасан холбогдох шийдвэрүүдийг харгалзан үзэж болно.

56. Гэхдээ зүй зохистой байдал нь нийцлийн аудитын шалгах асуудал байх тохиолдолд шалгуур нь илүү албан ёсны бус бөгөөд төрийн албан тушаалтны ёс суртахуун, үйл ажиллагаатай холбоотой олон нийтийн хүлээлтийг хамарсан байх тул шалгуурыг тогтооход илүү төвөгтэй байж болох юм. Эдгээр тохиолдлуудад төрийн аудаторууд тохиромжтой шалгуурыг тогтоохдоо илүү

анхааралтай хандах шаардлагатай. Хэрэв төрийн албан тушаалтны хүлээн зөвшөөрч болохуйц ёс суртахууны хэм хэмжээг зөрчсөн тохиолдол нь баталгаатай нөхцөл байдалд түүнийг тайлагнахад тохиромжтой шалгуурыг тогтоох хэрэгцээ шаардлага нь төрийн аудиторруудад саад учруулахгүй.

57. Тохиромжтой шалгуурыг тогтоох явцад төрийн аудиторрууд аудит хийгдэх сэдэв бүр (төсвийн тухай хууль, бусад тухайлсан хуулиуд, гэрээний нөхцөлүүд гэх мэт мөн түүнчлэн хамааралтай тохиолдолд зүй зохистой байдал) дээр гарч болохуйц зөрчлийн эрсдэлтэй холбоотой материаллаг байдлыг анхаарч үзнэ. Материаллаг байдлын талаар анхаарах зүйлд тоон үзүүлэлт (хэмжээ) ба чанарын үзүүлэлт (мөн чанар ба шинж чанар) багтана.
58. Ашиглах гэж буй шалгууруудад аудит хийх гэж буй сэдвүүд бүгд хангалттай тусгагдсан эсэхийг төрийн аудиторрууд баталгаажуулна. Цөөхөн тохиолдолд аудитын хамрах хүрээ хязгаарлагдмал бөгөөд хууль эсвэл тогтоомжийн зөвхөн зарим хэсгийг хамарч болох ба энэ үед аудиторын тайланд хязгаарлагдмал хамрах хүрээг тодорхой тусгасан байх ёстой. Хэрэв төрийн аудиторрууд тохиромжтой шалгууруудыг тогтоохдоо шалгагдагч байгууллага эсвэл бусад захиргааны эрх бүхий байгууллагаас өгсөн удирдамж, шалгах хуудас эсвэл бусад материалуудыг ашигласан бол холбогдох хууль, тогтоомжийг хангалттай тусгасан материалуудыг ашигласан гэдгээ тохиромжтой аудитын горимоор баталгаажуулахдаа хянамгай байх ёстой.
59. Зарим тохилдолд холбогдох хууль тогтоомжийн заалтууд нь ойлгомжтой бус байж болно, жишээлбэл илүү тодорхой заалтуудаар хангах хууль тогтоомжийн актыг холбогдох захиргааны байгууллага гаргах ёстой бөгөөд эдгээр заалтууд нь боловсруулагдаагүй байгаа. Ийм тохиолдолд төрийн аудиторрууд холбогдох хууль тогтоомжоор юуг шаардаж байна гэж итгэж байгаа эсвэл хязгаарлагдсан аудитын хамрах хүрээ ба энэ хязгаарлалтын учир шалтгааныг аудитын тайландаа тодорхой тусгана. Жишээлбэл, тайланд хуулийн хангалттай бус тодорхой байдал нь ашигласан аудитын шалгуурыг хязгаарласан бөгөөд залруулах арга хэмжээг авах шаардлагатай гэж тусгаж болно.
60. Зарим цөөн тохиолдолд шалгуурууд нь нарийн төвөгтэй байж болно, жишээлбэл хуулийн өөр өөр эх сурвалжуудын хооронд зөрчил байгаа бөгөөд холбогдох захиргааны эсвэл шүүхийн эрх бүхий байгууллагууд эдгээр асуудлыг шийдвэрлээгүй. Ийм тохиолдолд тухайн шалгуурын цаад зорилгыг ойлгох ба энэ зөрчлөөс үүсэх үр дагаврыг тогтоох зэрэг нь маш чухал юм. Мөн холбогдох байгууллагуудаар засаж залруулах арга хэмжээ авахуулахын тулд зөрчилдөж буй шалгууруудын тохиолдлуудыг аудитын тайланд тодорхой тусгах шаардлагатай байж болох юм.

61. Ийм төрлийн төвөгтэй байдалд тохиромжтой шалгууруудыг тогтооход туслах арга хандлагад дараах зүйлс багтана. Үүнд:

А) Салбарын шинжээч нарт “Логик сэтгэлгээ эсвэл харьцуулж болохуйц хамгийн сайн практикийн дагуу төгс нөхцөл байдалд ямар хийсвэр үр дүн гарах ёстой вэ” гэх мэт асуултад хариулах боломж олгох замаар “онолын” арга хандлагыг ашиглах, эсвэл

Б) Хэрэглэгчид болон шийдвэр гаргагчидтай хэлэлцүүлэг хийх зэргээр “туршлага дээр үндэслэсэн” арга хандлагыг ашиглах замаар үндэслэлтэй болон бодитой шалгуур тогтоох дэмжлэгийг тодорхойлох ба олж авах

62. Аудитын арга хандлагыг хэсгүүдэд хувааж эсвэл хамрах хүрээг нарийсгаж болох ба ингэснээр тодорхойлоход ойлгомжтой шалгууруудыг ашиглаж болно.

63. Шалгуурууд нь зорилтот хэрэглэгчид ба, тохиромжтой бол, бусад хэрэглэгчдэд нээлттэй байх ёстой, жишээлбэл аудиторын тайланд шалгуурыг тусгах эсвэл хэрэв шалгууруудыг өөр хэлбэрээр гаргаж өгсөн тохиолдолд тэдгээрт лавлагаа гаргах замаар.

64. Ямар нэг шалтгаанаар аудитын шалгууруудыг тохиромжтой биш гэж үзсэн тохиолдолд төрийн байгууллагуудын дагаж мөрдөх ерөнхий зарчмуудыг тодорхой боловсруулахад нь холбогдох байгууллагуудад АДБ дэмжлэг үзүүлж болно.

6.4 Шалгагдагч байгууллага, түүний орчныг ойлгох нь

65. Дээр тайлбарласан шалгах асуудал ба тохиромжтой шалгууруудыг тогтоох нь нийцлийн аудитыг гүйцэтгэх эхний алхмуудын нэг юм. Шалгах асуудал ба шалгууруудыг тогтоох үйл явцад төрийн аудиторууд шалгагдагч байгууллага болон аудитыг хүрээлж буй орчингийн тухай ойлголт олж авах багтана. Энэ ойлголт нь төрийн аудиторуудад аудитын бүхий л үйл явцын туршид мэргэжлийн шийдэл гаргахад нь чиг баримжаа өгдөг. Тухайн байгууллага, түүний орчин болон холбогдох хөтөлбөрийн талаарх ойлголт нь материаллаг байдлыг тодорхойлох ба эрсдэлийг үнэлэхэд хэрэглэгдэх учраас маш чухал юм. Энэ ойлголтыг олж авахад ашиглах эх сурвалжуудын зарим жишээг Хавсралт 2-т тусгасан.

66. АДБОУС 4000-ын 10 дугаар зүйлд зааснаар Нийцлийн аудитын гарын авлага нь засгийн газрын бүхий л түвшин дэх нийцлийн аудитыг хамарна. Иймээс энэхүү гарын авлагыг тохиромжтой бол хэд хэдэн байгууллагуудыг нэгтгэн хийхээр төлөвлөж, гүйцэтгэж буй аудитад ашиглана. Хэд хэдэн байгууллагуудыг нэгтгэн

хийх аудитад аудитор(ууд)-ын үүрэг хариуцлага тодорхой тусгагдсан байх ёстой.

6.5 Аудитын стратеги ба төлөвлөгөө

67. Аудитыг үр өгөөжтэй гүйцэтгэхийн тулд аудитыг төлөвлөхөд аудитын багийн холбогдох гишүүдтэй хэлэлцүүлэг хийх, аудитын үндсэн стратеги болон төлөвлөгөөг боловсруулах зэрэг хамаарна. Аудитын стратеги болон төлөвлөгөө аль алиныг нь бичгээр баримтжуулах ёстой. Төлөвлөлт нь аудитын салангид үе шат биш харин байнгын бөгөөд давтагддаг үйл явц юм. Аудитын үндсэн стратеги болон төлөвлөгөө нь аудитын туршид шаардлагатай тохиолдолд шинэчлэгдэнэ. Төлөвлөлтөнд бас ажлыг гүйцэтгэх багийн хяналт, удирдлага ба удирдамжтай холбоотой анхаарах зүйлс багтана.

68. Нийцлийн аудитын үндсэн стратегийг боловсруулахдаа төрийн аудиторуд дараах зүйлсийг анхаарч үзнэ. Үүнд:

А) АДБ-ын бүрэн эрх болон нийцлийн аудитын тодорхойлолтод тусгагдсан элементүүдийг харгалзан үзсэний үндсэн дээр тодорхойлсон нийцлийн аудитын зорилтууд, хамрах хүрээ, шалгах асуудал, шалгуурууд болон бусад шинж чанарууд

Б) Тайлагнах үүрэг хариуцлага ба зорилтууд, мөн түүнчлэн хэнд, хэзээ үүнийг ямар хэлбэрээр тайлагнах

В) Аудитын удирдамжид нөлөөлж болох чухал хүчин зүйлс

Г) Материаллаг байдал ба аудитын эрсдэлийн үнэлгээ

Д) Өмнөх эсвэл хамааралтай аудитаас олж авсан мэдлэг

Е) Аудитын багийн бүрэлдэхүүн ба ажлын хуваарилалт, түүний дотор шинжээчид шаардлагатай эсэх

Ё) Аудитын хугацаа

69. Төрийн аудиторуд нийцлийн аудитын төлөвлөгөөг боловсруулна. Аудитын стратеги нь аудитын төлөвлөгөөний суурь өгөгдөл юм. Аудитын төлөвлөгөөнд дараах зүйлс багтана. Үүнд:

- А) Нийцлийн аудитын хамрах хүрээ, шинж чанар болон хууль эрхзүйн, зохицуулалтын эсвэл төсвийн хүрээтэй холбоотой тогтоосон шалгууруудын тодорхойлолт
- Б) Аудитын янз бүрийн шалгууруудтай холбоотой зөрчлүүдийн эрсдэлийг үнэлэхэд хангалттай эрсдэлийн үнэлгээний горимуудын мөн чанар, хугацаа ба хэмжээний тодорхойлолт
- В) Нийцлийн аудитын янз бүрийн шалгуурууд болон эрсдэлийн үнэлгээтэй холбоотой төлөвлөсөн аудитын горимуудын мөн чанар, хугацаа ба хэмжээний тодорхойлолт

70. Төлөвлөлтөд дараах үйл явц багтана. Үүнд:

- А) Хууль эрх зүйн, зохицуулалтын ба төсвийн хүрээ мөн түүнчлэн шалгагдагч байгууллагатай холбоотой аудитын хамрах хүрээнд ашиглаж болох тохиролцсон нөхцөл байдлуудын талаар ерөнхий ойлголтыг олж авах
- Б) Удирдлагын холбогдох хууль тогтоомжид хийсэн үнэлгээ, түүний дотор хууль тогтоомжийн нийцлийг баталгаажуулахад туслах удирдлагын дотоод хяналтын талаар ойлголт олж авах
- В) Дүрэм журам, хууль тогтоомж, бодлого, дүрмүүд, ач холбогдол бүхий гэрээ эсвэл буцалтгүй тусламжийн хэлэлцээр гэх мэт холбогдох хууль тогтоомжуудын талаар ойлголт олж авах
- Г) Зүй зохистой байдлын аудитын хувьд – төрийн санхүүгийн сайн удирдлагын холбогдох зарчмууд болон төрийн салбарын албан тушаалтнуудын зан байдалтай холбоотой шаардлагуудын талаарх ойлголтыг олж авах

71. Аудитын төлөвлөлт ба аудитын шалгууруудын талаарх нэмэлт удирдамжийг дараах баримт бичгүүдээс олж болно. Үүнд:

- АДБОУС 1210 ба 1300
- ИНТОСАИ-н Гүйцэтгэлийн аудитыг гүйцэтгэх гарын авлагын 3-р хэсэг ба Хавсралт 2
- НБОУХ-ны БГАОУС 3000

6.6 Шалгагдагч байгууллагын дотоод хяналтыг ойлгох нь

72. Дотоод хяналтыг ойлгох нь ихэвчлэн тухайн байгууллага ба холбогдох шалгах асуудлыг ойлгох үйл явцын үндсэн хэсэг байдаг. Аудитын үндсэн зарчмуудад аудитыг гүйцэтгэх төрийн аудаторууд дотоод хяналтын найдвартай байдлыг ойлгож, үнэлнэ гэж тайлбарласан (АДБОУС 300, 3.3.1). Үүнд нийцлийн аудитын явцад хууль тогтоомжийг дагаж мөрдөхөд удирдлагад туслах хяналтыг ойлгож, үнэлэх багтана (АДБОУС 300, 3.3.2).

73. Хяналтуудын тодорхой нэг төрлүүд нь шалгах асуудал болон тухайн нийцлийн аудитын мөн чанар ба хамрах хүрээн дээр үндэслэн үнэлэгддэг. Дотоод хяналтыг үнэлэх явцад хяналтын бүтэц нь урьдчилан сэргийлж эсвэл илрүүлж чадахгүй байх магадлалтай материаллаг зөрчлийн эрсдэлийг төрийн аудаторууд үнэлдэг (АДБОУС 300, 3.4.6). Байгууллагын дотоод хяналтын тогтолцоонд тогтоосон зөрчлийг арилгахаар төлөвлөсөн хяналтууд бас багтаж болно. Төрийн аудаторууд аудитын зорилттой холбоотой дотоод хяналт болон хяналтын сорилуудын талаарх ойлголт олж авна. Дотоод хяналтын үнэлгээнээс бий болсон баталгаажуулалт нь аудаторуудад гүйцэтгэх аудитын горимуудын хэмжээ болон итгэлийн түвшинг тодорхойлоход туслана.

74. Шалгагдагч байгууллагыг ойлгох талаарх нэмэлт удирдамжийг дараах баримт бичгүүдээс олж болно. Үүнд:

- АДБОУС 1315
- ИНТОСАИ-н Гүйцэтгэлийн аудитыг гүйцэтгэх гарын авлагын 3.3-р хэсэг, Дэд бүлэг – хөтөлбөрийг ойлгох ба Хавсралт 1, Дэд бүлэг 2 – Аудитын асуултуудыг боловсруулах эсвэл аудитын асуудлуудыг тодорхойлох
- ИНТОСАИ-н Төрийн салбарын дотоод хяналтын стандартуудын гарын авлага
- НБОУХ-ны БГАОУС 3000

6.7 Материаллаг байдал

75. Материаллаг байдал нь тоон болон чанарын хүчин зүйлүүдээс бүрдэнэ. Нийцлийн аудитыг гүйцэтгэхэд материаллаг байдлыг дараах зорилгоор тооцоолдог. Үүнд:

А) Төлөвлөлтийн зорилгоор

Б) Олж авсан нотлох зүйлс болон тогтоосон зөрчлүүдийн нөлөөллүүдийг үнэлэх зорилгоор, ба

В) Аудитын ажлын үр дүнг тайлагнах зорилгоор.

76. Төрийн аудиторунд шалгах асуудлын мэдээлэл нь бүх материаллаг байдлын хувьд тогтоосон шалгууруудтай нийцэж байгаа эсэхийг тодорхойлохийн тулд аудитыг төлөвлөж, гүйцэтгэнэ.
77. Аудитын үндсэн зарчмуудад зааснаар “Материаллаг байдал нь ихэвчлэн үнэ цэнээр томъёологддог боловч эд зүйл эсвэл бүлэг эд зүйлсийн уламжлалт мөн чанар эсвэл шинж чанар нь материаллаг асуудлыг илэрхийлнэ- жишээлбэл, холбогдох дүн хэмжээнээс үл хамааран тусад нь тодруулга хийхийг хууль эсвэл тогтоомжоор шаардсан тохиолдлууд.” (АДБОУС 100, 1.0.10)
78. Төлөвлөлтийн үе шатанд аудитын горимуудыг боловсруулах зорилгоор материаллаг байдлын түвшнийг тогтоох ба эрсдэлийг үнэлэхийн тулд тухайн байгууллагын талаарх мэдээллийг цуглуулдаг. Цуглуулсан нотлох зүйлсийг дүгнэлт гаргах болон тайлагнах зорилгоор үнэлэх ёстой. Материаллаг байдал нь энэ үнэлгээнд ихээхэн ач холбогдолтой.
79. Төлөвлөлтийн зорилгоор материаллаг байдлыг тооцоолох нь энгийн байж болно. Энэ нь хууль эсвэл тогтоомж, эсвэл тохиролцсон нөхцөлүүд нийцлийн болзолт бус шаардлагуудыг бий болгож буй тохиолдол байж болох юм, жишээлбэл батлагдсан төсөвтэй холбоотой хэтрүүлэн зарцуулахыг үндсэн хуулиар хориглосон зэрэг
80. Материаллаг байдлын ерөнхий тодорхойлолтоос доогуур түвшний үнэ цэнэ эсвэл илэрхийлэлээр материаллаг гэж авч үзсэн бусад асуудлуудад дараах зүйл багтана.
- А) Залилан
 - Б) Санаатай хууль бус үйлдэл эсвэл зөрчил
 - В) Удирдлага, аудитор эсвэл хууль тогтоох байгуулагад өгсөн мэдээлэл нь буруу эсвэл иж бүрэн бус (нуун дарагдуулалт)
 - Г) Удирдлага, эрх бүхий байгууллага эсвэл аудитораас өгсөн аудитын мөрөөр авах арга хэмжээг санаатайгаар үл тоомсорлох
 - Д) Тухайн үйл явдал эсвэл ажил гүйлгээг хийхэд хууль эрх зүйн суурь дутмаг байгааг үл тоомсорлон хийсэн үйл явдал эсвэл ажил гүйлгээ
81. Бусад тохиолдлуудад материаллаг байдлыг тогтоох нь ихэвчлэн мэргэжлийн үнэлэмжийн асуудал юм.

82. Олж авсан нотолгоог үнэлэх явцад тухайн шалгах асуудал нөлөөлсөн хүмүүс эсвэл байгууллагын тоо, эсвэл мөнгөн дүн зэрэг тоон хүчин зүйлүүд материаллаг байдлыг тогтооход нөлөөлж болох юм. Зарим тохиолдолд чанарын хүчин зүйлүүд нь тоон хүчин зүйлүүдээс илүү чухал байдаг. Үүнд тухайлсан хөтөлбөр эсвэл шалгах асуудлын мөн чанар, ялгарах байдал ба мэдрэмтгий байдал зэрэг нь үүрэг гүйцэтгэж болно. Жишээлбэл, хэрэглэгчид, хууль тогтоох байгууллагын төрийн тооцооны хороо эсвэл ижил төстэй хороо, эсвэл зохицуулагч байгуулагаас анхаарал хандуулсан шалгах асуудал материаллаг байдлыг тогтооход нөлөөлж болно. Мөн олон нийтийн хүлээлт эсвэл ашиг сонирхол нь материаллаг байдлыг тогтооход төрийн аудитуудад нөлөөлж болохуйц чанарын хүчин зүйлс юм. Мөн зөрчлийн ноцтой байдлыг анхаарч үзнэ. Хууль тогтоох байгуулагаас эрх олгосон төсвийг хэтрүүлэн зарцуулсан эсвэл батлагдсан төсөвт тусгагдаагүй шинэ үйлчилгээг танилцуулсан зэрэг хууль бус гэж үзэхээргүй тохиолдлууд мөн чанараараа зөрчлийн ноцтой тохиолдлууд байж болох юм.

83. Тогтоосон зөрчлийн материаллаг байдлыг үнэлэхэд зөрчлийн шалгуур, нөхцөл байдал, учир шалтгаан ба үр дагавар зэрэг асуудлуудыг мөн анхаарч үзнэ.

84. Тогтоосон зөрчилтэй холбоотой материаллаг байдлын талаарх дэлгэрэнгүй удирдамжийг доорх Нотлох зүйлсийг үнэлэх ба дүгнэлт гаргах гэсэн хэсэгт авч үзнэ.

85. Материаллаг байдлын талаарх нэмэлт удирдамжийг дараах баримт бичгүүдээс олж болно. Үүнд:

- АДБОУС 1320 ба 1450
- ИНТОСАИ-н Гүйцэтгэлийн аудитыг гүйцэтгэх гарын авлагын 5.3-р хэсэг, Дэд бүлэг – Материаллаг, учир холбогдолтой ба бодиттой байдал ба Хавсралт 3-ын 1.2-р хэсэг, Дэд бүлэг – Нотлох зүйлсийн хангалттай байдал
- НБОУХ-ны БГАОУС 3000

6.8. Эрсдэлийн үнэлгээ

86. Эрсдэлийн үнэлгээ нь үндэслэлтэй баталгаажуулалтын аудитын үндсэн хэсэг юм. Аудитын уламжлалт хязгаарлалтаас хамааран нийцлийн аудит нь зөрчлийн бүх тохиолдлуудыг олж илрүүлнэ гэсэн баталгаа эсвэл бүрэн төгс баталгаажуулалтаар хангадаггүй. Нийцлийн аудитын уламжлалт хязгаарлалтуудад дараах хүчин зүйлс хамаарч болно. Үүнд:

А) Хууль тогтоомжийг тайлбарлахад ашиглах удирдлагын үнэлэмж

Б) Хүний гаргаж болох алдаа

В) Зүй зохистой бус төлөвлөсөн эсвэл үр өгөөжгүй тогтолцоо

Г) Зөрчигдсэн байж болохуйц хяналтууд

Д) Нуун далдалсан байж болохуйц нотлох зүйлс

87. Нийцлийн аудитыг гүйцэтгэхэд төрийн аудиторуд аудитын турш шаардлагатай тохиолдлуудад эрсдэлийг үнэлж, аудитын горимуудыг гүйцэтгэдэг. Тодорхой тохиолдлуудад эрсдэлийг боломжит доод түвшин хүртэл багасгахын тулд үүнийг гүйцэтгэх ба ингэснээр аудиторын дүгнэлтийн суурь болох үндэслэлтэй баталгаажуулалтыг олж авах юм.

88. Эдгээр эрсдлүүдийг нэмэгдүүлж болохуйц эрсдлүүд болон хүчин зүйлс аудитын нөхцөл байдал ба тухайлсан шалгах асуудлаас хамааран харилцан адилгүй байна. Ерөнхийдөө, төрийн аудиторуд аудитын эрсдэлийн – уламжлалт эрсдэл, хяналтын эрсдэл ба илрүүлэлтийн эрсдэл гэсэн элементүүдийг тухайн нөхцөл байдал ба шалгах асуудалтай холбоотой анхаарч үзнэ. Мөн түүнчлэн эрсдэлийг үнэлэхдээ асуудал үүсэж болох магадлал болон хэрэв тухайн асуудал үүсэхэд гарч болохуйц үр дагавар зэргийг харгалзаж үзнэ.

6.8.1. Залилантай холбоотой эрсдэлийн үнэлгээний анхаарах зүйлс

89. Төрийн аудиторуд залилангийн эрсдэлийг тогтоож, үнэлэх ба тогтоосон залилангийн эрсдэлтэй холбоотой хангалттай, зохистой нотолгоог тохиромжтой аудитын горимыг хэрэгжүүлэх замаар цуглуулах нь аудитын нэг хэсэг юм. Сэжиг бүхий залилан тогтоогдсон тохиолдолд төрийн аудиторуд АДБ-ын бүрэн эрх ба тухайн нөхцөл байдалд үндэслэсэн өөрсдийн зүй зохистой хариу үйлдлийг баталгаажуулах арга хэмжээ авна.

90. Төрийн аудитын илүү өргөн үзэл баримтлалын хүрээнд залилантай холбоотой материаллаг байдлын залилангийн эрсдэл ба үнэлгээг анхаарч үзнэ. Төрийн салбар дахь залилангийн эрсдлүүдийг ерөнхийдөө нэмэгдүүлэх магадлалтай хамрах хүрээ ба нөхцөл байдлуудын жишээнд дараах зүйлс багтаж болно. Үүнд:

А) Гуравдагч этгээдэд олгох буцалтгүй тусламж ба тэтгэмж

Б) Худалдан авалт

В) Төрийн албан тушаалтнуудын чиг үүрэг ба бүрэн эрхийг хэрэгжүүлэх

Г) Үр дүн ба мэдээллийг санаатай буруу илэрхийлэх эсвэл буруу толилуулах

Д) Төрийн байгууллагуудыг хувьчлах

Е) Төрийн албан тушаалтнууд эсвэл байгууллагуудын хоорондын харилцаа холбоо

6.8.2 Төрийн байгууллагуудын хоорондын харилцаатай холбоотой эрсдэлийн үнэлгээний анхаарах зүйлс

91. Янз бүрийн төрийн байгууллагуудын хоорондын харилцаа холбоог аудитын эрсдэлийг ялангуяа залилан эсвэл зөрчлийн эрсдэлийг үнэлэхэд анхаарч үзнэ. Эдгээр эрсдлүүд нь, жишээлбэл ямар нэг байгууллагад зүй зохисгүй үйл ажиллагаа явуулах нөлөөллийг үзүүлэх нэг байгууллагатай холбоотой байж болно. Энэ үйл ажиллагааны үр дүн нь эрх хууль тогтоомжтой үл нийцсэн ба зарим тохиолдолд хууль бус үйлдэл байж болох юм. Цаашлаад төрийн салбарт янз бүрийн төрийн байгууллагуудын хоорондын үйл ажиллагаа ба ажил гүйлгээнүүдтэй холбоотой тусгай шаардлагууд байж болно. Төлөвлөсөн аудитын горимууд, аудитын дүгнэлт эсвэл аудиторын тайлан зэрэгт нөлөө үзүүлж болохуйц эдгээр үйл ажиллагаа эсвэл ажил гүйлгээнүүдтэй холбоотой тайлагналын тусгай шаардлагууд бас байж болно.

92. Нийцлийн аудит дахь эрсдэлийг үнэлэхтэй холбоотой хүчин зүйлүүдийн жишээг Хавсралт 3-т тусгасан. Мөн түүнчлэн худалдан авалтын нийцлийн аудиттай холбоотой эрсдэлийн хүчин зүйлүүдийн тайлбар жишээг Хавсралт 4-т үзүүлэв.

93. Эрсдэлийн үнэлгээ ба залилангийн эрсдэлийн талаарх нэмэлт удирдамжийг дараах баримт бичгүүдээс олж болно. Үүнд:

- АДБОУС 1240, 1315 ба 1550
- ИНТОСАИ-н Гүйцэтгэлийн аудитыг гүйцэтгэх гарын авлагын 3.2-р хэсэг, Дэд бүлэг – Эрсдлүүд эсвэл тодорхой бус байдал
- НБОУХ-ны баталгаажуулалтын үзэл баримтлал ба БГАОУС 3000

6.9. Аудитын горимуудыг төлөвлөх

94. Аудитын горимуудын төлөвлөлтөнд зөрчлийн тогтоосон эрсдэлд хариу үйлдэл үзүүлэх горимуудыг боловсруулах багтана. Гүйцэтгэх аудитын горимуудын тодорхой мөн чанар, хугацаа ба хэмжээ нь нэг аудитаас нөгөөд харилцан адилгүй байна. Гэсэн ч ерөнхийдөө нийцлийн аудитын горимуудад холбогдох шалгуурууд, өөрөөр хэлбэл байгууллагыг удирдаж буй эрх бүхий байгууллагаас гаргасан хууль тогтоомжуудыг тодорхойлж, тэдгээрийн дагуу холбогдох шалгах

асуудлын мэдээллийг хэмжих зэрэг багтана. Аудитын горимуудын талаар дэлгэрэнгүй мэдээллийг нийцлийн аудитыг гүйцэтгэх ба нотлох зүйлсийг цуглуулах гэсэн дараагийн хэсэгт авч үзнэ.

7 Нийцлийн аудитыг гүйцэтгэх ба нотолгоог цуглуулах

95. Аудитын үндсэн зарчмуудад төрийн аудиторууд нөхцөл байдалд тохиромжтой гэж үзсэн аудитын үе шатууд болон горимуудыг өөрсдийн мэргэжлийн үнэлэмжээр сонгож, гүйцэтгэнэ гэж заасан байдаг (АДБОУС 300, 3.4.5). Мөн аудитын үндсэн зарчмуудад аудитын үе шатууд болон горимуудыг аудиторын үнэлэмж ба дүгнэлтэд үндэслэлтэй сууриар хангах хангалттай, шаардлага хангасан ба учир холбогдолтой нотолгоог олж авахад зориулж төлөвлөдөг гэж заасан (АДБОУС 300, 3.5.1). Байгууллагын дотоод хяналтын тогтолцоог болон хяналтын тогтолцоо нь зөрчлийн тохиолдлуудыг олж илрүүлэх эсвэл урьдчилан сэргийлэх боломжгүй байх эрсдэлийг үнэлэх зэрэг нь нийцлийн аудитын нийтлэг хэсэг юм (АДБОУС 300, 3.4.6).
96. Гүйцэтгэх аудитын горимууд тогтоосон тодорхой шалгах асуудал ба шалгуурууд мөн түүнчлэн аудиторын мэргэжлийн үнэлэмжээс ихээхэн хамаарна. Горимууд нь тогтоосон эрсдлүүдтэй тодорхой уялдсан байх ёстой. Зөрчлийн эрсдлүүд нь ноцтой бөгөөд төрийн аудиторууд байгаа хяналтууд дээр түшиглэхээр төлөвлөж байгаа тохиолдолд эдгээр хяналтуудыг сорих ёстой. Хяналтуудыг найдвартай биш гэж үзсэн тохиолдолд төрийн аудиторууд тогтоосон эрсдэлд хариу үзүүлэх нарийвчилсан горимуудыг төлөвлөж, гүйцэтгэнэ. Түүнчлэн зөрчлийн ноцтой эрсдлүүд байгаа нөхцөлд нэмэлт нарийвчилсан горимуудыг гүйцэтгэдэг. Хэрэв аудитын арга хандлага нь зөвхөн нарийвчилсан горимуудаас бүрдэж байвал хэсэг зүйлсдийн буюу дэлгэрэнгүй сорилуудыг (зөвхөн шинжилгээний сорилууд бус) гүйцэтгэнэ.
97. Зарим цөөн тохиолдолд дүгнэлт гаргахын тулд хангалттай ба зохистой аудитын нотолгоог олж авах нь хүндрэлтэй эсвэл бараг дийлшгүй үнэтэй байж болно. Ийм тохиолдолд төрийн аудиторууд нотолгоог цуглуулахад гарах зардал ба цуглуулсны үр өгөөж хоёрын хоорондын харилцаа холбоог мөн түүнчлэн хангалттай ба зохистой нотолгоо дутмагаас аудиторын тайлан ба аудитын зорилгод хүрэхэд нөлөөлөх үр дагаврыг анхаарч үзэх ёстой. Энэ нөхцөл байдал дахь аудиторын хариу үйлдэл нь бүрэн эрх, олон нийтийн ашиг сонирхлын анхаарах зүйлс, олон нийтийн хүлээлт ба эдгээр илрүүлэлтийг тайлагнах ур чадвар зэргээс хамаарч харилцан адилгүй байж болно. Аудитор энэ асуудлын талаар хууль тогтоох байгууллага эсвэл бусад зорилтот хэрэглэгчдэд тусгайлан тайлагнах шаардлагатай гэж үзэж болно. Гэхдээ ийм хүндрэлтэй байдал эсвэл зардал нь төлөвлөсөн нотолгоо цуглуулах горимуудыг үл хайхрах хангалттай үндэслэл биш юм.

98. Сонгосон шалгах асуудалд ашиглах нийцлийн аудитын горимуудын зарим жишээг Хавсралт 5-д тусгасан.

7.1 Нотолгоог цуглуулах ба үнэлэх

99. Үндэслэлтэй баталгаажуулалтын аудитыг гүйцэтгэхэд төрийн аудиторуд аудиторын дүгнэлтийн суурь болох хангалттай ба зохистой аудитын нотолгоог цуглуулна. Аудитын үндсэн зарчмуудад “аудит хийгдэж буй байгууллага, хөтөлбөр, үйл ажиллагаа эсвэл чиг үүрэгтэй холбоотой аудиторын үнэлэмж ба дүгнэлтийг дэмжих шаардлага хангасан, учир холбогдолтой ба ул үндэслэлтэй нотолгоог цуглуулах ёстой” гэж заасан байдаг (АДБОУС 300, 3.5.1).

100. Нотлох зүйлсийн хангалттай байдал нь нотлох зүйлсийн тоо хэмжээтэй холбоотой. Нотлох зүйлсийн шаардлага хангасан, учир холбогдолтой, найдвартай ба зохистой байдал нь нотлох зүйлсийн чанартай холбоотой. Төрийн салбарын нотлох зүйлсийг цуглуулах үйл явцын туршид хангалттай ба зохистой байдлыг тодорхойлохдоо мэргэжлийн үнэлэмжийг гаргана.

101. Нотлох зүйлсийг цуглуулах үйл явц нь системтэй, давтагддаг ба дараах үе шатуудыг хамарна. Үүнд:

А) Тохиромжтой аудитын горимуудыг гүйцэтгэн нотолгоог цуглуулах

Б) Цуглуулсан нотолгооны хангалттай байдал (тоо хэмжээ) ба зохистой байдал (чанар)-уудыг үнэлэх

В) Эрсдэлийг дахин үнэлж, шаардлагатай нэмэлт нотолгоог цуглуулах

102. Нотлох зүйлсийг цуглуулах үйл явц нь аудиторын дүгнэлтийн суурь болох хангалттай ба зохистой нотолгоо байна гэж төрийн аудиторуд үзэх хүртэл үргэлжилнэ.

103. Ихэнх тохиолдолд аудитын түүвэрлэлтийг хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдлуудыг олж илрүүлэхэд сорилын аргаар ашиглаж болно. МТ-ийн аудитын арга техникүүдийн хэрэглээ нь ихэвчлэн ашиг тустай байдаг бөгөөд ихэнх тохиолдолд нийцлийн аудитын цогц хэсэг юм.

104. Аудитын нотолгоог цуглуулах янз бүрийн арга техникүүдэд дараах аргууд багтана. Үүнд:

А) Ажиглалт

- Б) Хяналт шалгалт
- В) Асуулга
- Г) Дахин гүйцэтгэл
- Д) Баталгаажуулалт
- Е) Шинжилгээний горимууд гэх мэт

105. Нотолгоог цуглуулах горимуудыг ерөнхийд нь хоёр гол ангилалд хуваадаг. Үүнд:

- А) Хяналтын сорилууд
- Б) Шинжилгээний горимууд эсвэл дэлгэрэнгүй сорил зэрэг нарийвчилсан сорилууд

7.1.1 Ажиглалт

106. Ажиглалт нь гүйцэтгэж буй үйл ажиллагаа эсвэл горимуудыг хянах явдал юм. Нийцлийн аудитыг гүйцэтгэхэд тендер шалгаруулах үйл явц хэрхэн явагдаж байгааг хянах эсвэл тэтгэлгийн төлбөрийг хэрхэн боловсруулж буйг ажиглах зэрэг багтана.

7.1.2 Хяналт шалгалт

107. Хяналт шалгалт гэж бүртгэл хөтлөлт, баримт бичиг ба бусад баримтын файлууд эсвэл биет хөрөнгийг шалгахыг хэлэх ба үүнд төслийн хөрөнгийг хэрхэн бүртгэлд тусгасныг тодорхойлох бүртгэл хөтлөлт, баримт бичгүүдийг шалгах ба нягтлан бодох бүртгэлийг төслийн хэлэлцээрийн нөхцөлүүдтэй харьцуулах зэрэг багтана. Баримтын файлуудын хяналт шалгалт нь тэтгэлгийг хүлээн авагчид нь боломжит шаардлагуудыг хангасан эсэхийг тогтоох бүх холбогдох баримт бичгүүдийг шалгах юм. Мөн түүнчлэн хяналт шалгалтанд гүүр эсвэл барилга зэрэг хөрөнгийг холбогдох барилгын техникийн үзүүлэлттэй нийцэж байгаа эсэхийг тогтоох үйл явц хамаардаг.

108. Төрийн аудиторуд хянаж шалгасан ямар ч баримт бичгийнхээ найдвартай байдлыг анхаарч, шалгасан баримт бичгүүд баталгаатай биш байж болох магадлал болон залилангийн эрсдэлийг бодолцох нь зүйтэй. Залилангийн тохиолдолд хоёр өөр бүртгэл хөтлөлт ба баримт бичгүүдийг хөтөлдөг. Төрийн аудиторуд баримт бичгүүдийн эх сурвалж эсвэл тэдгээрийг бэлтгэх эсвэл ашиглах явцад тавигдах хяналт болгож өөр өөр хүмүүсээс асуулга авч болно.

7.1.3 Асуулга

109. Асуулга нь шалгагдагч байгууллагын доторх болон гаднах хүмүүсээс мэдээлэл эрэлхийлэх үйл явц юм. Асуулга нь албан ёсны бичгэн асуулгаас илүү албан бус аман хэлэлцүүлэг хүртэл хүрээг хамарч болно. Мөн түүнчлэн үүнд шинжээчид зэрэг холбогдох хүмүүсээс асуулт асуух ба ярилцлага хийх багтана. Ийм ярилцлагыг биечлэн эсвэл телефон утсаар эсвэл интернет хурал зэргээр хийж болно. Асуулгад асуулгын хуудас эсвэл судалгааг боловсруулж илгээх зэрэг үйл явц багтана.
110. Асуулгыг аудитын туршид өргөн хүрээтэй ашиглах ба энэ нь аудитын бусад горимуудад иж бүрдэл болгодог. Жишээлбэл, дээр дурдсан тэтгэлгийн төлбөрийн үйл явц зэрэг гүйцэтгэсэн үйл явцыг ажиглахад холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлт, шинэчлэлтүүдийг хэрхэн тодорхойлж, тайлбарласан талаар холбогдох хүмүүсээс асуулга авдаг. Асуулгын үр дүн нь зөрчлийн тохиолдлуудад чиглэж болохуйц өөр өөр арга замаар өөр өөр байршилд гүйцэтгэсэн үйл явцыг илэрхийлж болох юм.
111. Асуулгыг ихэвчлэн аудит хийгдэх гэж буй тухайн чиг үүргээс гадуур хүнээс авна. Жишээлбэл, нягтлан бодох бүртгэлийн ажилтнаас асуулга авахаас гадна хууль эрх зүйн эсвэл техникийн ажилтнуудаас бас асуулга авах нь учир холбогдолтой байж болох юм.
112. Асуулга нь ерөнхийдөө дангаараа хангалттай, зохистой нотолгоо биш юм. Хангалттай ба зохистой нотолгоог олж авахын тулд асуулга нь бусад төрлийн горимуудтай хамт хийгддэг. Асуулгыг холбогдох, мэдлэг бүхий хүмүүс, өөрөөр хэлбэл байгууллагын нэрийн өмнөөс ярих эсвэл санал дүгнэлтээ өгөх эрх олгогдсон эрх бүхий албан тушаалтнуудтай хийвэл хамгийн үр дүнтэй байдаг.

7.1.4 Баталгаажуулалт

113. Баталгаажуулалт гэдэг нь асуулгын нэг хэлбэр бөгөөд зарим нэг тодорхой асуудлуудтай холбоотойгоор шалгагдагч байгууллагаас хараат бусаар гуравдагч этгээдээс хариулт олж авах үйл явц юм. Нийцлийн аудитын явцад баталгаажуулалт нь аудитор буцалтгүй тусламж эсвэл бусад санхүүжилтийг хийсэн, эсвэл буцалтгүй тусламжийн эсвэл санхүүжилтийн хэлэлцээрийн нөхцөлд заасан тодорхой зорилгын дагуу хөрөнгийг зарцуулсан гэдгийг шалгагдагч байгууллагаас батлаж байгаа хүлээн авагч талаас шууд санал хүсэлт авах үйл явцыг хамарна. Мөн түүнчлэн баталгаажуулалтад хууль тогтоомжийн тусгай зүйл заалтыг хэрхэн тайлбарлах талаар хууль тогтоох байгууллагаас удирдамж авах үйл явц багтаж болно.

114. Бичгээрх баталгаажуулалтыг аудитын явцад аман мэдүүлэгтэй холбоотойгоор удирдлагаас олж авч болох юм. Эдгээр удирдлагын бичгээрх мэдүүлгүүдтэй холбоогтой байж болох зүйлээс дурдвал:

А) Холбогдох хууль тогтоомжийн зүйл заалтууд, хэлэлцээрийн нөхцөлүүд зэргийг дагаж мөрдсөн тухай удирдлагын батламж мэдэгдлүүд

Б) Мэдэж буй зөрчлийн бүх тохиолдлуудын талаарх удирдлагын тодруулга

В) Удирдлага аудиторыг шалгах асуудлын талаар иж бүрэн мэдээллээр хангах

7.1.5 Дахин гүйцэтгэл

115. Дахин гүйцэтгэл гэдэг нь шалгагдагч байгууллагын өмнө нь гүйцэтгэсэн ижил горимуудыг бие даан дахин гүйцэтгэх үйл явц юм. Дахин гүйцэтгэлийг гар аргаар эсвэл компьютерт суурилсан аудитын арга техникүүдээр гүйцэтгэж болно. Жишээлбэл, шалгагдагч байгууллага үнэн зөв шийдвэр гаргасан эсвэл холбогдох шалгуурын дагуу зохистой үйлчилгээгээр хангасан эсэхийг шалгахдаа баримтуудын файлуудыг судалж шалгана. Олгосон виз эсвэл байнга оршин суух эрх, эсвэл төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн зохистой байдлыг шалгахдаа үйл явцын үе шатуудыг дахин гүйцэтгэж болох юм. Хэрэв хүүхдийн тэтгэмжийн төлбөрийг хийх шалгуурт тодорхой наснаас доош насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд төлбөрийг хийх багтаж байвал шалгагдагч байгууллага улсын мэдээллийн сангаас хүлээн авагчдыг сонгосон үйл явцыг төрийн аудиторууд байгууллагын үйл явцын үнэн зөв байдлыг шалгахын тулд компьютерт суурилсан аудитын арга техникүүдийг ашиглан дахин гүйцэтгэнэ. Мөн тендерийн үйл явцад санал сонгож шалгаруулах нь тодорхой шалгуураас хамаардаг бол үнэн зөв саналыг шалгаруулсан эсэхийг шалгахын тулд санал шалгаруулах үйл явцыг дахин гүйцэтгэнэ. Маш нарийн мэргэжлийн асуудлуудыг хамарсан тохиолдолд (жишээлбэл, тэтгэврийн тооцоолол эсвэл инженерийн загваруудыг дахин гүйцэтгэх) мэргэжлийн шинжээч нарыг оролцуулж болно.

7.1.6 Шинжилгээний горимууд

116. Шинжилгээний горимд зөрчилтэй холбоо хамаарал эсвэл хэлбэлзлийг хянан шалгах, эсвэл мэдээллийг харьцуулах үйл явц багтдаг. Нийцлийн аудитын явцад эдгээр горимуудад, жишээлбэл, нэг жилээс дараагийн жилд тэтгэврийн тэтгэмжийн төлбөрийн өсөлтийг өнгөрсөн жилд тэтгэврийн насанд хүрсэн иргэдийн тоо зэрэг хүн амийн мэдээлэлтэй харьцуулах зэрэг үйл явц багтаж болох юм. Хэрэв шалгуурууд нь, жишээлбэл, ажилд авсан хүний тоо зэрэг үр дүнгийн түвшинд үндэслэж төслийн санхүүжилтээр хангана гэсэн хэлэлцээрийн нөхцөлүүдтэй холбоотой нөхцөлд төслийн санхүүжилтэд гарсан ямар нэг өөрчлөлтийг боловсон хүчний статистик мэдээллийн өөрчлөлттэй харьцуулна.

117. Регрессийн шинжилгээний арга техник эсвэл бусад математикийн аргууд төрийн аудиторуудад бодит байдлыг хүлээж буй үр дүнтэй харьцуулахад тусладаг.

118. Нотолгоо ба нотлох зүйлсийг цуглуулах горимуудын талаарх нэмэлт удирдамжийг дараах баримт бичгүүдээс олж болно. Үүнд:

- АДБОУС 1330, 1450, 1500, 1505, 1520, 1530, 1610 ба 1620
- ИНТОСАИ-н Гүйцэтгэлийн аудитыг гүйцэтгэх гарын авлагын 4-р хэсэг ба Хавсралт 3
- НБОУХ-ны баталгаажуулалтын үзэл баримтлал ба БГАОУС 3000

7.2 Баримтжуулалт

119. Аудитын үндсэн зарчмуудад цуглуулсан аудитын нотолгоог хангалттай баримтжуулж байх ёстой гэж заасан байдаг (АДБОУС 300, 3.5.5 ба 3.5.6). Нийцлийн аудиттай холбоотой баримтжуулалтанд гаргасан дүгнэлт болон тайланг дэмжих нотолгоогоор хангахад чухал ач холбогдол бүхий асуудлуудыг хангалттай баримтжуулах багтана. Аудитын баримтжуулалт нь хангалттай иж бүрэн ба уг аудитын хувьд өмнө нь холбоогүй боловч туршлагатай аудитор дүгнэлтийг дэмжих ямар ажил гүйцэтгэснийг ойлгохуйц дэлгэрэнгүй байх ёстой (АДБОУС 300, 3.5.7).

120. Баримтжуулалт нь аудитын бүхий л үйл явцын туршид хийгдэнэ. Төрийн аудиторууд нийцлийн аудитын баримтжуулалтыг цаг хугацаанд нь бэлтгэдэг ба ашигласан шалгуурууд, хийсэн ажил, олж авсан нотолгоо, гаргасан үнэлэмж ба гүйцэтгэсэн хяналтуудыг бүртгэх энэ баримтжуулалтыг тогтмол хийнэ. Төрийн аудиторууд аудиторын тайланг гаргахаасаа өмнө холбогдох аудитын баримтжуулалтыг бэлтгэдэг. Аудитын баримтжуулалтыг тодорхой хугацаанд хадгална.

121. Нийцлийн аудитыг баримтжуулах тухай нэмэлт удирдамжийг дараах баримт бичгүүдээс олж болно. Үүнд:

- АДБОУС 1230
- ИНТОСАИ-н Гүйцэтгэлийн аудитыг гүйцэтгэх гарын авлагын Хавсралт 3
- НБОУХ-ны БГАОУС 3000

7.3 Харилцаа холбоо

122. Аудитын туршид шалгагдагч байгууллагатай сайн харилцаа холбоотой байх нь үйл явцыг илүү үр дүнтэй, бүтээлч болгоход туслаж болох юм. Харилцаа

холбоо нь янз бүрийн үе шатанд болон янз бүрийн түвшинд явагддаг, жишээлбэл:

А) Хууль тогтоомжийн хязгаарлалтын хүрээнд – аудитын стратеги, хугацаа, логистик, үүрэг хариуцлага, тохиромжтой аудитын шалгуурууд ба төлөвлөлтийн бусад элементүүдийн талаар - харгалзах түвшний удирдлага болон засаглал хариуцсан этгээдтэй хэлэлцүүлэг хийх зэрэг үндсэн төлөвлөлтийн үе шатанд

Б) Нотолгоо цуглуулах ба тохиромжтой тохиолдолд холбогдох хүмүүсээс асуулга авах зэрэг гүйцэтгэлийн үе шат буюу аудитын туршид. Аудитын явцад тулгарсан томоохон хүндрэлүүд, мөн түүнчлэн материаллаг зөрчлийн тохиолдлуудыг тохирох түвшний удирдлага эсвэл засаглал хариуцсан этгээдэд түргэн шуурхай мэдээлнэ. Материаллаг бус гэж үзсэн эсвэл төрийн аудиторын тайланд ороогүй бусад ач холбогдол бага илрүүлэлтийг аудитын явцад удирдлагад мэдээлж бас болно. Эдгээр ач холбогдол багатай илрүүлэлтийг мэдээлэх нь шалгагдагч байгууллагад зөрчлийн тохиолдлыг залруулах ба цаашид төстэй тохиолдлоос урьдчилан сэргийлэхэд туслаж болох юм. Иймээс олон төрийн салбарын аудиторууд тогтоосон бүх зөрчлийн тохиолдлуудыг удирдлагад мэдээлдэг.

В) Тайлагналын үе шатанд зорилтот хэрэглэгчид, шалгагдагч байгууллага болон тохиромжтой бол бусад хэрэглэгчдэд бичгээр тайлан цаг хугацаанд нь гаргаж өгөх.

123. Зарим АДБ-ууд бүрэн эрхийнхээ дагуу тогтоосон зөрчлийн тохиолдлуудыг засаж залруулахыг шалгагдагч байгууллагад тушааж чадна. Ингэхдээ төрийн аудиторууд тэдний хараат бус ба бодитой байдалд нөлөөлөх эсэхийг тогтоох ба эдгээр нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх тохиромжтой арга хэмжээг авна.

124. Харилцаа холбооны талаар нэмэлт удирдамжийг дараах баримт бичгүүдээс олж болно. Үүнд:

- АДБОУС 1260
- ИНТОСАИ-н Гүйцэтгэлийн аудитыг гүйцэтгэх гарын авлагын Хавсралт 4
- НБОУХ-ны БГАОУС 3000

7.4 Сэжиг бүхий хууль бус үйлдлийг тайлагнахтай холбоотой анхаарах зүйлс

125. Нийцлийн аудитыг гүйцэтгэх гол зорилт бус залилан зэрэг нуугдмал хууль бус үйлдлийг олж илрүүлэхдээ төрийн аудиторууд эрсдэлийн үнэлгээндээ залилангийн эрсдэлийн хүчин зүйлсийг хамруулдаг ба өөрсдийн ажлаа гүйцэтгэхдээ залилан гэх мэт хууль бус үйлдлийн шинж тэмдэгт болгоомжтой хандана.

126. Нийцлийн аудитыг гүйцэтгэхдээ хэрэв төрийн аудиторууд хууль бус үйлдэл эсвэл залилангийн шинж тэмдэг бүхий зөрчлийн тохиолдлуудтай тулгарвал тэд ирээдүйн боломжит шүүхийн үйл явц эсвэл мөрдөн байцаалтанд хөндлөнгөөс оролцохгүйн тулд мэргэжлийн ур дүйтэй ба болгоомжтой ажиллана. Төрийн аудиторууд хуулийн зөвлөх эсвэл холбогдох захиргааны эрх бүхий байгууллагатай зөвлөлдөх талаар харгалзаж үзэж болно (АДБОУС 300, 3.4.7). Түүнчлэн тэд өөрсдийн сэжиг таамгын талаар харгалзах түвшний удирдлага эсвэл засаглал хариуцсан этгээдэд мэдээлж, холбогдох арга хэмжээг авсан эсэхийг магадлах дараачийн арга хэмжээг авч болно. Олон улсын түвшинд өөр өөр бүрэн эрх, зохион байгуулалтын бүтэцтэй байдаг учраас залилан эсвэл ноцтой алдаа дутагдалтай холбоотой зөрчлийн тохиолдлуудын хувьд авч хэрэгжүүлэх тохиромжтой арга хэмжээг АДБ өөрөө шийднэ (АДБОУС 400, 4.0.7б).
127. Аудитын уламжлалт эрсдлээс хамааран залилан, авилга эсвэл хулгай зэрэг хууль бус үйлдэл гарч болох болон төрийн аудиторууд тэдгээрийг олж илрүүлэхгүй байх зайлшгүй эрсдэл байдаг. Залилан гэдэгт оршин байгаа зүйлийг санаатайгаар нуун далдлахад төлөвлөгдсөн үйлдэл хамаарч болно. Удирдлага, ажилчид эсвэл гуравдагч талуудын хооронд хуйвалдаан эсвэл хуурамчаар үйлдсэн баримт бичгүүд байж болно. Жишээлбэл, буцалтгүй тусламж ба тэтгэлгийн нэхэмжлэлүүдийг дэмжих хуурамч баримт бичгүүдийг, хэрэв тэдгээр нь илт илэрхий хуурамч биш бол, хуурамч гэдгийг нь тогтоохыг төрийн аудиторуудаас шаардах нь үндэслэлгүй юм. Мөн түүнчлэн ийм зарга үүсгэн хувь хүн эсвэл байгууллагуудад хандан мөрдөн байцаах эрх эсвэл бүрэн эрх төрийн аудиторуудад байхгүй.
128. Зөвхөн шүүх л тухайн ажил гүйлгээ хууль бус эсэхийг тогтоож чадна. Төрийн аудиторууд хууль бус үйлдэл гарсан эсэхийг тогтоохгүй ч гэсэн холбогдох ажил гүйлгээ харгалзах хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэхэд үнэлгээ өгөх эрхтэй.
129. Залилангийн ажил гүйлгээ нь мөн чанараараа холбогдох хууль тогтоомжтой нийцдэггүй. Төрийн аудиторууд залилан гэж нотлогдоогүй ч сэжиглэгдэж буй ажил гүйлгээг холбогдох хууль тогтоомжтой нийцэхгүй байгааг тогтоож болно. Материаллаг хууль бус үйлдэл нь ихэвчлэн аудиторын дүгнэлт эсвэл тайланд тодруулга оруулахад хүргэдэг.
130. Хэрэв аудитын явцад хууль бус үйлдэл сэжиглэгдвэл хуулиар зөвшөөрсөн тохиолдолд төрийн аудиторууд харгалзах түвшний удирдлага болон засаглал хариуцсан этгээдэд мэдээлж болно. Энэ тохиолдолд засаглал хариуцсан этгээд нь тайлагналын шатлал дахь дээд түвшний яам эсвэл захиргааны

байгууллагууд байвал зохино. Удирдлага эсвэл засаглал хариуцсан этгээд сэжиглэж буй үйлдлийн хариуд, жишээлбэл тухайн тохиолдлыг холбогдох хууль хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад тайлагнах зэрэг тохиромжтой арга хэмжээг авсан эсэхийг төрийн аудиторуд магадлах ба дараачийн арга хэмжээг авна. Төрийн аудиторуд эдгээр тохиолдлуудыг шууд хууль хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад тайлагнаж бас болно.

131. Сэжиг бүхий залиланг авч үзэхдээ анхаарах зүйлсийн талаар нэмэлт удирдамжийг дараах баримт бичгүүдээс олж болно. Үүнд:

- АДБОУС 1240
- ИНТОСАИ-н Гүйцэтгэлийн аудитыг гүйцэтгэх гарын авлагын 3-р хэсэг
Дэд бүлэг – Хууль тогтоомжийн нийцэл

8 Нотолгоог үнэлэх ба дүгнэлт гаргах

8.1 Нотолгоог үнэлэх ба дүгнэлт гаргахад ерөнхий анхаарах зүйлс

132. Төрийн аудиторуд олж авсан нотолгоо нь аудитын эрсдэлийг боломжит доод түвшин хүртэл багасгахад хангалттай ба зохистой байгаа эсэхийг үнэлнэ. Энэ үнэлгээнд мэргэжлийн үнэлэмж ба үл итгэх байр суурийг гаргах ба зөрчилдөж буй шалгах асуудлын мэдээллийг дэмжих нотолгоог харгалзаж үзэх зэрэг багтана.

133. Материаллаг зөрчлийн гарч болзошгүй тохиолдлуудыг тогтоохын тулд олж авсан нотолгоог тогтоосон материаллаг түвшинтэй холбоотой үнэлнэ. Илрүүлэлтийн ач холбогдлыг тодорхойлохдоо дээр заасан материаллаг байдлын ойлголт дээр үндэслэнэ. Нийцлийн аудитын илрүүлэлтүүдийг зүй зохистой үзэл баримтлалд хуваарилах ёстой, жишээлбэл тайлагнасан зөрчлийн тохиолдлууд нь зөрчлийн тохиолдлуудын тоо хэмжээ эсвэл холбогдох мөнгөн дүн дээр үндэслэж болно (АДБОУС 400, 4.0.19). Тооцооны Шүүхийн орчинд үйл ажиллагаа явуулж буй АДБ-ууд данс тооцоон дээр үнэлэмж шийдвэр гаргах хууль ёсны эрхтэй байна. Зөрчлийн тохиолдлуудад үүнд нөхөн төлбөр, мөнгөн торгууль эсвэл бусад торгуулиудыг оногдуулах зэрэг орж болно.

134. Олж авсан нотолгоон дээр үндэслэн төрийн аудиторуд шалгах асуудлын мэдээллийг бүх материаллаг байдлын хувьд тогтоосон шалгууруудтай нийцэж байгаа үндэслэлтэй баталгаажуулалт байгаа эсэхийг үнэлнэ. Аудитын уламжлалт хязгаарлалтуудаас хамааран зөрчлийн бүх тохиолдлуудыг олж илрүүлэхийг төрийн аудиторудад шаардаж болохгүй.

135. Юуг материаллаг нийцлийн хэлбэлзэл гэж илэрхийлэх талаарх төрийн аудиторудын үнэлгээ нь мэргэжлийн үнэлэмжийн асуудал бөгөөд ажил гүйлгээ

эсвэл тухайлсан асуудлын тоон болон чанарын ухагдахууны хүрээг харгалзаж үзэх үүнд багтана.

136. Зөрчил нь материаллаг эсвэл материаллаг бус байгааг тогтооход мэргэжлийн үнэлэмжийг гаргахдаа хэд хэдэн хүчин зүйлсийг анхаарч үзнэ. Эдгээр хүчин зүйлээс дурдвал:

А) Холбогдох дүн хэмжээний ач холбогдол (мөнгөн дүн эсвэл холбогдох ард иргэд эсвэл байгууллагуудын тоо зэрэг бусад тоон хэмжүүрүүд, нүүрстөрөгч ялгаруулалтын түвшин, эцсийн хугацаатай холбоотой хугацаа хойшлуулалт гэх мэт)

Б) Нөхцөл байдлууд

В) Зөрчлийн мөн чанар

Г) Зөрчилд хүргэж буй учир шалтгаанууд

Д) Зөрчлөөс гарч болзошгүй үр нөлөө ба үр дагаврууд

Е) Шалгаж буй хөтөлбөрийн ялгаатай ба мэдрэмтгий байдал (жишээлбэл, олон нийтийн ашиг сонирхлын чухал асуудал мөн үү, эмзэг бүлэгт нөлөөлж байна уу, гэх мэт)

Ё) Хууль тогтоох байгууллага, олон нийт эсвэл аудитын тайлангийн бусад хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлага ба хүлээлт

Ж) Холбогдох эрх бүхий байгууллагын мөн чанар

З) Зөрчлийн хэмжээ эсвэл мөнгөн үнэ цэнэ

137. Материаллаг байдал ба дүгнэлт гаргахтай холбоотой анхаарах зүйлс болон нийцлийн хэлбэлзлийн зарим жишээнүүдийг Хавсралт 6-т тусгасан.

138. Дүгнэлт гаргах талаарх нэмэлт удирдамжийг дараах баримт бичгүүдээс олж болно. Үүнд:

- АДБОУС 1700
- ИНТОСАИ-н Гүйцэтгэлийн аудитыг гүйцэтгэх гарын авлагын 4.5-р хэсэг
- НБОУХ-ны БГАОУС 3000

8.2 Хариуцаж буй албан тушаалтнуудын бичгээрх тайлбар мэдүүлэг

139. Нотолгоог цуглуулах ба дүгнэлт гаргах явцад шаардлагатай гэж үзсэн тохиолдолд төрийн аудиторуудын олж авсан аудитын нотолгоог дэмжих бичгээрх тайлбар мэдүүлгийг олж авч болох юм. Эдгээр бичгээрх тайлбар мэдүүлгүүдэд байгууллагын санхүүгийн тайланд тусгагдсан үйл ажиллагаа, санхүүгийн ажил гүйлгээ ба мэдээлэл нь хууль тогтоомжид нийцсэн эсвэл тухайн хяналтын тогтолцоо нь аудитын туршид үр өгөөжтэй явагдсан зэргийг тусгаж болно.
140. Бичгээрх тайлбар мэдүүлгийн талаарх нэмэлт удирдамжийг АДБОУС 1580-т тусгасан.

8.3 Хойшхи үйл явдал

141. Төрийн аудиторууд нийцлийн аудитын тайлангийн хугацаа хүртэл болон талбарын ажил дууссаны дараа материаллаг зөрчил байж болзошгүй үйл явдал гарсан эсэхийг тодорхойлох аудитын горимуудыг гүйцэтгэх ба тиймээс тусгай тодруулгыг шаардах эсвэл аудиторын дүгнэлт эсвэл тайланд нөлөөлж болох юм. Эдгээр горимуудад ихэвчлэн асуулга, удирдлагаас бичгээрх тайлбар мэдүүлэг олж авах эсвэл холбогдох уялдаа холбоог хянах, хурлын тэмдэглэлүүд, хэвлэгдсэн тайлангууд, эсвэл хойшхи хугацааны санхүүгийн мэдээлэл (сарын, улирлын) гэх мэт багтана. Хойшхи үйл явдлын үр дүн нь холбогдох асуудлуудын мөн чанар ба талбарын ажил дууссан хугацаа болон тайлан гарсан хугацаа хоорондын хугацаанаас хамаарна.
142. Хойшхи үйл явдлын талаар нэмэлт удирдамжийг дараах баримт бичгүүдээс олж болно. Үүнд:
- АДБОУС 1560
 - НБОУХ-ны БГАОУС 3000

9 Тайлагнал

143. Тайлагнал нь төрийн аудитын үндсэн хэсэг бөгөөд үүнд хэлбэлзэл болон зөрчлүүдийг тайлагнах багтах ба ингэснээр тэдгээрийг залруулах арга хэмжээг авч, хариуцагч этгээдүүд үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээнэ. Энэ зорилгын дагуу Аудитын үндсэн зарчмуудад илрүүлэлтийг тохиромжтой хэлбэрээр тусгасан бичгээр илэрхийлсэн тайланг аудит бүрийн эцэст боловсруулах ёстой гэж заасан байдаг (АДБОУС 400, 4.0.7а).
144. Иж бүрэн, бодитой ба цаг хугацаандаа байх байдлын зарчмууд нь нийцлийн аудитыг тайлагнахад чухал юм. Төрийн аудиторууд бэлтгэгдсэн тайлан нь үнэн зөв баримт бүхий ба илрүүлэлтүүд нь зүй зохистой үзэл баримтлалаар,

тэнцвэртэй байдлаар бэлтгэгдсэн зэргийг баталгаажуулахад анхаарна. Үүнд бодит баримтыг шалгах ба тохиромжтой тохиолдолд хариуцаж буй албан тушаалтнуудын хариултуудыг оруулах зэрэг няцаалтын зарчмыг хэрэглэнэ.

9.1 Нийцлийн аудитын тайлангийн хэлбэр ба агуулга

145. Бичгээр илэрхийлсэн тайлангийн хэлбэр нь нөхцөл байдлаас хамааран харилцан адилгүй байж болно. Гэхдээ аудиторын тайлангийн зарим тогтвортой байдал нь тайлангийн хэрэглэгчдэд аудитын ажлыг ойлгох, хүрсэн үр дүн ба энгийн бус нөхцөл байдал үүсэхэд нь таньж тогтооход туслаж болох юм.
146. Нийцлийн аудитын тайлангийн хэлбэрт нөлөөлж болохуйц хүчин зүйлс их олон юм. Эдгээр хүчин зүйлсээс заримыг нь дурдвал, АДБ-ын бүрэн эрх, холбогдох хууль тогтоомж ба дүрэм журам, тухайлсан нийцлийн аудитын зорилго, уламжлалт тайлагналын туршлага ба тайлагнасан асуудлын нарийн төвөгтэй байдал зэрэг багтана. Мөн түүнчлэн тайлангийн хэлбэр нь зорилтот хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлага, түүний дотор тайланг хууль тогтоох байгууллага эсвэл хандивлагч байгууллагууд, олон улсын эсвэл бүсийн байгууллагууд, эсвэл санхүүгийн байгууллагууд зэрэг бусад гуравдагч талуудад өргөн барих эсэх зэргээс хамаарч болно.
147. Дээр дурдсан хүчин зүйлүүдээс хамааран АДБ нь товч эсвэл дэлгэрэнгүй тайлангийн аль нь тохиромжтой болохыг сонгож болно. Дэлгэрэнгүй тайлан нь ерөнхийдөө (зарим тохиолдолд “нийцлийн аудитын тусгай тайлан” гэж нэрлэгддэг) боломжит үр дагавар болон бүтээлч зөвлөмж бүхий аудитын илрүүлэлт ба дүгнэлтийг дэлгэрэнгүй тайлбарласан байдаг бол товч тайлан нь илүү товч бөгөөд ихэвчлэн илүү стандартчилсан хэлбэртэй байдаг. Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хамтран гүйцэтгэх үед нийцлийн талаарх дүгнэлт нь санхүүгийн тайлангийн аудитын талаарх аудиторын тайлангийн нэг хэсгийг бүрдүүлж болно. Ийм тохиолдолд нийцлийн талаарх дүгнэлт нь санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлт болон АОУС 700-д тусгасан “бусад хууль болон дүрэм журмын шаардлагын илтгэл” зэргээс тодорхой ялгарна.
148. Тайлангийн хэлбэр ба агуулгын талаарх удирдамжийг дор тусгасан. Энэ гарын авлагын практикийн зорилгоор Хавсралт 7-12-г тусгасан тайлбар жишээнүүд нь товч хэлбэрийн тайлан юм. Дэлгэрэнгүй тайлангийн дэлгэрэнгүй мөн чанараас хамааран гарын авлагад тусгай жишээнүүдийг тусгаагүй болно.
149. Энэ гарын авлагад урьдчилан зааснаас ялгаатай тайлагналын хэлбэрийг АДБ-ын бүрэн эрхээр бий болгож байгаа тохиолдолд ч энэхүү гарын авлага нь

төрийн аудиторуудад хэрэгцээтэй байж болох ба тухайлсан нөхцөл байдалд тохиромжтой байдлаар тохируулан ашиглаж болох юм.

9.1.1 Нийцлийн аудитын тайлан

150. Ерөнхийдөө нийцлийн аудитын тайланд дараах элементүүд (гэхдээ дараах дэс дарааллаар байх шаардлагагүй) багтана. Үүнд:

1. Гарчиг
2. Хүлээн авагчийн хаяг
3. Аудитын зорилтууд ба хамрах хүрээ, түүний дотор хамарсан хугацаа
4. Шалгах асуудлын мэдээллүүдийн тодорхойлолт (тохиромжтой тохиолдолд, шалгах асуудлууд)
5. Тогтоосон шалгуурууд
6. Янз бүрийн талуудын үүрэг хариуцлага (хууль эрх зүйн үндэс)
7. Ажлын гүйцэтгэхэд ашигласан аудитын стандартуудын тодорхойлолт
8. Гүйцэтгэсэн ажлын хураангуй
9. Дүгнэлт
10. Шалгагдагч байгууллагаас өгсөн хариу
11. Зөвлөмжүүд (тохиромжтой тохиолдолд)
12. Тайлангийн огноо
13. Гарын үсэг

151. Төрийн аудиторууд чухал ач холбогдол өгөх ёстой нийцлийн аудитын тайлангийн элементүүдийн удирдамжийг дор тусгав.

9.1.1.1 Тогтоосон шалгуурууд

152. Шалгах асуудлуудыг үнэлэхэд ашигласан шалгууруудыг аудиторын тайланд тодорхойлно. Нийцлийн аудитыг гүйцэтгэх явцад шалгуурууд нь аудитаас аудитад харилцан адилгүй байж болно. Нийцлийн аудитын тайланд

шалгууруудыг ойлгомжтой тодорхойлох нь тайлангийн хэрэглэгчид төрийн аудитуудын ажил ба дүгнэлтийн үндэслэлийг ойлгоход чухал юм. Шалгууруудыг тайланд тусгах эсвэл хэрэв удирдлагын батламж мэдэгдэлд тусгасан бол шалгууруудыг тайланд дурдаж тайлбарлаж болох ба эсвэл бусад тохиолдолд хүртээмжтэй, найдвартай эх сурвалжаас олох боломжтой байна.

153. Шалгууруудыг амархан тогтоох боломжгүй эсвэл холбогдох эх сурвалжаас тодорхойлох шаардлагатай тохиолдолд аудитад ашигласан шалгууруудыг аудиторын тайлангийн холбогдох хэсэгт тодорхой тусгана. Шалгуурууд зөрчилдөж буй тохиолдолд зөрчилдөөнийг тайлбарлана. Ийм тохиолдолд нөхцөл байдлаас гарч болохуйц үр дагавруудыг боломжийн хирээр тохиромжтой бол өгсөн зөвлөмжийг тайлбарлана.

9.1.1.2 Санал ба дүгнэлт

154. Үндэслэлтэй баталгаажуулалтын аудитын үндэслэн нийцлийг шалгасан зүйлүүдийн хувьд санал дүгнэлт нь эерэг баталгаажуулалтын мэдэгдлээр тодорхой илэрхийлэгдэнэ. Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хамтран гүйцэтгэх үед санал нь дүгнэлтийн хэлбэрээр байж болно (санхүүгийн аудиттай хамаатай нийцлийн аудитын тайлагналын талаар доорх хэсгийг харна уу). Найруулгын мөн чанарт АДБ-ын бүрэн эрх ба аудитыг гүйцэтгэж буй хууль эрх зүйн орчин зэрэг нөлөөлж болно.

155. Зөрчлийн материаллаг бус тохиолдлуудыг тогтоосон үед санал дүгнэлт нь хязгаарлалтгүй байна. Хязгаарлалтгүй санал ба дүгнэлтийн хэлбэрийн жишээ нь (тохиромжтой үг сонголтыг тохирох хаалтанд оруулна) дараах хэлбэртэй байж болно: “Гүйцэтгэсэн аудитын ажил дээр үндэслэн бид /шалгагдагч байгууллагын шалгах асуудлын мэдээлэл/нь бүх материаллаг байдлын хувьд хэрэглэсэн шалгаруудтай нийцэж байгааг олж илрүүлээ.”

156. Төрийн аудитор дараах тохиолдлуудад санал дүгнэлтээ тохиромжтой байдлаар өөрчилнө. Үүнд:

А) Зөрчлийн материаллаг тохиолдлууд. Зөрчлийн хэмжээнээс хамааран дараах дүгнэлтүүдэд хүрч болох юм.

- i. Хязгаарлалттай санал эсвэл дүгнэлт (“Бид гүйцэтгэсэн аудитын ажил дээр үндэслэн, [онцлох зүйлийг тайлбарлах] эс тооцвол, шалгагдагч байгууллагын шалгах асуудлын мэдээлэл нь бүх материалын байдлын хувьд [хэрэглэсэн шалгуурууд]-тай.....нийцэж байгааг олж илрүүлээ.”), эсвэл

- ii. Сөрөг санал эсвэл дүгнэлт (“Гүйцэтгэсэн аудитын ажил дээр үндэслэн бид шалгах асуудлын мэдээлэл нь нийцээгүй байгааг олж илрүүллээ”); эсвэл

Б) Хамрах хүрээний хязгаарлалттай байдал. Хязгаарлалтын хэмжээнээс хамааран дараах дүгнэлтүүдэд хүрч болно.

- i. Хязгаарлалттай санал эсвэл дүгнэлт (“Бид гүйцэтгэсэн аудитын ажил дээр үндэслэн, [онцлох зүйлийг тайлбарлах] эс тооцвол, шалгагдагч байгууллагын шалгах асуудлын мэдээлэл нь бүх материалын байдлын хувьд [хэрэглэсэн шалгуурууд]-тай.....нийцэж байгааг олж илрүүллээ.”), эсвэл
- ii. Дүгнэлт өгөхөөс татгалзах (“Гүйцэтгэсэн аудитын ажил дээр үндэслэн бид аудитын дүгнэлт гаргахад суурилах аудитын хангалттай зохистой нотолгоог олж авах боломжгүй байсан тул дүгнэлт өгөхөөс татгалзаж байна”)

157. Төрийн аудиторууд өөрлөлттэй дүгнэлтийнхээ шалтгаан болгож мэдээллээр хангана. Үүнийг тайлан дахь ноцтой зөрчлийн тодорхой тохиолдлуудыг замаар хийж болно, жишээлбэл дүгнэлтийн дараагийн догол мөр эсвэл хэсэгт, дүгнэлтийн үндэслэлийг тайлбарлах

158. Төрийн аудиторууд нийцлийн талаарх санал эсвэл дүгнэлтэд нөлөөлөхгүй тухайлсан асуудлуудыг нарийвчлан үзэх шаардлагатай байна гэсэн дүгнэлтэнд хүрч болох юм. Ийм тохиолдлуудад төрийн аудиторууд эдгээр асуудлуудыг тодруулахдаа ашиглах зүйлсээс дурьдвал:

А) Асуудлыг онцолсон зүйл (Санхүүгийн тайланд толилуулсан ба тодруулсан асуудлууд нь материаллаг буруу илэрхийлэгдээгүй тохиолдолд, жишээлбэл ямар нэгэн зүйл хуультай нийцэж байгаа эсэхийг холбогдох эрх бүхий байгууллага хэзээ нэгэн цагт тодорхойлох ёстой зэрэг ирээдүйн үйл явдлаас хамааралтай тодорхой бус байдал эсвэл системийн сул талыг тодруулж өгөх; эсвэл

Б) Бусад асуудал зүйлүүд (Нийцлийн санал эсвэл дүгнэлтэд нөлөөлөхгүй санхүүгийн тайланд толилуулсан ба тодруулснаас бусад асуудлууд, жишээлбэл хуулийн өөр өөр эх сурвалжуудын хооронд зөрчил байгааг тогтоосон тохиолдолд хууль тогтоох байгууллагаас арга хэмжээ авах хэрэгцээ шаардлага)

Жишээнүүдыг Хавсралт 11-т тусгасан.

9.1.1.3 Шалгагдагч байгууллагаас ирүүлсэн хариу

159. Холбогдох албан тушаалтнуудын үзэл бодлыг тайлагнах замаар шалгагдагч байгууллагаас ирүүлсэн хариуг тайланд тусгах нь мэтгэлцээний зарчим гэж нэрлэгдэх зарчмын нэг хэсэг юм. Мэтгэлцээний зарчим нь төрийн аудитын өвөрмөц ба чухал онцлог юм. Энэ нь залруулгыг дэмжих байдлаар сул тал эсвэл ноцтой илрүүлэлтүүдийг толилуулахтай холбоотой (АДБОУС 400, 4.0.20 ба 4.0.24). Үүнд баримтуудыг иж бүрэн, үнэн зөв ба шударгаар илэрхийлэгдсэн гэдгийг баталгаажуулахад туслах зорилгоор шалгагдагч байгууллагуудтай зөвшилцөх хамаарна. Мөн түүнчлэн тохиромжтой тохиолдолд үүссэн асуудлуудтай холбоотой шалгагдагч байгууллагаас ирүүлсэн хариуг үгчилсэн эсвэл товчилсон хэлбэрээр тайланд тусгах нь үүнд хамаарч болно.

9.1.1.4 Бүтээлч зөвлөмжөөр хангах

160. Аудитын үндсэн зарчмуудад мөн тайлангуудыг бүтээлч байх шаардлагатайг онцолдог. Энэ нь аудиторын тайлангууд нь тохиромжтой тохиолдолд сайжруулалтанд хүрэхээр төлөвлөгдсөн зөвлөмжүүдийг тусгах гэсэн утгатай юм. Эдгээр зөвлөмжүүд нь шалгагдагч байгууллагын хувьд бүтээлч байж болох ч ирээдүйн аудитад төрийн аудиторуудын зорилтуудыг бууруулахуйц нарийвчилсан мөн чанартай байх ёсгүй (АДБОУС 400, 4.0.4, 4.0.20 ба 4.0.25)

9.1.1.5 Тайлангийн огноо

161. Тайлангийн огноо нь төрийн аудиторууд санал ба дүгнэлтийг дэмжих хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авсан өдрөөс өмнө тавигдаж болохгүй.

9.1.1.6 Гарын үсэг

162. Тайланг АДБ-ыг төлөөлөх холбогдох эрх бүхий хүн гарын үсэг зурж, баталгаажуулна. Энэ нь Ерөнхий аудитор, итгэмжлэгдсэн ажилтан, эсвэл холбогдох эрх бүхий хүнийг төлөөлж буй хоёр ажилтны хамтарсан гарын үсэг байж болох юм.

9.1.1.7 Хязгаарлагдмал баталгаажуулалтын тайлан

163. Энэхүү гарын авлага нь үндэслэлтэй баталгаажуулалтын аудитын үзэл баримтлалаар боловсруулагдсан. Гэхдээ зарим тохиолдолд хязгаарлагдмал баталгаажуулалтын хяналтад тохируулан ашиглаж болно. Энэ гарын авлагын хамрах хүрээ хэсэгт тайлбарласанчлан хязгаарлагдмал баталгаажуулалтын хяналтын үед дүгнэлт нь (хаалтанд тохиромжтой үг хэллэгийг оруулна) ихэвчлэн дараах байдлаар илэрхийлэгдэнэ: “[шалгагдагч байгууллагын шалгах асуудлын мэдээлэл” нь бүх материаллаг байдлын хувьд [хэрэглэсэн шалгуурууд]-тай нийцээгүй гэж итгэх ямар ч зүйл бидний анхаарлыг татаагүй болно.”

164. Хязгаарлагдмал баталгаажуулалтын хяналт нь дүгнэлт илэрхийлэхийн тулд хангалттай хэмжээний ажлыг гүйцэтгэхийг шаарддаг боловч үндэслэлтэй баталгаажуулалттай дүгнэлт илэрхийлэхэд шаардлагатай ажлаас бага юм. Гэхдээ төрийн аудиторуд хязгаарлагдмал баталгаажуулалттай дүгнэлтийг илэрхийлэхийн тулд хангалттай ба зохистой аудитын нотолгоог олж авсан эсэхийг үнэлнэ.

165. Хязгаарлагдмал баталгаажуулалтын нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн үндэслэлтэй баталгаажуулалтын аудитын нэг хэсэг болгож гүйцэтгэх онцгой тохиолдлуудад нийцлийн талаарх хязгаарлагдмал баталгаажуулалт нь аудиторын тайланд тодорхой тусгагдсан байх ба санхүүгийн тайлангийн санал дүгнэлтээс тусдаа байна. Санхүүгийн тайлангийн талаарх үндэслэлтэй баталгаажуулалтын санал дүгнэлттэй ба нийцлийн талаарх хязгаарлагдмал дүгнэлттэй аудиторын тайлангийн жишээг Хавсралт 12-т тусгасан.

9.1.1.8 Санамсаргүй илрүүлэлтүүд

166. Төрийн аудиторуд ихэвчлэн бусад төрлийн аудитын ажлыг гүйцэтгэхтэй холбоотойгоор зөрчлийн жишээнүүдтэй тулгарч болох юм. Хэдийгээр аудиторуд тухайлсан нөхцөл байдал байгаа эсвэл үгүйг эрэлхийлээгүй ч олон нийтийн хүлээлт нь ийм тохиолдлуудыг тайлагнахыг шаардана. Эдгээр илрүүлэлтийг төрийн салбарын аудиторуд тайлагнаж болох ч эдгээр нь нийцлийн аудитын хамрах хүрээнээс гадуур юм. Аудитын хамрах хүрээг дахин үнэлж, санамсаргүй илрүүлэлтүүдийг гүйцэтгэж буй нийцлийн аудитад хамруулаагүй тохиолдолд аудитор санамсаргүй илрүүлэлтүүдтэй холбоотой нөхцөл байдал оршин байгаа эсвэл байхгүй талаар үндэслэлтэй баталгаажуулалт олж авах эсвэл түүгээр хангахгүй. Гэхдээ нөхцөл байдал дээр үндэслэн хязгаарлагдмал баталгаажуулалттай дүгнэлт илэрхийлэх боломжтой байж болох юм. Аль ч тохиолдолд эдгээр нөхцөл байдлыг тайлагнахад холбогдох баталгаажуулалтын түвшний (үндэслэлтэй эсвэл хязгаарлагдмал) уншигчид, хэрэв байгаа бол, мэдэгдэх нь чухал юм.

9.1.2 Санхүүгийн тайлангийн аудиттай хамаатай нийцлийн аудитын тайлагнал

167. Санхүүгийн тайлангийн аудиттай хамаатай нийцлийн аудитыг гүйцэтгэхэд хууль тогтоомжын нийцлийн талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн талаарх аудиторын тайлангийн нийцлийн дүгнэлтэнд оруулж болно. Зарим тохиолдолд нийцлийн аудитын тусдаа тайланг гаргаж болно. Санхүүгийн тайлангийн талаарх аудиторын тайлангийн удирдамжийг АДБОУС 1700 ба 1800-д тусгасан. Нийцлийн аудитын салангид тайлангийн талаарх дэлгэрэнгүй удирдамжийг АДБОУС 4100-д тусгасан болно. Нийцлийн талаарх санал дүгнэлтийг агуулсан жишиг тайлангуудыг Хавсралт 7-11-д хавсаргасан.

9.1.2.1 Нийцлийн өөрчлөлтгүй санал дүгнэлт

168. Төрийн аудиторууд санхүүгийн тайланд толилуулсан үйл ажиллагаа, санхүүгийн ажил гүйлгээ ба мэдээлэл нь бүх материаллаг байдлын хувьд удирдаж буй эрхий бүхий байгууллагын хууль тогтоомжтой нийцэж байна гэж дүгнэсэн тохиолдолд өөрчлөлтгүй санал дүгнэлтийг илэрхийлнэ.

9.1.2.2 Нийцлийн өөрчлөлттэй санал дүгнэлт

169. Төрийн аудиторууд материаллаг нийцлийн хэлбэлзэл байна гэж дүгнэсэн тохиолдолд дараах санал дүгнэлтүүдийн аль нэгийг илэрхийлнэ:

А) хязгаарлалттай (хэрэв нийцлийн хэлбэлзэл нь материаллаг гэхдээ өргөн хүрээтэй бус, эсвэл төрийн аудиторууд хангалттай ба зохистой нотолгоог олж авах боломжгүй ба гарч болохуйц үр нөлөө нь материаллаг боловч өргөн хүрээтэй бус); эвсэл

Б) сөрөг (хэрэв нийцлийн хэлбэлзэл нь материаллаг ба өргөн хүрээтэй)

170. Төрийн аудиторууд хууль тогтоомжийн нийцлийн талаарх хангалттай ба зохистой аудитын нотолгоог олж авах боломжгүй ба гарч болохуйц үр нөлөө нь материаллаг, өргөн хүрээтэй байвал төрийн аудиторууд нийцлийн талаарх санал дүгнэлт өгөхөөс татгалзана.

171. Нийцлийн аудитын дүгнэлтийг өөрчилсөн тохиолдолд өөрчлөлт хийх болсон учир шалтгааныг “Өөрчлөлттэй дүгнэлтийн үндэслэл” хэсэгт тайлбарлана. Нийцлийн өөрчлөлттэй дүгнэлтийн жишээнүүдийг Хавсралт 8-10-т харуулав.

172. Нийцлийн аудитын дүгнэлтийг өөрчилсөн тохиолдолд төрийн аудиторууд санхүүгийн тайлангийн хувьд бүхэлд нь болон тэнд тусгасан аудиторын дүгнэлтийн өргөн хүрээтэй үр дагаврыг анхаарч үзнэ.

9.1.2.3 Тайлагналын анхаарах нэмэлт асуудлууд

173. Зарим тохиолдолд АДБ санхүүгийн тайлангийн талаарх аудиторын тайланд нэмэлтээр (санхүүгийн тайлангийн ба нийцлийн талаарх санал дүгнэлтийг агуулсан) илүү дэлгэрэнгүй нийцлийн аудитын тусгай тайланг гаргаж болно. Ийм тайлангийн зорилго нь хууль тогтоох байгууллага, төрийн тооцооны хороо эсвэл хууль тогтоох байгууллагын ижил төстэй хороо, шалгагдагч байгууллага, эсвэл шаардлагатай тохиолдолд засаглал хариуцсан бусад байгууллагуудыг санхүүгийн тайлангийн талаарх аудиторын дүгнэлтэнд тусгаснаас илүү дэлгэрэнгүй тайлбараар хангах байж болох юм. Төрийн аудиторууд эдгээр асуудлуудыг холбогдох хэрэглэгчдэд зүй зохистой ойлгуулах ба анхаарч үзэх боломж олгохуйц хангалттай дэлгэрэнгүй хэлбэрээр тайлагнана. Нийцлийн

аудитын тусгай тайлангийн талаарх дэлгэрэнгүй удирдамжийг АДБОУС 4100-д тусгасан.

174. Бусад тохиолдлуудад АДБ-ууд санхүүгийн тайлангийн талаарх аудиторын тайлангаас тусдаа нийцлийн талаарх санал дүгнэлттэй тайланг гаргаж болно. Нийцлийн талаарх санал дүгнэлттэй ийм тусдаа тайланг гаргасан тохиолдолд төрийн аудиторууд санхүүгийн тайлангийн талаарх аудиторын тайлан дахь тусдаа тайланд тохиромжтой тайлбарыг оруулж болох юм.

175. Тайлагналын талаарх нэмэлт удирдамжийг дараах баримт бичгүүдээс олж болно. Үүнд:

- АДБОУС 1700, 1705 ба 1706
- ИНТОСАИ-н Гүйцэтгэлийн аудитыг гүйцэтгэх гарын авлагын 5-р хэсэг
- НБОУХ-ны БГАОУС 3000 ба Хянан шалгах ажлын олон улсын стандарт 2400

9.2 Зөвлөмжийн мөрөөр авах арга хэмжээ

176. Аудитын үндсэн зарчмууд нь бүтээлч зөвлөмж ба тогтоосон сул талыг залруулахтай холбоотой, шаардлагатай тохиолдолд, зөвлөмжийн мөрөөр авах нэмэлт арга хэмжээг тайлагнах талаар анхаардаг (АДБОУС 400, 4.0.26). Өмнө нь тайлагнасан зөрчлүүдийн мөрөөр авах арга хэмжээний хэрэгцээ шаардлага нь тухайлсан нөхцөл байдал ба зөрчлийн мөн чанараас шалтгаалан харилцан адилгүй байна. Үүнд аудитор хууль тогтоох байгууллага, мөн түүнчлэн шалгагдагч байгууллага эсвэл бусад холбогдох байгууллагуудад албан ёсоор тайлагнах хамаарна. Аудитын мөрөөр авах бусад арга хэмжээнүүдэд тайлан, дотоод хяналт, шалгагдагч байгууллага эсвэл бусад байгууллагын бэлтгэсэн үнэлгээ, зөвлөмжийн мөрөөр авах арга хэмжээний аудит, шалгагдагч байгууллагаас эсвэл тэдэнд зориулж зохион байгуулсан бага хурал ба семинарууд зэрэг хамаарч болно. Ерөнхийдөө зөвлөмжийн мөрөөр авах арга хэмжээ нь залруулгын арга хэмжээг үр өгөөжтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх болон шалгагдагч байгууллага, тайлангийн хэрэглэгчид ба төрийн аудиторуудад ирээдүйн аудитаа төлөвлөхөд хэрэгцээтэй эргэх холбоогоор хангадаг. Зөвлөмжийн мөрөөр авах арга хэмжээг АДБ-ын бүрэн эрхэд тусгасан байж болно.

177. Зөвлөмжийн мөрөөр авах арга хэмжээний талаарх нэмэлт удирдамжийг дараах баримт бичгүүдээс олж болно. Үүнд:

- ИНТОСАИ-н Гүйцэтгэлийн аудитыг гүйцэтгэх гарын авлагын 5.5-р хэсэг

10 Тооцооны шүүхийн орчинд үйл ажиллагаа явуулж буй төрийн аудитуудад зориулсан нэмэлт удирдамж

178. Тооцооны шүүхийн орчинд үйл ажиллагаа явуулдаг АДБ-уудад олгосон шүүх эрх мэдлийн байр сууриас хамааран тухайн АДБ-ууд данс тооцоонууд болон хариуцагч хүмүүс, түүний дотор нягтлан бодогчид ба удирдлага нарын талаар шийдвэр гаргах ба шийдэл гаргах эрхтэй байдаг (АДБОУС 100, 1.0.21).

10.1 Тооцооны шүүх аудитыг гүйцэтгэх нь

179. Төсвийн тусдаа данс тооцоонд нь эсвэл улсын нэгдсэн төсөвт нийцлийн аудитыг гүйцэтгэхэд Тооцооны шүүхийн орчин дахь төрийн салбарын аудитууд:

А) Төсвийн тусдаа данс тооцоонд толилуулсан мэдээлэл ба үндсэн ажил гүйлгээ нь бүх материаллаг байдлын хувьд тэдгээрийг удирдаж буй эрх бүхий байгууллагаас гаргасан хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх дээр үндэслэлтэй баталгаажуулалт олж авах

Б) Улсын төсвийн зарцуулалт нь бүх материаллаг байдлын хувьд тэдгээрийг удирдаж буй эрх бүхий байгууллагаас гаргасан хууль тогтоомж болон төсвийн тусдаа данс тооцоотой нийцэж буй эсэхийг тогтоох, ба

В) Холбогдох талуудад илрүүлэлтийг тайлагнана.

180. Дээр дурдсан өвөрмөц шүүх эрх мэдлийн байр суурь нь Тооцооны шүүхийн орчинд үйл ажиллагаа явуулж буй төрийн аудитуудыг нийцлийн аудитыг төлөвлөх ба гүйцэтгэхэд нэмэлт зүйлүүдийг анхаарч үзэх хэрэгцээ шаардлагад хүргэж болно. Эдгээр асуудлуудаас дурдвал:

А) АДБ-ын шийдлээс гарч болох хариуцагч хүмүүстэй холбоотой хууль эрх зүйн дүгнэлтээс шалтгаалан зөрчлийн үйлдлийг хариуцах хүн/хүмүүсийг тогтоох. Төсвийн хөрөнгийн үр ашиггүй зарцуулалт эсвэл алдагдалд төрийн албан тушаалтнуудад биечлэн хариуцлага тооцож тухайн алдагдлыг бүрэн дүнгээр эргүүлэн төлөхийг шаардаж болно.

Б) Тохиромжтой нарийн тодорхой хугацаа, тухайн хүний хариуцлагын зааврыг тасалдуулсан арга хэмжээ ба ямар албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх тодорхой цаг хугацаа зэргийг харгалзаж үзэх

В) Зөрчлийн үйлдлээр хүлээх тухайн хүний хариуцлагыг хууль бус үйлдлийн (сэжиг бүхий залилан) хариуцлагаас ялгах. Хууль бус үйлдлийн хувьд аудитын нэмэлт горимуудыг гүйцэтгэх шаардлагатай байж болно.

Г) Шалгагдагч байгууллага ба түүний орчныг ойлгох, зөрчлийн эрсдэлийг үнэлэх, залиланг илтгэж болох зөрчлийн тохиолдлуудыг авч үзэх болон эдгээр асуудлуудыг тайлагнах зэрэг дээр прокурорууд, шаардлагатай тохиолдол цагдаа нартай харилцан уялдаатай ажиллах

Д) Чанарын хяналтын нэмэлт түвшин эсвэл илүү албажуулсан горимуудын хэрэгцээ шаардлагыг анхаарч үзэх

Е) Бичгэн хэлбэрээр асуулга авах (аман хэлбэрээр бус)

Ё) Аудитын баталгаажуулалт нь нотолгооны холбогдох дүрэм журамтай нийцэж байгааг баталгаажуулах

Ж) Хууль ёсны байдлаар мэдээлэх

З) Албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх тодорхой шалгууруудыг, түүний дотор холбогдох ямар нэг тоо хэмжээ байгаа эсэхийг тайланд оруулах

И) Зөвлөмж, хохирлын тодорхойлолт, эсвэл үүрэг хариуцлагыг албан ёсоор гүйцэтгэхэд хүргэх шүүхийн шийдвэр, эсвэл хариуцлагын албан ёсны тодорхойлолт зэргийг илэрхийлэх дүгнэлтийн хамгийн тохиромжтой хэлбэрийг анхаарч үзэх

10.2 Мэдээлэх ба хуулийг хэрэгжүүлэх

181. Шүүхийн АДБ-ууд дахь төрийн аудиторуд хууль эрх зүйн арга хэмжээ, хохирол эсвэл эрүүгийн хэрэгт хүргэж болзошгүй нийцлийн асуудлуудыг шүүгч, хуульч эсвэл Шүүх доторх шүүхийн шийдвэрийг хариуцдаг хэсэг эсвэл шаардлагатай тохиолдолд бусад байгууллагуудад бас мэдээлнэ. Мөн түүнчлэн Шүүхийн АДБ-ууд аудитын ажлаас гарч буй илүү ерөнхий эсвэл мэдээллийн мөн чанартай ажиглалтыг шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтанд мэдээлж болно.

182. Төрийн албан тушаалтнуудтай холбоотой хуулийг хэрэгжүүлэхэд Шүүхийн АДБ-уудаас гаргасан шийдвэрүүд нь дараах зүйлсээс хамаарна. Үүнд:

А) Хууль эрх зүйн ба олон нийтийн сонсголын зохих ёсны үйл явц

Б) Олон нийтийн тодруулга

В) Эрүүгийн гэмт хэргийн нотолгоо байвал холбогдох хууль хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагуудад мэдэгдэх

10.3 Тооцооны шүүхийн янз бүрийн загвар дахь үйл явц

183. Тооцооны шүүхийн орчинд үйл ажиллагаа явуулж буй АДБ-уудын хувьд гүйцэтгэсэн ажилд янз бүрийн үе шатууд, түүний дотор аудит, зааварчилгаа болон албан ёсны шийдвэр зэргийг багтаана.
184. Тооцооны шүүхийн орчинд үйл ажиллагаа явуулж буй зарим АДБ-ууд энэ гарын авлагад тайлбарласан аудитын үйл явцыг баримтална. Гэхдээ төлөвлөлт, гүйцэтгэл ба нотолгоо цуглуулах үе шатуудын дараа зааварчилгааны үйл явцыг нээх ба эцсийн албан ёсны шийдэлд хүргэх нэмэлт ба тусгай асуудлууд байж болох юм.
185. Шүүгч эсвэл хуульч хэргийг зааварчлах шийдвэр гаргах үед зааварчилгааны зорилт нь шийдлийг гаргах боломжийг олгохын тулд хохирол учруулсан нь батлагдсан төрийн албан тушаалтны гэм буруутай эсвэл гэм буруугүйн хангалттай нотолгоог цуглуулах юм.
186. Тооцооны шүүхийн орчинд үйл ажиллагаа явуулж буй зарим АДБ-ууд дахь аудиторүүд шүүгчийн чиг үүргийг хэрэгжүүлж, аудит болон албан ёсны шийдлийг аль алиныг нь хэрэгжүүлэх эрх олгогдсон байж болно. Эдгээр тохиолдлуудад зааварчилгааны үе шат нь аудитын төлөвлөлт, гүйцэтгэл ба нотолгоо цуглуулах үе шатуудын үндсэн хэсэг бөгөөд аудит нь эдгээр бүх үе шатуудыг хамрах үзэл баримтлалаар төлөвлөгддөг.

Хавсралт 1 – Нийцлийн аудитын шалгах асуудлууд, шалгах асуудлуудын мэдээлэл ба шалгууруудын жишээ

Дараах хүснэгтээр шалгах асуудлууд, шалгах асуудлуудын мэдээлэл ба холбогдох шалгууруудын жишээнүүдийг харуулахаар зорьлоо. Тухайн шалгах асуудал, шалгах асуудлуудын мэдээлэл ба шалгуурууд нь тухайлсан аудитын зорилт ба АДБ-ын бүрэн эрх зэрэг янз бүрийн асуудлуудаас шалтгаалан харилцан адилгүй байна.

	Шалгах асуудал	Шалгах асуудлын мэдээлэл	Шалгуурууд
1.	<p>Төсөвлөсөн төсвийн ашиглалт ба санхүүгийн гүйцэтгэл</p> <p>Үүнд төсвийн зарцуулалт, түүний дотор хууль тогтоох байгууллагаас гаргасан төлөвлөгөө ба зорилгын дагуу төсвийг ашиглаж байгаа эсэхийг шалгах хамаарна. Олон АДБ-уудад энэ төрлийн нийцлийн аудит нь үнэн зөв байдлын аудит, түүний дотор санхүүгийн аудиттай холбогдож болно.</p> <p>Тухайлсан сэдвээрх илүү дэлгэрэнгүй удирдамжийг Хавсралт 1-А-д тусгав.</p>	<p>Санхүүгийн тайлан гэх мэт санхүүгийн мэдээлэл</p>	<p>Төсвийн тухай хууль зэрэг холбогдох төсвийн хууль тогтоомж</p> <p>Батлагдсан төсөв</p>
2.	<p>Санхүүгийн гүйцэтгэл, жишээлбэл дараах хэлбэрийн орлогууд</p> <ul style="list-style-type: none"> • Хандивлагч агентлагуудаас авсан төслийн хөрөнгө • Төрөөс авсан 	<p>Төслийн санхүүгийн мэдээлэл/төслийн данс тооцоо</p>	<p>Төсвийн хөрөнгийн ашиглалттай холбоотой холбогдох хууль тогтоомж (төрийн аудитын хууль)</p> <p>Шалгагдагч байгууллагын хуулиар эрх олгосон үйл ажиллагаа</p> <p>Санхүүжилтийн</p>

	санхүүжилт • Бусад ижил төстэй төрлийн төсөв ба тэдгээрийн ашиглалт		хэлэлцээрийн нөхцөлүүд
3.	Санхүүгийн гүйцэтгэл, жишээлбэл буцалтгүй тусламжийн хэлбэрээрх орлого ба түүний ашиглалт	Буцалтгүй тусламжийг ашиглахтай холбоотой санхүүгийн мэдээлэл	Шалгагдагч байгууллагын эрх олгосон үйл ажиллагаа Буцалтгүй тусламжийн хэлэлцээрийн нөхцөлүүд
4.	Санхүүгийн гүйцэтгэл, жишээлбэл гэрээ эсвэл зээлийн гэрээ хэлэлцээрийн дагуу орлого ба зардлууд болон тэдгээрийн ашиглалт	Гэрээ эсвэл зээлийн гэрээ хэлэлцээртэй холбоотой санхүүгийн мэдээлэл	Гэрээ эсвэл зээлийн гэрээ хэлэлцээрийн нөхцөлүүд
5.	Худалдан авалт	Санхүүгийн мэдээлэл	Худалдан авалтын тухайи холбогдох хууль тогтоомж ба дүрэм журам (үндэсний ба олон улсын) Нийлүүлэгчтэй хийсэн гэрээний нөхцөлүүд
6.	Зардлууд	Санхүүгийн мэдээлэл Нийцлийн тухай мэдэгдэл	Төсвийн тухай хууль гэх мэт холбогдох төсвийн хууль тогтоомж Бусад холбогдох хууль тогтоомж Холбогдох яамдын заавар удирдамж, төрийн бодлогын шаардлагууд ба хууль тогтоох байгууллагын шийдвэрүүд Гэрээний нөхцөлүүд
7.	Хөтөлбөрийн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны үзүүлэлтүүд эсвэл тайлангууд	Хууль тогтоомж, дүрэм журам, яамдын заавар удирдамж, хууль тогтоогч эсвэл байгууллагаас хүлээн зөвшөөрсөн

			<p>зорилго, олон улсын гэрээ хэлэлцээрүүд, протоколиуд, конвенц эсвэл хэлэлцээрүүд, гэрээний нөхцөлүүд, нийтээр боловсруулсан аж үйлдвэрийн стандартууд, эсвэл үндэслэлтэй олон нийтийн хүлээлт зэрэгт тусгагдсан гүйцэтгэлийн холбогдох түвшнүүд</p> <p>Жишээлбэл:</p> <ul style="list-style-type: none"> • Хүлээн зөвшөөрөгдсөн хүүхдүүдийн тоотой хамааралтай цэцэрлэгийн тоо • Ард иргэд нэг бүрт ногдох мэргэшсэн сувилагч, эмч нарын тоо • Засмал замын милийн урт • Тэтгэмжийн төлбөр эсвэл барилгын зөвшөөрөл олгох үйл явцад шаардлагатай сарын тоо хэмжээ • Үйлчилгээний байгууллагаас хангах нягтлан бодох бүртгэлийн давтамж ба чанар • Тодорхой цаг хугацаанд гүйцэтгэх барилгын хяналт шалгалтын тоо • Усны чанартай холбоотой үр дүнгийн хэмжүүр, гэх мэт
8.	Үйлчилгээний хүргэлт	<p>Үйлчилгээний хүргэлтийн мэдэгдэл</p> <p>Олон нийтэд тайлагнасан мэдээлэл</p>	Холбогдох хууль тогтоомж ба шийдвэрүүд
9.	Төрийн захиргааны	Ард иргэдийн гомдлын бүртгэл	Холбогдох хууль тогтоомж

	шийвдэрийн шударга байдал	Олон нийтэд тайлагнасан мэдээлэл	ба шийдвэрүүд
10.	Компанийн нийгмийн үүрэг хариуцлага, жишээлбэл хөгжиж буй орнуудад хэрэгжүүлсэн төрөөс санхүүжүүлсэн төслүүдийн аудит	Компанийн нийгмийн үүрэг хариуцлагын нийцлийн мэдэгдэл (эсвэл дутагдал)	Хүний ба иргэний эрх, хүйсийн тэнцвэрт байдал, ажлын байр, орчин гэх мэт асуудлуудтай холбоотой хууль тогтоомж ба шийдвэрүүд
11.	Зан байдал/ёс зүй	Нийцлийн мэдэгдэл, жишээлбэл хараат бус байдлын мэдэгдэл (хууль зүйн бүрэн эрх) Төрийн салбарт энэхүү “мэдэгдэл” нь зарим тохиолдолд шууд бус байж болох ба шударга ёс ба ёс зүйн ухагдахуунтай холбоотой байж болно. (дээр дурдсан шалгууруудын хэсгийг харна уу)	Төрийн албан тушаалтнуудын зан байдлыг хамарсан холбогдох хууль тогтоомж ба шийдвэрүүд Ёс зүйн дүрэм эсвэл дотооддоо боловсруулсан сахилгын дүрэм Эрхэмлэх үнэт зүйлс эсвэл удирдлагын зарчмууд Дотоод бодлого, гарын авлага ба зааврууд хуулиар эсвэл ижил төстэй баримт бичгээр тогтоосон байгууллагын үйл ажиллагаа явуулах хүрээ Гэрээний нөхцөлүүд (тохиролцсон нууцлал эсвэл тодорхой ажил эрхлэлтийн нөхцөл байдлын дараагаар авах хорио цээрийн арга хэмжээ)
12.	Гишүүнчлэлийн үүрэг	Нийцлийн мэдэгдэл	Гишүүнчлэлийн тохиролцсон нөхцөлүүд
13.	Эрүүл мэнд ба аюулгүй байдалтай холбоотой үйл явц	Нийцлийн мэдэгдэл Санхүүгийн ажил гүйлгээ	Хөдөлмөр хамгаалал ба эрүүл мэндтэй холбогдох хууль тогтоомжууд, жишээлбэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ашиглах боломжтой холбоотой

			Бодлого, үйл явц, гарын авлага, заавар гэх мэт
14.	Байгаль орчныг хамгаалахтай холбоотой үйл явц	Нийцлийн мэдэгдэл Санхүүгийн ажил гүйлгээ	Холбогдох байгаль орчны тухай хууль тогтоомж, жишээлбэл усны чанар, хог хаягдлыг зайлуулах эсвэл нүүрстөрөгч ялгаруулалтын түвшинтэй холбоотой гэх мэт Байгаль орчны олон улсын гэрээ, протокол, конвенц эсвэл хэлэлцээрүүдийн нөхцөлүүд Бодлого, үйл явц, гарын авлага, зааврууд гэх мэт
15.	Дотоод хяналтын үйл явц	Нийцлийн мэдэгдэл Санхүүгийн ажил гүйлгээ	Дотоод хяналтын үзэл баримтлал, жишээлбэл холбогдох хууль тогтоомжинд заасан эсвэл эрх мэдлийн хүрээнд нийтээр хүлээн зөвшөөрсөн дотоод хяналтын шаардлагууд Бодлого, үйл явц, гарын авлага, зааврууд гэх мэт
16.	Тэтгэвэр эсвэл нийгмийн халамж, паспорт олгох эсвэл иргэншлийн мэдүүлэг, торгууль эсвэл хуулиар тогтоосон бусад хэлбэрийн төлбөрийг тогтоох зэрэг байгууллагын тодорхой үйл ажиллагаа, чиг үүрэгтэй холбоотой үйл явц	Нийцлийн мэдэгдэл Санхүүгийн ажил гүйлгээ	Холбогдох хууль тогтоомж эсвэл зааврууд Бодлого, үйл явц, гарын авлага, зааврууд гэх мэт
17.	Биет шинж чанар	Биет зүйлийн техникийн үзүүлэлтүүдийг заасан баримт бичиг эсвэл тухайн биет зүйл өөрөө	Барилгын тухай хууль (хэмжээ, өндөр, зорилго, тухайн бүсчилсэн хэсгийн нягтралын хэмжүүр гэх мэт)

			Барилгын гэрээний нөхцөлүүд, эсвэл бусад төрлийн гэрээ
18.	Татварын орлого, татвар төлөгчдийн үүрэг эсвэл захиргааны эрх бүхий байгууллагуудад тайлагнахыг хамарсан бусад үүргүүд	Хувь хүний эсвэл компанийн татварын буцаан олголтын маягт Захиргааны эрх бүхий байгууллагад гаргадаг бусад татварын маягтууд (НӨАТ-ын маягт, банк, санхүү, эм зүйн бүтээгдэхүүн зэрэг дүрмээр зохицуулж буй эдийн засгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй агентлагуудын татвар тайлагнах маягтууд)	Холбогдох хууль тогтоомж эсвэл эдийн засгийн салбарын тусгай дүрэм Татварын тухай хууль, орлогын албан татварын тухай эсвэл бусад ижил төстэй хуулиуд

Хавсралт 1-А- Санхүүгийн тайлангийн аудиттай хамтад нь гүйцэтгэж буй Нийцлийн аудитын шалгууруудын жишээ

Шалгагдагч байгууллагын орлого ба зарлага нь хууль тогтоомжууд, түүний дотор төсвийн тухай хууль тогтоомжтай нийцэж байгаа эсэхийг шалгахад хэрэглэж болох аудитын шалгууруудын тайлбар жишээнүүдийг дор дурдав.

Орлого

1. Татвар ногдуулах, төлбөр шаардах эсвэл бараа, үйлчилгээ эсвэл үл хөдлөх хөрөнгө борлуулах засгийн газрын бүрэн эрхтэй холбоотой үндсэн хуулийн заалтууд эсвэл бусад үндсэн зарчмууд
2. Албан татварын объектыг тогтоох татварын тухай хуулийн заалтууд
3. Татвар, гаалийн татвар ба бусад хураамжын тооцооллын заалтууд
4. Татвар цуглуулах ба хорогдуулах үйл ажиллагаа ба тогтолцооны заалтууд
5. Татварын хяналтын заалтууд
6. Төрийн эрх бүхий байгууллагын бараа, үйлчилгээ эсвэл үл хөдлөх хөрөнгө борлуулалтыг зохицуулдаг төсвийн, өрсөлдөөний эсвэл бусад хуулиудын заалтууд ба зарчмууд
7. Үнэ ба төлбөрийг зөв тооцоолох заалтууд ба зарчмууд
8. Орлого олж авах төсөв төлөвлөлт
9. Авилгаас урьдчилан сэргийлэх ба бараа, үйлчилгээ ба үл хөдлөх хөрөнгийг хуульт ёс ба эрх тэгш зарчмуудын дагуу ил тод үйл ажиллагаагаар борлуулсныг баталгаажуулахад үйлчлэх заалтууд эсвэл нийтлэг туршлага
10. Орлогыг нэмэгдүүлэх ба төлбөрийн алдагдлаас урьдчилан сэргийлэхэд үйлчлэх зарчмууд
11. Төлбөрийн нөхцөлүүд, зээл олгох хандлага, хөрөнгийн баталгаа ба өр төлбөрийг цуглуулахтай холбоотой заалтууд ба зарчмууд

Үйл ажиллагааны зардлууд

1. Ажилтнуудын бүтэц, орон тоог оновчтой шийдвэрлэх замаар үр ашиг, үр өгөөжийг баталгаажуулахад үйлчлэх зарчмууд
2. Ажилтнуудын цалин, тэтгэвэр бусад урамшууллыг зохицуулах заалтууд
3. Ажилд авах ажилтнуудын тоо ба ангиллыг зохицуулах заалтууд
4. Ажилтнуудын хувийн зардлын нөхөн олголтыг зохицуулах заалтууд ба зарчмууд
5. Олон нийтэд нээлттэй худалдан авалтын үйл ажиллагааны талаарх төсвийн, өрсөлдөөний эсвэл бусад хуулийн заалтууд ба зарчмууд
6. Бараа, үйлчилгээ худалдан авахад зориулсан заалтууд ба зарчмууд
7. Бараа, үйлчилгээ нийлүүлэгчтэй хийсэн хэлэлцээрийн заалтууд ба гэрээнд тусгасан эрх, үүргийн зарчмууд

8. Гадаад төлөөлөл эсвэл дотоод ажилтнуудын зорилгоор төсвийг ашиглахыг хязгаарласан заалтууд, зарчмууд ба нийтлэг туршлага
9. Орон сууцны зээл, бараа түрээслэх ба зээлээр худалдан авахтай холбоотой заалтууд ба зарчмууд
10. Дотоод хяналт ба төлбөрийн хуваарилалтын үйл ажиллагаатай холбоотой заалтууд ба нийтлэг туршлага

Барилга байгууламж, дэд бүтэц, МТ тогтолцоо ба бусад их хэмжээний хөрөнгө оруулалтын зардлууд (үйл ажиллагааны зардлаас гадна)

1. Үндэслэлийн судалгаа, төлөвлөлт, ба төсөвлөлттэй холбоотой заалтууд
2. Олон нийтэд нээлттэй тендер зарлах ба нийлүүлэгчийг сонгохтой холбоотой төрийн хөрөнгийн сайн удирдлагын заалтууд ба зарчмууд
3. Эдийн засгийн салбарын стандартууд ба стандарт гэрээнүүд
4. Гэрээний заалтууд, төслийн сайн удирдлага ба төсвийн хяналттай холбоотой зарчмууд
5. Барилга угсралт/хөгжлийн үе шат ба хүлээлгэн өгөх үед тохиромжтой чанарын удирдлагын заалтууд ба зарчмууд
6. Авилга ба өрсөлдөх чадваргүй зан байдлыг хэмжих хэмжүүр

Аж ахуйн нэгж, байгууллагууд эсвэл хувь хүнд олгох тусламж, эрхийн бичиг, баталгаа ба бусад санхүүгийн хандив

1. Хөрөнгийг хэрхэн ашиглах тухай хязгаарлалт ба төлөвлөгөөний зорилгын талаарх заалтууд
2. Хүсэлт гаргагч нарын урих ба буцалтгүй зээл хуваарилах үйл явц дахь эрх тэгш, найдвартай ба ил тод байдлын зарчмууд
3. Хүсэлтийг сонгох шалгуур
4. Хүлээн авагчийн нягтлан бодох бүртгэл, хяналт ба аудиттай холбоотой заалтууд
5. Захиргааны шийдвэр эсвэл ашиг хүртэгчтэй хийсэн хэлэлцээрээр тогтоосон нөхцөл байдлууд
6. Эргэн төлөх баталгаа ба нөхцөл байдлын хамрах хүрээний заалтууд
7. Дүн хэмжээг тооцоолох заалтууд
8. Урьдчилгаа төлбөр, дараагийн нөхөн олголт ба/эсвэл эцсийн төлбөр төлөлт зэрэгтэй холбоотой нөхцөл байдлыг хамаарсан төлбөр төлөлтийн үйл явцын заалтууд

Хавсралт 2 – Шалгагдагч байгууллагын талаар ойлголт олж авах ба зохистой шалгууруудыг тогтооход хэрэглэх эх сурвалжуудын жишээ

Зохистой аудитын шалгууруудыг тогтооход төрийн аудиторууд хэрэглэж болох эх сурвалжуудын иж бүрэн биш боловч тайлбар жагсаалтыг дор дурдав:

- А) Хууль тогтоомжууд, түүний дотор эдгээр хууль тогтоомжуудыг бий болгох баримтжуулсан зорилт ба урьдчилсан нөхцөл
- Б) Төсвийн тухай хууль тогтоомж/батлагдсан төсөв эсвэл төсөвлөлт
- В) Төсвийн тухай хууль тогтоомж эсвэл шийдвэр ба батлагдсан төсвийн ашиглалт эсвэл санхүүгийн ажил гүйлгээ, хөрөнгө ба үлдэгдлүүдийн тодорхой заалт эсвэл урьдчилсан нөхцөлтэй холбоотой хууль тогтоох байгууллагын баримт бичгүүд
- Г) Хууль тогтоох байгууллага эсвэл яамны зааврууд
- Д) Захиргааны эрх бүхий байгууллагуудын мэдээлэл
- Е) Хууль тогтоох байгууллага, төрийн тооцооны хороо эсвэл хууль тогтоох байгууллагын ижил төстэй хороо, эсвэл бусад төрийн байгууллагуудын хурлын албан ёсны тэмдэглэл
- Ё) Хуулийн зарчмууд
- Ж) Өмнө нь тохиолдсон хууль эрх зүйн жишээ
- З) Эрх зүйн дүрэм эсвэл сахилгын дүрмүүд
- И) Бодлого, стратегийн ба үйл ажиллагааны төлөвлөгөөнүүд ба журмуудын дотоод тодорхойлолт
- Й) Гарын авлага ба бичгээрх зааврууд
- К) Гэрээ гэх мэт албан ёсны хэлэлцээрүүд
- Л) Зээл ба тусламжийн хэлэлцээрүүд
- М) Эдийн засгийн хүрээний стандартууд
- Н) Сайн үндэслэлтэй онол (жишээлбэл, ерөнхий зохицуулалт бүхий онол. Ийм онолыг жишээлбэл мэргэжлийн зохиол бүтээл ба арга, мэргэжлийн сэтгүүл гэх мэт хэвлэгдсэн мэдээллээс, эсвэл тухайлсан салбарын шинжээч гэх мэт мэдлэг бүхий эх сурвалжаас асуулга авах замаар олж авч болно.)
- О) Тухайлсан салбарын нийтээр хүлээн зөвшөөрсөн стандартууд (эдгээр стандартууд нь хэвшсэн дадлага ба өмнө нь тохиолдсон хууль эрх зүйн

жишээний үр дүнгээс бий болсон ба эх сурвалж нь хууль тогтоомжийн хэлбэртэй ихэвчлэн тодорхой танигдахуйц стандартууд байдаг, жишээлбэл тухайн улс орны “нийтээр хүлээн зөвшөөрсөн нягтлан бодох бүртгэлийн зарчмууд”)

Ө) Зүй зохистой байдлын аудитын хувьд: Төрийн салбарын санхүүгийн сайн удирдлагын ба төрийн албан тушаалтны ёс суртахууны зарчмууд. Ёс суртахууны зарчмууд нь төрийн албан тушаалтнуудын зан байдалтай холбоотой олон нийтийн хүлээлт эсвэл хууль тогтоох байгууллагаас үүсэлтэй байж болно. Зарим тохиолдолд эдгээр зарчмуудыг зөвхөн хэсэгчлэх замаар баримтжуулж болно. Мөн зарим тохиолдолд эдгээр зарчмуудыг зөрчигдсэн тохиолдолд зөвхөн тогтоож болно.

Шалгагдагч байгууллага, түүний орчин ба холбогдох хөтөлбөрийн хамрах хүрээний талаар төрийн аудиторуд ойлголт олж авахад хэрэглэх нэмэлт эх сурвалжуудаас дурдвал:

- А) Байгууллагын жилийн тайлан
- Б) Хуулийн мэдэгдэл ба илтгэл
- В) Цахим хуудас
- Г) Сонин эсвэл сэтгүүл, бусад хэвлэл мэдээллийн эх сурвалж дээр хэвлэгдсэн тайлан, нийтлэлүүд
- Д) Хурал ба бусад харилцаа холбоогоор цуглуулсан мэдээлэл
- Е) Зөвлөл эсвэл бусад удирдлагын хурлуудын тэмдэглэл
- Ё) Дотоод аудитын тайлан
- Ж) Албан ёсны статистик мэдээ

Хавсралт 3 – Нийцлийн аудитын эрсдэлийг үнэлэхтэй холбоотой хүчин зүйлсийн жишээ

Нийцлийн аудитын явцад эрсдэлийг үнэлэхэд анхаарч үзэх хүчин зүйлсийн жишээг дор дурдав. Энэ жагсаалт нь өргөн хүрээг хамрахыг зориогүй бөгөөд хүчин зүйлс нь тухайлсан аудитын нөхцөл байдлаас хамаарна.

Шалгагдагч байгууллагын зорилт ба бүрэн эрх

1. Шалгагдагч байгууллагын зорилт, бүрэн эрх ба хууль эрх зүйн чадавхийг ойлгомжтой томъёолсон эсэх ба энэ нь бэлэн байна уу?
2. Бүрэн эрх, зорилт эсвэл хөтөлбөрийн хамрах хүрээнд сүүлийн үед өөрчлөлт орсон уу?
3. Хөтөлбөрийн хамрах хүрээ эсвэл холбогдох шалгах асуудлууд нь ойлгомжтой тодорхойлогдохуйц байна уу?
4. Давхардал эсвэл хэсэгчлэлийн эрсдэл бий болгохуйц хэмжээнд хөтөлбөрийн хамрах хүрээ нь бусад байгууллагатай мэдэгдэхүйц давхцаж байна уу?

Зохион байгуулалтын бүтэц

1. Байгууллагын хууль эрх зүйн үндэс суурь (яам, газар, агентлаг гэх мэт) юу болох ба хаанаас бүрэн эрхийг нь тогтоодог вэ?
2. Шалгагдагч байгууллага нь чиг үүрэг, хариуцлага ба тэдгээртэй холбогдох бүрэн эрхээ ойлгомжтой тодорхойлсон уу?
3. Эдгээр чиг үүрэг, хариуцлага болон бүрэн эрхийг байгууллагад бүхэлд нь мэдээлж, байгууллага бүхэлдээ ойлгосон уу?
4. Хэрэв тухайн байгууллага нь босоо/шаталсан бүтцийн нэг хэсэг бөгөөд өөр нэг байгууллага шалгагдагч байгууллагыг удирдаж хянах үүрэгтэй бол энэ хяналтыг хэрхэн хэрэгжүүлдэг вэ?
5. Байгууллага нь үйл ажиллагаандаа эрсдэлийн үнэлгээ ба эрсдэлийн удирдлага, түүний дотор зөрчлийн эрсдэлд анхаардаг уу?
6. Зохион байгуулалтын өөрчлөлт сүүлийн үед хийсэн үү?
7. Бусад байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлсэн ямар нэг үйл ажиллагаа байна уу?
8. Хэрэв үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгүүлдэг бол нийцэл ба гүйцэтгэлийг хэрхэн хянадаг вэ?
9. Гэрээгээр ажил гүйцэтгүүлэхтэй холбоотой бусад гарч болохуйц эрсдэл байна уу?
10. Ажилтнуудад хангалттай ур чадвар ба ёс зүй байна уу?
11. Ажилтнууд холбогдох мэдээллийг эрэлхийлдэг эсэх ба холбогдох мэдээлэл нь амархан хэрэглэгдэхүйц байна уу?
12. Байгууллага дотор мэдээллийг цаг хугацаанд нь мэдээлж байна уу?

13.Залилангийн өндөр эрсдэлд хүргэж болохуйц зохион байгуулалтын бүтцийн ямар нэг шинж чанар байна уу?

Анхаарч үзэх улс төрийн асуудлууд

1. Тухайлсан байгууллага нь засгийн газрын аль түвшинд хамаардаг ба засгийн газрын бусад түвшинтэй харилцаа холбоотой байдаг уу?
2. Холбогдох сайд, эсвэл байгууллагын удирдлагын үүрэг хариуцлага (үндсэн хуулиарх эсвэл бусад хуулиар тогтоосон) юу вэ?
3. Байгууллагын захиргааны эсвэл улс төрийн удирдлагыг хэрэгжүүлдэг туршлага байна уу?
4. Улс төрийн зөвшилцөл байгаа эсэх эсвэл ялгаатай үзэл санааг чөлөөтэй илэрийлдэг үү?
5. Улс төрийн удирдлагыг хэрхэн бүрдүүлдэг вэ?
6. Улс төрийн анхаарал, харагдахуйц болон мэдрэмтгий байдалд байгаа хөтөлбөрийн хамрах хүрээ юу вэ?
7. Улс төрийн болон захиргааны удирдлагын чиг үүргийн хоорондын ажлын уялдаа холбоо ямар байна вэ?
8. Олон нийтийн ашиг сонирхлыг татсан тодорхой асуудал байна уу?
9. Нэг байгууллага төрийн салбарын босоо/шаталсан тогтолцоон дахь бусад холбогдох байгууллагуудад тааламжгүй нөлөөлөл үзүүлж байгаатай холбоотой туршлага юу байна вэ?
- 10.Залилангийн өндөр эрсдэлд хүргэхүйц ямар нэг улс төрийн анхаарах асуудал байна уу?
- 11.Нөөц ба хөрөнгийг ашиглахтай холбоотой улс төрийн төвийг сахьсан байр суурийн шаардлагуудыг агуулсан хууль, тогтоомж байна уу?

Хууль, тогтоомж ба бусад

1. Шалгагдагч байгууллага ба тухайлсан шалгах асуудалд аль хууль тогтоомж, дүрэм журмыг хэрэглэх нь тодорхой байна уу?
2. Өөр өөр хууль тогтоомжуудын хооронд давхардал эсвэл зөрчилдөх байдал байна уу?
3. Тухайн байгууллага нь хууль боловсруулдаг байгууллага эсэх хэрэв тийм бол хувь хүний эрхэд хууль боловсруулах үйл явц хэрхэн нөлөөлж байна вэ?
4. Хэрэв тухайн байгууллага хууль боловсруулдаг байгууллага бол ямар нэг эрх мэдлийг захиргааны эрх бүхий байгууллага эсвэл хувийн салбарын байгууллага зэрэг бусад байгууллагуудад итгэмжилж шилжүүлсэн үү?
5. Холбогдох хууль тогтоомж харьцангуй шинэ эсвэл бат бэх тогтсон уу?
6. Хэрэв шинэ бол тухайн хууль нь тодорхой ойлгогдож, хэрэглэгдэхүйцээр хэлбэр ба агуулга нь томъёологдсон уу?
7. Хэрэв бат бэх тогтсон бол тухайн хууль нь тодорхой ойлгогдож, хэрэглэгдэхүйц хууль эрх зүйн жишиг нь хангалттай байна уу?

8. Холбогдох хөтөлбөрийн хамрах хүрээ нь үйл ажиллагааны үнэлэмжээс ихээхэн хамаарч байна уу?
9. Хэрэв ач холбогдол бүхий үнэлэмж гаргасан бол үүнийг хууль тогтоомжийн зорилготой нийцүүлэн гаргасан уу?
10. Хэрэв ач холбогдол бүхий үнэлэмж гаргасан бол уялдаа холбоотой гаргасан уу?
11. Холбогдох хууль тогтоомжийг тайлбарлах ба түүнд нэмэлт хийхэд бусад байгууллага оролцсон уу?
12. Хөндлөнгийн нөлөөнөөс шалтгаалан ихээхэн хэмжээний санхүүгийн сөрөг үг дагавар гаргахгүй мөн хувь хүний эрхийг хөндөлгүйгээр тухайн байгууллага цаг хугацаанд нь чиг үүргээ гүйцэтгэдэг үү?
13. Нөлөөнд байгаа талуудын санал, гомдлыг хүлээж авах сувгийг зүй зохистой ашигладаг уу?
14. Тухайлсан хууль тогтоомж эсвэл дүрэм журмыг хэрэглэх ба тайлбарлахад ямар нэг хувь хүний/ байгууллагын эрх хөндөгдсөн үү?
15. Залилангийн өндөр эрсдэлд хүргэхүйц хууль, тогтоомжийн хүчин зүйл байна уу?

Ач холбогдол бүхий үйл явдал ба ажил гүйлгээ

1. Өндөр эрсдэл эсвэл залилангийн эрсдэлд (ихээхэн хэмжээний худалдан авалт, урт хугацаат барилгын гэрээ, гадаад валют солилцооны гэрээ, ихээхэн хэмжээний зээл эсвэл санхүүгийн худалдаа, хувьчлал гэх мэт санхүүгийн хэрэглүүрүүдийн хуваарилалт) хүргэхүйц ач холбогдол бүхий үйл явдал эсвэл ажил гүйлгээ байна уу?
2. Тухайн байгууллагад ач холбогдол бүхий үйл явдал ба ажил гүйлгээг гүйцэтгэх ба оролцох шаардлагатай эрх мэдэл, ур чадвар байна уу?
3. Ач холбогдол бүхий үйл явдал ба ажил гүйлгээтэй холбоотойгоор шинжээч нарыг оролцуулсан уу?
4. Хэрэв шинжээч нар оролцсон бол тэдний ур чадвар ба бодитой байдлыг баталгаажуулах ямар урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан бэ?
5. Шинжээч нарын ажлыг хэрхэн хянасан бэ?

Удирдлага

1. Удирдлагын багт тогтвортой байдал байгаа эсэх эсвэл гол ажилтнуудад өөрчлөлт гарсан эсэх?
2. Удирдлагын гишүүдийг яаж ажилд авдаг вэ? (бодит өрсөлдөөнтэй нээлттэй ба ил тод үйл явц эсвэл билэг тэмдэг бүхий үйл явц)
3. Эрсдэлийг үнэлэхэд удирдлага тогтмол идэвхтэй оролцдог уу?
4. Байгууллагын орчны өөрчлөлтийн үр дагавар болон шалгагдагч байгууллагад үзүүлэх нөлөөг удирдлага анхаарч үздэг үү?
5. Удирдлага консерватив хандлагатай эсвэл аз туршихад бэлэн байдаг уу?

6. Байгууллагад сөрөг нөлөө үзүүлж болохуйц ноцтой эрсдлүүдийг тогтоох ба тэдгээрээс зайлсхийх ямар санаачлагыг удирдлага гаргасан бэ?
7. Байгууллагыг бүхэлд нь хамруулан гүйцэтгэсэн эрсдэлийн үнэлгээг удирдлагын тохиромжтой түвшинд үр өгөөжтэйгээр мэдээлдэг үү?
8. Удирдлага өөрсдийн гаргасан шийдвэр ба авсан арга хэмжээнийхээ үр дагаврыг идэвхитэй хянаж, үнэлдэг үү?
9. Өмнөх аудитуудаар зөрчлийн, залилангийн, хууль бус үйлдлийн, ёс зүйгүй байдлын, удирдлагын зөрчлийн гэх мэт тохиолдлууд тогтоогдсон уу?
10. Удирдлага эрсдэлийг удирдах ба хууль тогтоомжийн нийцлийг баталгаажуулахын тулд хөтөлбөрийн зорилгын биелэлтийг хэрэгцээ шаардлагатай нь хэрхэн тэнцвэржүүлдэг вэ?

Хавсралт 4 – Тухайлсан шалгах асуудалтай холбоотой эрсдэлийн хүчин зүйлсийн жишээ

Худалдан авалт нь нийцлийн аудитын нийтлэг шалгах асуудал юм. Худалдан авалтанд хийх нийцлийн аудиттай холбоотой эрсдэлийн хүчин зүйлсийн жишээг дараах хүснэгтээр харуулав. Энэхүү жагсаалт нь өргөн хүрээг хамрахыг зориогүй. Тухайлсан аудитын нөхцөл байдал ба шалгах асуудлаас хамааран холбогдох эрсдэл ба эрсдэлийн хүчин зүйлс нь харилцан адилгүй байна.

Худалдан авалтын аудиттай холбоотой эрсдэлийн хүчин зүйлсийн жишээ	
Уламжлалт эрсдэл	
1	Худалдан авалтын холбогдох хууль тогтоомж дутмаг
2	Худалдан авалтын хууль тогтоомжид орсон сүүлийн үеийн өөрчлөлт (олон улсын хууль тогтоомжид нийцүүлэх гэх мэт)
3	Нарийн төвөгтэй эсвэл ойлгомжтой бус хууль тогтоомж, эсвэл тайлбар нь шийдэгдээгүй хууль тогтоомж
4	Батлан хамгаалахын худалдан авалт зэрэг ихээхэн хэмжээний мөнгөн дүн оролцсон худалдан авалт
5	Өмнө нь илрүүлсэн худалдан авалтын хууль тогтоомж ба заавруудтай холбоотой зөрчлийн хэлбэлзлийн аудитын илрүүлэлтүүд
6	Удирдлага ба гол ажилтнууд оролцсон урьд нь гарч байсан авилга ба залилангийн сажиг бүхий таамаглал эсвэл тохиолдлууд
7	Зохицуулагч эрх бүхий байгууллагын хяналт шалгалт (өрсөлдөөний эрх бүхий байгууллага гэх мэт)
8	Тендерийг олгохтой холбоотой шударга бус үйл ажиллагааны талаар боломжит нийлүүлэгчдээс ирсэн санал гомдол
9	Гарч болохуйц ашиг сонирхлын зөрчил
Хяналтын эрсдэл	
1	Сайн дотоод зааврууд дутмаг, түүний дотор тодорхой ба бодитой шалгуурууд дутмаг
2	Худалдан авалтын МТ-ийн тогтолцоотой холбоотой ерөнхий эсвэл хэрэглээний хяналтуудад гарсан сүүлийн үеийн өөрчлөлтүүд
3	Нийлүүлэгчидтэй холбоотой чанар муутай-хяналт эсвэл сул хяналтын үйл ажиллагаа
4	Нийлүүлэгчдийн ёс зүйн заавруудыг дагаж мөрдөж байгаатай холбоотой хяналт сул эсвэл байхгүй
5	Холбогдох хууль тогтоомжийн нийцэлтэй холбоотой хяналтын үйл ажиллагааны чанар муу эсвэл байхгүй
Илрүүлэлтийн эрсдэл	
1	Бодитой бус төлөвлөсөн аудитын горимууд (иж бүрэн байдлыг шалгахгүй зөвхөн бүртгэсэн ажил гүйлгээг шалгах горимуудыг гүйцэтгэх; эсвэл захиргааны удирдлагын ажилтан, нийлүүлэгчид эсвэл санал гомдлыг бүртгэдэг агентлагууд зэргээс бус харин зөвхөн худалдан авалтын газрын ажилтнуудаас асуулга авах)
2	Нотолгоог санаатайгаар нуух эсвэл далдлахад удирдлагыг хүргэж болзошгүй шагнал урамшуулал (жишээлбэл, нийлүүлэгчид авилга эсвэл хээл хахууль өгөх)

Хавсралт 5 – Сонгосон шалгах асуудлуудад хэрэглэх нийцлийн аудитын горимуудын жишээ

Энэхүү хүснэгтээр байгаль орчны тухай хууль тогтоомж ба хандивлагч байгууллагаас хүлээн авсан төслийн хөрөнгийн хүрээнд хэрэглэх нийцлийн аудитын горимуудын тайлбар жишээнүүдийг харуулав. Аудитын горимуудыг тухайлсан аудитын нөхцөл байдал ба зорилгод тохируулан төлөвлөх ёстой.

Аудитын жишиг горимууд	
Шалгах асуудал: Байгаль орчны тухай хууль тогтоомж	
1	Байгууллагын дагаж мөрдөх шаардлагатай холбогдох хууль тогтоомжийн төсөөлөлтэй болох
2	Шаардлагатай үед байгаль орчны тухай холбогдох хууль тогтоомжийн нийцлийг баталгаажуулах үйл явц ба тогтсон дэг журмын талаар удирдлагаас шаардлагатай бол дотоод аудитаас асуулга авах
3	Үйл явц ба холбогдох хяналтуудын талаар ойлголт олж авахын тулд гарын авлага ба тогтолцооны тодорхойлолтыг шалгаж үзэх. Үйл явцыг баримтжуулж, гол хяналтуудыг тогоох. Шаардлагатай бол гол хяналтуудыг шалгах
4	Байгууллагад өмнө нь байсан зөрчлийн тохиолдлуудыг тогтоохын тулд медиа хайлт ба шаардлагатай бол бусад мэдээллийн санд хайлт хийх
5	Хяналт шалгалтын тайлан, түүний дотор шаардлагатай бол дотоод аудитын тайланг шалгаж үзэх. Байгаль орчны тухай хууль тогтоомжийг зөрчсөн ноцтой эрсдэлийг илтгэх ямар нэг хамрах хүрээг хянах
6	Шалгагдагч байгууллагад шаардлагатай зөвшөөрөл ба холбогдох бүртгэлийн сертификат байгаа эсэхийг нягтлах
7	Байгаль орчин, эсвэл эрүүл мэнд ба аюулгүй байдлын хороодын хурлын тэмдэглэлүүдийг шалгаж үзэх
8	Холбогдох хэрэгжүүлж буй бодлого, журам, түүний дотор сургалтын талаар мөн эдгээр журмууд хэрхэн бодит байдал дээр хэрэгжиж байгаа талаар ойлголтыг олж авахын тулд сонгосон ажилтнуудаас ярилцлага авах
9	Өмнө нь байсан, одоо байгаа эсвэл гарч болохуйц байгаль орчны өр төлбөрийн нэхэмжлэлийн талаар мэдээлэл олж авахын тулд удирдлага шаардлагатай бол хуулийн зөвлөхөөс асуулга авах
10	Бодит байдал дээр хэрэгжиж буй үйл явц ба тогтсон дэг журмыг (хог хаягдлыг зайлуулах- зүй зохистой агуулах-зайлуулах гэх мэт) ажиглах ба зохистойгоор баримтжуулах (гэрэл зураг эсвэл видео зэрэг холбогдох нотлох баримт)

Аудитын жишиг горимууд

Шалгах асуудал: Хандивлагч байгууллагаас хүлээн авсан төслийн хөрөнгө

1	Байгууллага дагаж мөрдөх шаардлагатай санхүүжилтийн хэлэлцээр ба холбогдох хууль тогтоомж, зааврууд бүрэн эрх зэргийн талаар төсөөлөлтэй болох
2	Санхүүжилтийн хэлэлцээрийн нөхцөлүүд ба холбогдох хууль тогтоомж, зааврууд, бүрэн эрх зэргийг дагаж мөрдөж байгааг баталгаажуулах үйл явц ба тогтсон дэг журмын талаар удирдлага шаардлагатай бол дотоод аудитаас асуулга авах. Зохистой нягтлан бодох бүртгэл ба тодруулгыг батлагаажуулах тогтсон хэв журмын талаарх асуулга
3	Санхүүжилтийн хэлэлцээрийн нийцэлтэй холбоотой үйл явц ба холбогдох хяналтуудыг ойлгохын тулд гарын авлага ба тогтолцооны тайлбарыг хянаж үзэх. Үйл явцыг баримтжуулах ба гол хяналтуудыг тодорхойлох. Шаардлагатай бол гол хяналтуудыг шалгах.
4	Эрсдэлийг үнэлэхэд шинжилгээний горимуудыг, шаардлагатай гэж үзсэн үед нарийвчилсан горимуудыг гүйцэтгэнэ. Жишээлбэл, төсөв ба өмнөх жилийн санхүүгийн мэдээлэлтэй одоогийн санхүүгийн ямар нэг мэдээлэл, түүний дотор төслийн дансуудыг харьцуулах. Шаардлагатай нөхцөл байдалд сэжиг бүхий зөрчлийг давтан шалгах. Төслийн дансуудад энгийн бус эсвэл ач холбогдол бүхий ажил гүйлгээ байгаа эсэхийг шалгах. Шаардлагатай үед дахин шалгах
5	Төслийн хөрөнгөтэй холбоотой ажил гүйлгээг түүвэрлэх. Сонгосон ажил гүйлгээ бүрийн санхүүжилтийн хэлэлцээрийн нөхцөлүүд ба ямар нэг холбогдох хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэхийг шалгах. Жишээлбэл: <ul style="list-style-type: none">• Хөрөнгийн ашиглалттай холбоотой шаардлагууд• Шаардлагатай зөвшөөрөл ба эрх олголт• Тайлагнах шаардлагууд• Шаардлагатай нягтлан бодох бүртгэл ба тодруулга, түүний дотор зохистой нягтлан бодох бүртгэлийн бодлого ба зохистой хугацаан дахь ажил гүйлгээний бүртгэл гэх мэт
6	Төслийн хөрөнгийг тусгай зориулалтаар ашигласан тохиолдолд биет хяналт шалгалтыг гүйцэтгэх хэрэгцээ шаардлагыг үнэлэх. Шаардлагатай бол дахин шалгах.
7	Ямар нэг холбогдох асуудлыг тодорхойлохын тулд холбогдох хурлуудын албан бичиг ба тэмдэглэлүүдийг хянаж үзэх. Шаардлагатай бол дахин шалгах.
8	Гуравдагч талаас ямар нэг бичгээрх баталгаажуулалт олж авах хэрэгцээ шаардлагыг харгалзаж үзэх ба шаардлагатай бол дахин шалгах.
9	Санхүүжилтийн хэлэлцээртэй холбоотойгоор удирдлагаас тусгай бичгээрх тайлбар мэдүүлэг олж авах хэрэгцээ шаардлагыг харгалзаж үзэх
10	Хөрөнгийн зохистой хугацаанд бүртгэсэн эсэхийг баталгаажуулахад шаардлагатай сорилыг (тухайн хугацаагаар нь зогсоож) гүйцэтгэх ба шалгах

Хавсралт 6 – Нийцлийн хэлбэлзлийн жишээ

Дараах хүснэгтээр нийцлийн хэлбэлзлийн жишээнүүд харуулсан ба үүнд материаллаг байдал болон дүгнэлт гаргахтай холбоотой анхаарах асуудлууд тусгагдсан болно. Материаллаг байдал ба дүгнэлт гаргахтай холбоотой тайлбар нь тухайлсан жишээ материаллаг хэлбэлзлийг агуулж байгаа эсвэл үгүй эсэхийг үнэлэх тодорхой үнэлгээг бус харин холбогдох анхаарах зүйлсийг тодруулж өгөхийг зорьсон. Материаллаг байдлыг тогтоох нь тухайн нөхцөл байдал ба төрийн аудитуудын мэргэжлийн үнэлэмж зэргээс хамаарна.

Нийцлийн хэлбэлзлийн жишээ		Материаллаг байдал ба дүгнэлт гаргахтай холбоотой анхаарах зүйлс
1	Тайлант жилийн хугацаанд засгийн газрын агентлаг Боловсролын яамнаас үндэсний боловсролыг дэмжих зорилгоор санхүүжилт авсан. Агентлагийн тайлант хугацаан дахь тусламжийн зардалд хилийн чанад дахь дэвшилтэт технологийн үйлдвэрлэгчдэд олгосон 10 сая долларыг тусгажээ.	Засгийн газрын агентлагын хууль тогтоомж дээр үндэслэн тухайн агентлаг чанад дахь байгууллагуудад тусламж олгох бүрэн эрхгүй. Тусламжийн зардал нь хилийн чанад дахь байгууллагуудад олгогдсон ба холбогдох хууль тогтоомжтой нийцээгүй бөгөөд хууль тогтоох байгууллагаас олгосон зорилгын дагуу ашиглагдаагүй учраас зөрчил нь материаллаг байж болно.
2	Засгийн газрын агентлаг хууль тогтоох байгууллагаас баталсан төсөвт зөвшөөрсөн нийт зардал болох 5000 доллар дээр илүү 100 долларыг тайлант хугацаанд зардлаар тусгасан.	Энэ тохиолдолд бодит зардал нь баталсан төсвөөр зөвшөөрсөн хэмжээнээс илүү байна. Энэ нь тодорхой тогтоосон хууль тогтоомжийг илэрхий зөрчиж байгаа тул энэхүү зөрчил материаллаг байж болох юм. Нөхцөл байдал, түүний дотор зардлын төрөл зүйлээс шалтгаалан энэ нь мөн чанарын хувьд мэдрэмтгий байж бас болох юм.
3	Иргэн сард 1000 долларын тэтгэвэр авах эрхтэй. Засгийн газрын агентлаг сар бүр зөвхөн 900 долларыг олгож байсан. Төлбөрийг хууль тогтоомжинд заасан хугацаанаас хойш хийж байжээ.	Энэхүү мөнгөн дүн хэмжээ нь засгийн газрын агентлагийн санхүүгийн тайланд материаллаг бус байж болох ч зөрчлийн үр дагаврууд нь тогтмол орлоготой тэтгэврийн хүн бүрт их хэмжээтэй байх магадлалтай. Хэрэв зөрчил нь тогтолцооны сул байдлаас шалтгаалж байгаа бол бусад олон иргэдэд нөлөөлж болох юм. Тэгэхээр энэ зөрчил нь ерөнхийдөө ард иргэд ба нийгэмд үзүүлэх нөлөөлийнхөө хувьд материаллаг байж болно.
4	Өрх толгойлсон эх 18 наснаас доош насны хүүхэд бүртээ сар бүр хүүхдийн тэтгэмж авах эрхтэй. Засгийн газрын агентлаг 19 настай хүүхдэд хүүхдийн тэтгэмж олгосон.	Энэхүү зөрчлийн хэлбэлзэл нь хүлээн авагч талд эерэг нөлөөтэй боловч хууль тогтоомж ба түүний зорилгод нийцээгүй учир бусад тэтгэмж хүртэгсдэд шударга биш байж болно. Хэрэв зөрчил нь тогтолцооны сул байдлаас шалтгаалж байгаа бол бусад олон иргэдэд нөлөөлж болох юм. Тэгэхээр энэ зөрчил нь

		ерөнхийдөө ард иргэд ба нийгэмд үзүүлэх нөлөөлийнхөө хувьд материаллаг байж болно.
5	Барилгын тухай хуулийн нөхцөл нь жил бүр хяналт шалгалтыг гүйцэтгэхийг шаарддаг. Засгийн газрын агентлаг сүүлийн 5 жилд хяналт шалгалтыг гүйцэтгээгүй.	Зөрчил нь аюулгүй байдлын үр дагавар зэрэг чанарын талуудаас шалтгаалан ихээхэн хэмжээтэй байж болно. Тодорхой мөнгөн дүн хэмжээ оролцоогүй ч гэсэн барилгыг эзэмшигчдийн аюулгүй байдалд нөлөөлж болох үр дагавраас хамааран зөрчил нь материаллаг байж болох юм. Байгалийн гамшигийн тохиолдолд зөрчил нь засгийн газрын агентлагыг материаллаг санхүүгийн үр дагавар бүхий ихээхэн хэмжээний өр төлбөрийн нэхэмжлэлд хүргэх эрсдэл бас байж болох юм.
6	Санхүүжилтийн хэлэлцээрийн нөхцөлүүдэд санхүүжилт хүлээн авагч тал нь санхүүгийн тайлан бэлтгэж, тогтоосон хугацаанд хандивлагч байгууллагуудад илгээнэ гэж заасан. Санхүүгийн тайланг тогтоосон хугацаанд бэлтгэж, илгээгүй.	Санхүүгийн тайланг дараа нь бэлтгэж, илгээсэн эсэх, хожимдуулсан хугацаа, хожимдуулсан шалтгаан ба зөрчлийн үр дүнд үүсэж болох ямар нэг нөхцөл байдал зэргээс шалтгаалан тухайн зөрчил нь материаллаг эсвэл материаллаг бус байж болно.
7	Татварын тухай хуулийн дагуу бүрдүүлсэн орлоготой холбоотой ач холбогдол бүхий тогтолцооны сул талыг тогтоосон. Сул тал нь шалгагдагч байгууллага татварын тухай хуулийг буруу тайлбарласнаас улбаатай. Татвар төлөгчдөд төлөх ёстойгоос нь илүү татвар ногдуулсан маш олон тохиолдлуудыг тогтоосон.	Зөрчлийн хэлбэлзлийн энэ төрөл нь иргэн бүрийн эрхийн зохих ёсны үйл ажиллагаатай холбоотой. Зарим иргэдэд илүү татвар ногдуулж харин бусдад нь ямар ч татвар ногдуулаагүй. Тогтолцооны сул талтай холбоотой учир нөхцөл байдлаас шалтгаалан энэхүү хэлбэлзэл нь материаллаг ба өргөн хүрээг хамарсан байж болох ба энэ тохиолдолд нийцлийн талаар сөрөг дүгнэлт өгвөл тохиромжтой.

Хавсралт 7 – Санхүүгийн тайлангийн талаар Аудиторын дүгнэлтийн нэг хэсэг болох Нийцлийн аудитын дүгнэлтийн жишээ

Энэхүү баримт бичгийн үндсэн хэсэгт тайлбарласанчлан АДБ-ын бүрэн эрх, холбогдох хууль тогтоомж, уламжлалт тайлагналын туршлага, тайлагнах асуудлын нарийн төвөгтэй байдал зэргээс шалтгаалан тайлагналын хэлбэр нь харилцан адилгүй байна. Гэхдээ тайлагналын загвар дахь зарим тогтвортой байдал нь аудиторын тайлангийн хэрэглэгчдэд гүйцэтгэсэн ажил, хүрсэн дүгнэлтийг ойлгох мөн түүнчлэн энгийн бус нөхцөл байдал үүсэх үед тэдгээрийг тогтооход тусалж болно.

Дараах “товч хэлбэрийн” тайлангийн жишээ нь зөвхөн тайлбарын зорилготой. Зарим АДБ-ууд илрүүлэлтүүдийг санал эсвэл дүгнэлтийн хэсгийн өмнө тайлангийн үндсэн хэсэгт дэлгэрэнгүй тайлбарласан “дэлгэрэнгүй хэлбэрийн” тайланг ашиглаж болно. Санал дүгнэлтийн хэсгийн хэлбэр ба агуулга нь тухайн АДБ-ын бүрэн эрхээс хамааран харилцан адилгүй байж болох юм.

XXX-ын АДБ-ын Аудитын тайлан

[Хууль тогтоох байгууллага, Парламент гэх мэт хүлээн авагчийн хаяг]

Санхүүгийн тайланд өгөх дүгнэлт тайлан

Бид 20X1 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн гүйцэтгэлийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, тайлант жилийн эцсээрх мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн чухал бодлогуудын болон бусад тайлбар мэдээллийн хураангуйг багтаасан засгийн газрын ABC агентлагийн санхүүгийн тайлангуудад аудит хийлээ.

Санхүүгийн тайлантай холбогдуулан удирдлагын хүлээх хариуцлага

[Удирдлагын үүрэг хариуцлагыг заасан хууль тогтоомж/дүрэм журмийн нэрийг бичих] - д зааснаар удирдлага нь *[Улсын салбарын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, XYZ улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн төрийн нягтлан бодох бүртгэлийн зарчмууд гэх мэт холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартуудыг бичих]* -ын дагуу эдгээр санхүүгийн тайлангуудыг² бэлтгэж, толилуулах хариуцлагагыг хүлээнэ. Энэ үүрэг хариуцлагад залилан эсвэл алдаанаас шалтгаалан материаллаг хэмжээний буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх ба толилуулахтай холбоотой дотоод хяналтыг төлөвлөх, хэрэгжүүлэх ба хадгалах багтана.

Аудиторын хүлээх хариуцлага

² Найруулга нь АОУС 700 ба төрийн салбар дахь нийцлийн нийтлэг үзэл баримтлал дээр үндэслэнэ. Үнэн зөв толилуулгын үзэл баримтлалтай холбоотой найруулгыг АОУС 700-аас харна уу.

Бидний хүлээх хариуцлага нь аудитдаа тулгуурлан санхүүгийн тайлангуудад дүгнэлт өгөх явдал юм. Бид аудитаа *[Холбогдох аудитын стандартууд: жишээлбэл ИНТОСАИ-н Аудитын үндсэн зарчмууд ба гарын авлага, Аудитын олон улсын стандарт³, XYZ улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн төрийн аудитын стандартууд, гэх мэт]-д нийцүүлэн гүйцэтгэлээ. Эдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудыг мөрдөж⁴, санхүүгийн тайлангууд нь материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгааг олж авахын тулд аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг.*

Санхүүгийн тайлангуудад багтсан дүн ба тодруулгуудын тухай аудитын нотолгоог цуглуулах горимуудыг гүйцэтгэх нь аудитын хүрээнд багтана. Сонгосон горимууд нь залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлангууд материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийн үнэлгээг багтаасан аудиторын үнэлэмжээс шалтгаална. Эрсдэлийн ийм үнэлгээг хийхдээ байгууллагын дотоод хяналтын үр өгөөжтэй байдлын⁵ талаар дүгнэлт өгөх зорилгоор бус харин нөхцөл байдалд тохиромжтой аудитын горимыг тодорхойлохыг тулд байгууллагын санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулахтай холбоотой дотоод хяналтыг харгалзан үздэг. Мөн ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын зохимжтой байдал ба удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэлтэй байдал мөн түүнчлэн санхүүгийн тайлангуудыг ерөнхий толилуулгыг үнэлэх явдал аудитад хамаарна.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн суурь болоход хангалттай ба зохистой гэдэгт бид итгэж байна.

Дүгнэлт

Бидний үзэж байгаагаар 20X1 оны 12 дугаар сарын 31-нээрх засгийн газрын ABC агентлагийн санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг байдлын хувьд *[Холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартууд: Улсын салбарын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартууд, XYZ улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн төрийн нягтлан бодох бүртгэлийн зарчмууд, зэргийг бичих]-ын дагуу толилуулсан байна.*

Хуулийн болон зохицуулалтын бусад шаардлагад хамаарах дүгнэлт тайлан

[Аудиторын бусад тайлагналын хариуцлагын үндсэн шинжээс шалтгаалан аудиторын тайлангийн энэ хэсгийн хэлбэр, агуулга харилцан адилгүй байна.]

[Зарим эрх зүйн орчинд аудитор нь санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлт илэрхийлэх хариуцлагын зэрэгцээ АОУС 700-гын 35-36 дугаар зүйл буюу А37-А38-д тайлбарласанчлан бусад асуудлаар тайлагнах нэмэлт хариуцлага хүлээж болно.

³ Аудиторууд АОУС 200 ба аудиттай холбоотой бүх АОУС-уудыг дагаж мөрдөөгүй бол АОУС-ын нийцлийн талаар илэрхийлэхгүй байж болно. Хэрэв АОУС-уудын нийцлийн талаар илэрхийлэх бол аудиторууд илүү тохирсон найруулгыг сонгохын тулд АОУС 700-г зааварчилгаа болгоно.

⁴ Ашигласан заавар/стандартуудад үндэслэн шаардлагатай бол найруулгыг хэрэглэнэ.

⁵ Хэрэв дотоод хяналтын талаар санал дүгнэлтийг илэрхийлэх бол найруулгыг тохиромжтой байдлаар өөрчилнө.

Нийцлийн талаар өгөх дүгнэлт тайлан

[Тэмдэглэл: АДБ-ын бүрэн эрх ба бусад тайлагналын хариуцлагаас шалтгаалан аудиторын тайлангийн энэ хэсгийн хэлбэр, агуулга нь нөхцөл байдлуудад харилцан адилгүй байна.]

Нийцлийн талаарх удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэх ба толилуулах дээр тайлбарласан хариуцлагын зэрэгцээ удирдлага нь санхүүгийн тайлангуудад тусгагдсан үйл ажиллагаа, санхүүгийн ажил гүйлгээ ба мэдээлэл нь хууль тогтоомжтой нийцэж байгааг баталгаажуулах хариуцлага бас хүлээнэ.

Аудиторын хариуцлага

Санхүүгийн тайлангуудийн талаар санал дүгнэлт илэрхийлэх дээр тайлбарласан хариуцлагын зэрэгцээ санхүүгийн тайлангуудад тусгагдсан үйл ажиллагаа, санхүүгийн ажил гүйлгээ ба мэдээлэл нь бүх материаллаг байдлын хувьд хууль тогтоомжуудтай нийцэж байгаа эсэх дээр дүгнэлт илэрхийлэх нь бидний хариуцлагад хамаарна. Энэ хариуцлагад агентлагийн зардал ба орлого нь хууль тогтоох байгууллагаас төлөвлөсөн зорилгоор хэрэглэгдсэн эсэх талаар аудитын нотолгоо олж авахын тулд горимуудыг гүйцэтгэх багтана. Эдгээр горимуудад материаллаг зөрчлийн эрсдлүүдийн үнэлгээ багтана.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн суурь болоход хангалттай ба зохистой гэдэгт бид итгэж байна.

Нийцлийн талаарх дүгнэлт

Бидний үзэж байгаагаар санхүүгийн тайлангуудад тусгагдсан үйл ажиллагаа, санхүүгийн ажил гүйлгээ ба мэдээлэл нь бүх материаллаг байдлын хувьд хууль тогтоомжуудтай нийцэж байна.

[Тохиромжтой бол шалгагдагч байгууллагас ирүүлсэн хариуг оруулах, жишээлбэл Дүгнэлтийн хэсгийн дараа “Шалгагдагч байгууллагаас ирүүлсэн хариу” гарчиган доор хураангуйгаар, эсвэл тусдаа хавсралтаар]

[Тохиромжтой бол бүтээлч зөвлөмжийг оруулах, жишээлбэл Дүгнэлтийн хэсгийн дараа “Зөвлөмж” гарчгийн доор хураангуйгаар эсвэл тусдаа хавсралтаар]

[Аудиторын гарын үсэг]

[Аудиторын тайлангийн огноо]

[Аудиторын хаяг]

Хавсралт 8 – Нийцлийн талаарх хязгаарлалттай дүгнэлтийн жишээ

Энэхүү жишээ нь хууль тогтоомж, ялангуяа хууль тогтоох байгууллагаас гаргасан хууль тогтоомж, зорилго ба төлөвлөгөөг зөрчсөн нөхцөл байдалд хамаарна. Аудитор нь зөрчлийн нөлөөг материаллаг гэхдээ өргөн хүрээтэй бус гэж тогтоосон. Тайлангийн танилцуулгын хэсэг ба нийцлийн дүгнэлтийн дараагийн хэсгүүд Хавсралт 7 дахь жишээнээс өөрчлөгдөөгүй болно.

.....[Тайлангийн тохиромжтой танилцуулгын хэсэг].....

Нийцлийн талаарх дүгнэлт тайлан

.....[тохиромжтой танилцуулгын текст].....

Нийцлийн талаарх хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Тайлант жилд засгийн газрын ABC агентлаг нь үндэсний боловсролыг дэмжих зорилгоор Боловсролын яамнаас төсвийн санхүүжилтийг хүлээн авсан. Бид аудитаар тухайн жилийн тусламжийн зардалд хилийн чанад дахь дэвшилтэт технологийн үйлдвэрлэгчдэд олгосон 10 сая долларыг багтаасан байсныг илрүүлсэн.

[Шалгаагдагч байгууллагыг удирдаж буй хууль тогтоомж] дээр үндэслэн засгийн газрын ABC агентлаг хилийн чанад дахь байгууллагуудад тусламж олгох эрхгүй. Хилийн чанад дахь байгууллагуудад төлсөн тусламжтай холбоотой зардал нь хууль тогтоох байгууллагаас төлөвлөсөн зорилгын дагуу ашиглагдаагүй учраас хууль тогтоомжтой нийцэхгүй байна.

Нийцлийн талаарх дүгнэлт

Бидний үзэж байгаагаар дээр дурдсан Нийцлийн талаарх хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэлд тайлбарласан хилийн чанад дахь байгууллагуудад олгосон зардлыг эс тооцвол санхүүгийн тайлангуудад тусгагдсан үйл ажиллагаа, санхүүгийн гүйлгээ ба мэдээлэл нь бүх материаллаг байдлын хувьд хууль тогтоомжуудтай нийцэж байна.

.....[тайлангийн тохиромжтой төгсгөлийн хэсэг].....

Хавсралт 9 – Нийцлийн талаарх сөрөг дүгнэлтийн жишээ

Энэхүү жишээ нь хууль тогтоомж, ялангуяа хууль тогтоох байгууллагын холбогдох хууль тогтоомж, зорилго ба төлөвлөгөөг зөрчсөн нөхцөл байдалд хамаарна. Аудитор нь зөрчлийн нөлөөг материаллаг ба өргөн хүрээтэй гэж тогтоосон. Тайлангийн танилцуулгын хэсэг ба нийцлийн дүгнэлтийн дараагийн хэсгүүд Хавсралт 7 дахь жишээнээс өөрчлөгдөөгүй болно.

.....[Тайлангийн тохиромжтой танилцуулгын хэсэг].....

Нийцлийн талаарх дүгнэлт тайлан

.....[тохиромжтой танилцуулгын текст].....

Нийцлийн талаарх сөрөг дүгнэлтийн үндэслэл

Тайлант жилд засгийн газрын ABC агентлаг нь нийт 500 сая долларын нийгмийн халамжийн тэтгэмжийг олгосон. Олгосон нийт нийгмийн халамжийн 90 хувь нь тэтгэврийн төлбөрөөр бүртгэгдсэн. Олгогдсон дүн хэмжээг санхүүгийн тайлангуудад үнэн зөв тусгасан байна. Гэхдээ тэтгэврийн төлбөрийг хийхэд ашигласан МТ тогтолцооны хүрээлэгч хяналтуудад тогтоосон сул талууд нь төлбөр [холбогдох нийгмийн халамжийн хууль тогтоомж, дүрэм журам зэргийг бичих]-д заасан хугацаандаа хийгдэхгүй байгааг олж илрүүлсэн. Энэ сул талын үр дагавар нь тэтгэвэр авах эрх олгогдсон иргэний эрхийг зөрчиж байж болох юм.

Нийцлийн талаарх дүгнэлт

Бидний үзэж байгаагаар дээр дурдсан Нийцлийн талаарх сөрөг дүгнэлтийн үндэслэлд тайлбарласан асуудлын ач холбогдлоос хамааран санхүүгийн тайлангуудад тусгагдсан үйл ажиллагаа, санхүүгийн гүйлгээ ба мэдээлэл нь бүх материаллаг байдлын хувьд хууль тогтоомжуудтай нийцэхгүй байна.

.....[тайлангийн тохиромжтой төгсгөлийн хэсэг].....

Хавсралт 10 – Нийцлийн талаарх татгалзсан дүгнэлтийн жишээ

Аудитор хууль тогтоомж, ялангуяа хууль тогтоох байгууллагын холбогдох хууль тогтоомж, зорилго ба төлөвлөгөөтэй зардлууд нь нийцэж байгаа эсэх талаар хангалттай ба зохистой аудитын нотолгоог олж авах боломжгүй байсан нөхцөл байдлыг энэ жишээнд тусгасан. Аудитор нь зөрчлийн нөлөөг материаллаг ба өргөн хүрээтэй гэж тогтоосон. Тайлангийн танилцуулгын хэсэг ба нийцлийн дүгнэлтийн дараагийн хэсгүүд Хавсралт 7 дахь жишээнээс өөрчлөгдөөгүй болно.

.....[Тайлангийн тохиромжтой танилцуулгын хэсэг].....

Нийцлийн талаарх дүгнэлт тайлан

.....[төхиромжтой танилцуулгын текст].....

Нийцлийн талаарх татгалзсан дүгнэлтийн үндэслэл

Тайлант жилд засгийн газрын ABC агентлаг нь үндэсний боловсролыг дэмжих зорилгоор Боловсролын яамнаас төсвийн санхүүжилтийг хүлээн авсан. Бид аудитаар тухайн жилийн санхүүгийн тайланд тусгагдсан тусламжийн зардалд хувийн судалгаа шинжилгээний байгууллагуудад олгосон 10 сая долларыг багтаасан байсныг илрүүлсэн. Энэ тусламж нь тайлант жилийн нийт тусламжийн зардлын 90 хувиар бүртгэгдсэн байна.

Бидэнд байгаа нотолгоо нь тусламжийн зардал нь [холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, зэргийг бичих]-ын дагуу олгогдсон эсэхийг тогтооход хязгаарлагдмал байна. Далайн шуурганы хор хохирлоос шалтгаалан засгийн газрын ABC агентлаг нь хувийн судалгаа шинжилгээний байгууллага энэхүү тусламжийг авах шаардлагыг хангасан гэдгийг нотлох хангалттай баримтжуулалтаар хангах боломжгүй байна. Төлбөрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу, хууль тогтоох байгууллагаас төлөвлөсөн зорилгод ашигласан эсэхийг тодорхойлоход бидэнд хэрэглэх шаардлага хангасан горимууд байхгүй байна.

Нийцлийн талаарх татгалзсан дүгнэлт

Нийцлийн талаарх татгалзсан дүгнэлтийн үндэслэлд тайлбарласан хамрах хүрээний хязгаарлагдмал байдлаас хамааран санхүүгийн тайлангуудад тусгагдсан үйл ажиллагаа, санхүүгийн гүйлгээ ба мэдээлэл нь бүх материаллаг байдлын хувьд хууль тогтоомжуудтай нийцсэн эсэх талаар бид дүгнэлт гаргах боломжгүй байна.

.....[тайлангийн тохиромжтой төгсгөлийн хэсэг].....

Хавсралт 11 – Асуудлыг онцолсон зүйл ба бусад асуудал(ууд) зүйлийн жишээ

Зарим нөхцөл байдалд нийцлийн дүгнэлтэд нөлөөлөхгүй тодорхой асуудлуудыг нарийвчлан үзэх хэрэгцээ шаардлага гарч болно. Эдгээр нөхцөл байдлуудад ашиглах асуудлыг онцолсон зүйл ба бусад асуудал зүйлүүдийг дараах жишээнүүдээр тайлбарлалаа. Тайлангийн танилцуулгын хэсэг ба нийцлийн дүгнэлтийн дараагийн хэсгүүд Хавсралт 7 дахь жишээнээс өөрчлөгдөөгүй болно.

.....[Тайлангийн тохиромжтой танилцуулгын хэсэг].....

Нийцлийн талаарх дүгнэлт тайлан

.....[тохиромжтой танилцуулгын текст].....

Нийцлийн талаарх дүгнэлт

Бидний үзэж байгаагаар санхүүгийн тайлангуудад тусгагдсан үйл ажиллагаа, санхүүгийн ажил гүйлгээ ба мэдээлэл нь бүх материаллаг байдлын хувьд хууль тогтоомжуудтай нийцэж байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Бид санхүүгийн тайлангуудын Тэмдэглэл хх-д анхаарлаа хандуулсан. Энэ тэмдэглэл нь 20хх.хх.хх өдрийн байгаль орчны тухай хууль тогтоомжийн шаардлагуудын талаарх байгууллагын тайлбартай холбоотой хараахан эцэслэн шийдэгдээгүй хууль эрх зүйн шийдвэрийн тодорхой бус байдлыг тайлбарласан. Энэ асуудалтай холбоотойгоор бидний дүгнэлт хязгаарлагдаагүй юм.

Бусад асуудлууд

Бид ABC агентлагийн хууль эрх зүйн хүрээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 20хх.хх.хх өдрийн худалдан авалтын тухай хууль тогтоомжийн нийцэл дээр анхаарлаа хандуулсан. Энэ хууль тогтоомжийн нөхцөлүүд нь ZZZ ерөнхий худалдааны хэлэлцээрт оролцогч талуудын бүх эрх зүйн хүрээнд хэрэгжүүлж буй 20уу.уу.уу өдрийн худалдан авалтын тухай хууль тогтоомжийн нөхцөлүүдтэй зөрчилдөж байна. Үүнд ABC агентлагийн эрх зүйн хүрээ хамаарна. Хууль тогтоох байгууллагаас энэ асуудалд цаашид анхаарал хандуулах шаардлагатай бөгөөд ингэснээр 20хх.хх.хх өдрийн худалдан авалтын тухай хууль тогтоомжид нийцсэн шаардлагатай нэмэлт өөрчлөлтүүдийг баталж болох юм.

.....[тайлангийн тохиромжтой төгсгөлийн хэсэг].....

Хавсралт 12 – Санхүүгийн тайлангийн талаар үндэслэлтэй баталгаажуулалтын дүгнэлттэй ба нийцлийн талаар хязгаарлагдмал баталгаажуулалтын дүгнэлттэй санхүүгийн тайлангийн талаарх аудиторын тайлангийн жишээ

Энэ гарын авлага нь төрийн аудиторуудыг байгууллагын хууль тогтоомжийн нийцлийн талаар үндэслэлтэй баталгаажуулалтын дүгнэлтийн хэлбэрээр тайлагнах заавраар хангахад чиглэгдсэн. Гэхдээ энэ баримт бичгийн үндсэн хэсэгт заасанчлан зарим АДБ-уудын бүрэн эрх нь нийцлийн аудитын дүгнэлтийг төрийн аудиторууд аудитын бусад чиг үүргээ гүйцэтгэж байх явцад тэдний анхаарлыг татсан ажил гүйлгээ нь хууль тогтоомжуудтай нийцэж байгаа эсэхийг эсвэл аудитын явцад тэдний анхаарлыг татахаар хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдлууд байхгүй байгааг тогтоохоор хязгаарладаг.

Дараах “ товч хэлбэрийн” тайлангийн жишээ нь хязгаарлалттай баталгаажуулалтаар хангасан зөвхөн цөөн тооны тусгай нөхцөл байдлуудад хэрэглэгдэх тайлбарын зорилготой юм. Зарим АДБ-ууд илрүүлэлтийг санал эсвэл дүгнэлтийн хэсгийн өмнө буюу тайлангийн үндсэн хэсэгт дэлгэрэнгүй тайлбарласан “дэлгэрэнгүй хэлбэрийн” тайланг хэрэглэж болно. Дүгнэлтийн хэсгийн хэлбэр, агуулга нь АДБ-ын тодорхой бүрэн эрхээс хамааран харилцан адилгүй байна.

XXX-ын АДБ-ын Аудитын тайлан

[Хууль тогтоох байгууллага, Парламент гэх мэт хүлээн авагчийн хаяг]

Санхүүгийн тайланд өгөх дүгнэлт тайлан

Бид 20X1 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн тайлангийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, тайлант жилийн эцсээрх мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн чухал бодлогуудын болон бусад тайлбар мэдээллийн хураангуйг багтаасан засгийн газрын АВС агентлагийн санхүүгийн тайлангуудад аудит хийлээ.

Санхүүгийн тайлантай холбогдуулан удирдлагын хүлээх хариуцлага

[Удирдлагын үүрэг хариуцлагыг заасан хууль тогтоомж/дүрэм журмийн нэрийг бичих] - д зааснаар удирдлага нь [Улсын салбарын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, ХҮЗ улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн төрийн нягтлан бодох бүртгэлийн зарчмууд гэх мэт холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартуудыг бичих] -ын дагуу эдгээр санхүүгийн тайлангуудыг⁶ бэлтгэж, толилуулах хариуцлагагыг хүлээнэ. Энэ

⁶ Найруулга нь АОУС 700 ба төрийн салбар дахь нийцлийн нийтлэг үзэл баримтлал дээр үндэслэнэ. Үнэн зөв толилуулгын үзэл баримтлалтай холбоотой найруулгыг АОУС 700-аас харна уу.

үүрэг хариуцлагад залилан эсвэл алдаанаас шалтгаалан материаллаг хэмжээний буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх ба толилуулахтай холбоотой дотоод хяналтыг төлөвлөх, хэрэгжүүлэх ба хадгалах багтана.

Аудиторын хүлээх хариуцлага

Бидний хүлээх хариуцлага нь аудитдаа тулгуурлан санхүүгийн тайлангуудад дүгнэлт өгөх явдал юм. Бид аудитаа *[Холбогдох аудитын стандартууд: жишээлбэл ИНТОСАИ-н Аудитын үндсэн зарчмууд ба гарын авлага, Аудитын олон улсын стандарт⁷, XYZ улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн төрийн аудитын стандартууд, гэх мэт]-д нийцүүлэн гүйцэтгэлээ. Эдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудыг мөрдөж⁸, санхүүгийн тайлангууд нь материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгааг олж авахын тулд аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг.*

Санхүүгийн тайлангуудад багтсан дүн ба тодруулгуудын тухай аудитын нотолгоог цуглуулах горимуудыг гүйцэтгэх нь аудитын хүрээнд багтана. Сонгосон горимууд нь залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлангууд материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийн үнэлгээг багтаасан аудиторын үнэлэмжээс шалтгаална. Эрсдэлийн ийм үнэлгээг хийхдээ байгууллагын дотоод хяналтын үр өгөөжтэй байдлын⁹ талаар дүгнэлт өгөх зорилгоор бус харин нөхцөл байдалд тохиромжтой аудитын горимыг тодорхойлохыг тулд байгууллагын санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулахтай холбоотой дотоод хяналтыг харгалзан үздэг. Мөн ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын зохимжтой байдал ба удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэлтэй байдал мөн түүнчлэн санхүүгийн тайлангуудыг ерөнхий толилуулгыг үнэлэх явдал аудитад хамаарна.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн суурь болоход хангалттай ба зохистой гэдэгт бид итгэж байна.

Дүгнэлт

Бидний үзэж байгаагаар 20X1 оны 12 дугаар сарын 31-нээрх засгийн газрын ABC агентлагийн санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг байдлын хувьд *[Холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартууд: Улсын салбарын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартууд, XYZ улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн төрийн нягтлан бодох бүртгэлийн зарчмууд, зэргийг бичих]-ын дагуу толилуулсан байна.*

Нийцлийн шалгалт

⁷ Аудиторууд АОУС 200 ба аудиттай холбоотой бүх АОУС-уудыг дагаж мөрдөөгүй бол АОУС-ын нийцлийн талаар илэрхийлэхгүй байж болно. Хэрэв АОУС-уудын нийцлийн талаар илэрхийлэх бол аудиторууд илүү тохирсон найруулгыг сонгохын тулд АОУС 700-г зааварчилгаа болгоно.

⁸ Ашигласан заавар/стандартуудад үндэслэн шаардлагатай бол найруулгыг хэрэглэнэ.

⁹ Хэрэв дотоод хяналтын талаар санал дүгнэлтийг илэрхийлэх бол найруулгыг тохиромжтой байдлаар өөрчилнө.

Санхүүгийн тайлангуудад тусгагдсан үйл ажиллагаа, санхүүгийн ажил гүйлгээ ба мэдээлэл нь бүх материаллаг байдлын хувьд хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх талаар хязгаарлалттай баталгаажуулалттай дүгнэлт илэрхийлэхийн тулд санхүүгийн тайланд хийсэн бидний аудитад нэмэлтээр нийцлийн шалгалтыг төлөвлөж, гүйцэтгэсэн.

Аудиторын хүлээх хариуцлага

Бидний хүлээх хариуцлага нь хийсэн шалгалтандаа тулгуурлан дүгнэлт илэрхийлэх явдал юм. Бид шалгалтаа [ИНТОСАИ-н Аудитын үндсэн зарчмууд ба нийцлийн аудитын гарын авлага]-д нийцүүлэн гүйцэтгэлээ. Эдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудыг мөрдөж, санхүүгийн тайлангууд нь материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгааг олж авахын тулд аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Шалгалт нь ихэвчлэн шинжилгээний горимууд ба асуулгуудаар хязгаарлагддаг учир аудитаас бага баталгаажуулалтаар хангадаг. Бид аудит хийгээгүй учраас энэхүү нийцлийн шалгалтын хүрээнд бидний гүйцэтгэсэн хязгаарлагдмал ажилтай нийцэхүйц хязгаарлагдмал баталгаажуулалтын хэлбэрээр дүгнэлт өгнө.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн суурь болоход хангалттай ба зохистой гэдэгт бид итгэж байна.

Нийцлийн талаарх дүгнэлт

Энэ тайланд тусгасан бидний ажил дээр үндэслэн, санхүүгийн тайлангуудад тусгагдсан аудитын явцад бидний анхаарлыг татсан үйл ажиллагаа, санхүүгийн ажил гүйлгээ ба мэдээлэл нь бүх материаллаг байдлын хувьд хууль тогтоомжтой нийцэж байна.

[Эсвэл: Энэ тайланд тусгасан бидний ажил дээр үндэслэн санхүүгийн тайлангуудад тусгагдсан үйл ажиллагаа, санхүүгийн ажил гүйлгээ ба мэдээлэл нь хууль тогтоомжийг зөрчсөн гэж итгэх юу ч бидний анхаарлыг татсангүй.]

[Тохиромжтой бол шалгагдагч байгууллагаас ирүүлсэн хариуг оруулах, жишээлбэл Дүгнэлтийн хэсгийн дараа “Шалгагдагч байгууллагаас ирүүлсэн хариу” гарчиган доор хураангуйгаар, эсвэл тусдаа хавсралтаар]

[Тохиромжтой бол бүтээлч зөвлөмжийг оруулах, жишээлбэл Дүгнэлтийн хэсгийн дараа “Зөвлөмж” гарчгийн доор хураангуйгаар эсвэл тусдаа хавсралтаар]

[Аудиторын гарын үсэг]

[Аудиторын тайлангийн огноо]

[Аудиторын хаяг]

Нийцлийн ажлын мөн чанар, хугацаа ба хэмжээ нь санхүүгийн тайлангуудад үндэслэлтэй баталгаажуулалттай дүгнэлт илэрхийлэхээр төлөвлөгдсөн ажлынхтай харьцуулахад хязгаарлагдмал байна.